



НҮБ-ын Мансууруулах бодис,
гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ БАНГАЛОРЫН ЗАРЧИМ (2002), ТҮҮНИЙ ТАЙЛБАР (2007)

(2001 онд Бангалор хотод Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын багийн баталсан Шүүгчийн ёс зүйн дүрмийн төслийг 2002 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Гааг хотын Энх тайвны ордонд болсон ерөнхий шүүгчдийн дугуй ширээний уулзалтаар дахин хянасан болно)

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ДАА 340
ННА 67
Ш-971

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ БАНГАЛОРЫН ЗАРЧИМ (2002), ТҮҮНИЙ ТАЙЛБАР (2007)

Орчуулагч: Л.Галбаатар

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-баги

Редактор: Н.Эрдэнэцогт

Шүүхийн ёс зүйн хорооны дарга



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada



The Asia Foundation

Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр “Азийн сан”-аас хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд энэхүү “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, түүний тайлбар”-ыг Англи хэлнээс Монгол хэлнээ хөрвүүлж, хэвлэн гаргав.

Цаасны хэмжээ: 148x210

Хэвлэлийн хуудас: 13.1

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ISBN 978-99978-3-936-7

АГУУЛГА

Өмнөх үг	4
Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд	5
Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын тайлбар	21



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ӨМНӨХ ҮГ

Ардчилсан дэглэмтэй дэлхийн аль ч улсад шүүгчийн эрхэм үүрэг нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, шүүн таслах ажиллагааг шударгаар хэрэгжүүлэх, шүүгчийн ёс зүйн өндөр стандартыг чанд баримтлах явдал. Энэ үүднээс эрх зүйн бүл, тогтолцооны ялгаанаас үл хамааран олон орны шүүгчдийн идэвхтэй оролцоо, хүчин чармайлт, мөн НҮБ-ын дэмжлэгээр Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг 2002 онд, тайлбарыг нь 2007 онд тус тус боловсруулж, олон нийтийн хүртээл болгожээ. Өдгөө Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд, түүний тайлбар нь зөвхөн шүүгч, шүүх эрх мэдэлд хязгаарлагдалгүйгээр, шударга ёс, хараат бус шүүх эрх мэдлийн төлөө хүчин зүтгэж байгаа хэн бүхэнд зориулагдсан чухал бүтээл болтлоо хүлээн зөвшөөрөгджээ. Ийм учир энэхүү сонгодог бүтээлийг эх хэлнээ орчуулан хэвлэж, шүүгч, олон түмний хүртээл болгож байгаа юм.

Энэ санал санаачилгыг найрсаар хүлээн авч, тууштай дэмжлэг үзүүлсэн Азийн сангийн хамт олон, бүтээлийг монгол хэл дээр хөрвүүлэх ажилд оюун ухаан, хүч хөдөлмөрөө дайчлан ажилласан тус хүрээлэнгийн судлаач-багш Л.Галбаатар, хянан тохиолдуулсан Шүүхийн ёс зүйн хорооны дарга Н.Эрдэнэцогтод уншигчдын өмнөөс талархлаа илэрхийлье. Энэ бүтээл уншигч таны насан туршийн ширээний ном, судалгааны чухал лавлагаа болно хэмээн найдан өргөн барьж байна.

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ,
СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН



НҮБ-ын Мансууруулах бодис,
гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ БАНГАЛОРЫН ЗАРЧМУУД

2002 он

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ ХЭСЭГ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр тулгасан аливаа эрүүгийн хариуцлага болон эрх үүргээ тодорхойлон тогтоолгохдоо хараат бус, төвийг сахисан шүүхээр эрх тэгш байх үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй гэсэн суурь зарчмыг хүлээн зөвшөөрсөн байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байх, түүнчлэн хүн бүр зохисгүй удаашруулалгүйгээр, шударга, нээлттэй шүүх хуралдаанаар, чадварлаг, хараат бус, төвийг сахисан, хуульд заасан журмын дагуу байгуулагдсан шүүхээр эрүүгийн хариуцлага, иргэний эрх, үүргээ тодорхойлон тогтоолгох ажиллагааг хийлгэх эрхтэй болохыг баталгаажуулжээ.

Дээр дурьдсан суурь зарчмууд, эрхийн талаарх заалтууд нь бүс нутгийн хэмжээний хүний эрхийн баримт бичгүүд, дотоодын үндсэн хууль, салбар хууль, жишгийн эрх зүй, шүүн таслах ажиллагааны зарчмууд болон жишиг тогтоосон шүүхийн шийдвэрүүдэд мөн тусгалаа олж, хүлээн зөвшөөрөгдсөн болно.

Чадварлаг, бие даасан, төвийг сахисан шүүх нь хүний эрхийг хамгаалахад онцгой ач холбогдолтой бөгөөд бүх эрх, эрх чөлөөний хэрэгжилт нь шүүн таслах ажиллагааг зохистой хэрэгжүүлэхээс хамаардаг.

Шүүхүүд үндсэн хуульт болон хууль дээдлэх ёсыг сахиулах үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд чадварлаг, бие даасан, төвийг сахисан байх зайлшгүй шаардлагатай юм.

Шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь орчин үеийн ардчилсан нийгмийн амин сүнс болж байна.

Шүүн таслах ажлыг олон нийтийн зүгээс хүлээлгэсэн итгэл хэмээн ойлгож, дээдлэн хүндэлж, шүүгчид дангаараа болон хамтдаа шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж, бэхжүүлж байх нь зайлшгүй чухал юм.

Шүүгчийн ёс зүйг өндөр хэмжээнд байлгах, түүнийг сайжруулах нь улс бүрийн шүүхийн байгууллагын тэргүүлэх, хүндтэй үүрэг мөн.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэсэн бөгөөд энэ талаар нэн тэргүүнд улс гүрнүүдэд хандсан байдаг.

Дараах зарчмууд нь шүүгчийн ёс зүйн стандартыг тогтоох зорилготой. Эдгээр зарчмууд шүүгчийн ёс зүйг зохицуулах хүрээнд, шүүхээс хийх зүйлийг тодорхойлох, шүүгчдэд зөвлөмж өгөхөд зориулагдсан болно.

Түүнчлэн эдгээр зарчмууд нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын төлөөлөл, хуульчид, олон нийтээс шүүхийг илүү сайн ойлгох, дэмжихэд нь туслах зорилготой юм.

Эдгээр зарчмууд нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг бүхий бие даасан, төвийг сахисан байгууллагын өмнө шүүгчид хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг урьдчилан тогтоож буй бөгөөд өнөөгийн хүчин төгөлдөр хуулиар тогтоосон журам, ёс зүйн хэм хэмжээг үгүйсгэхгүйгээр боловсронгуй болгох зорилготой юм.

ҮНЭТ ЗҮЙЛ 1: БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ

Зарчим:

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь хууль дээдлэх ёс, шүүн таслах ажиллагааг шударгаар хэрэгжүүлэх үндсэн баталгаа, урьдчилсан нөхцөл болдог. Иймд шүүгч нь хувийн амьдралдаа болон албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг байнга хүндэтгэн дээдэлж, өөрөө үлгэр жишээч байвал зохино.

Хэрэглэх нь:

1.1. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг үйл баримтын талаарх өөрийн үнэлэлтэд тулгуурлан, хуулийг ухамсартайгаар ойлгож, оролцогч талуудын шууд ба шууд бус аливаа нөлөө, зүй бус урамшуулал, дарамт шахалт, заналхийлэл, саад тотгоргүйгээр хараат бусаар хэрэгжүүлнэ.

1.2. Шүүгч нь олон нийт болон тухайн хянан шийдвэрлэж буй маргааны оролцогч талуудаас хараат бус байна.

1.3. Шүүгч нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын зүй бус харилцаа холбоо, нөлөөнөөс ангид байх төдийгүй тэдгээрээс үл хамаарах хөндлөнгийн этгээд байна.

1.4. Шүүгч нь албан үүргээ гүйцэтгэж, төвийг сахин шийдвэр гаргахдаа бусад шүүгч, шүүхийн ажилтнаас хараат бус байна.

1.5. Шүүгч нь албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шүүхийн үйл ажиллагааны болон институцийн бие даасан байдлын баталгааг хангах, бэхжүүлэхийг эрмэлзэнэ.

1.6. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах гол тулгуур болох шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхийн тулд, шүүгч нь ёс зүйн өндөр хэм хэмжээг үлгэр жишээчээр даган мөрдөж, өөрийн биеэр батлан үзүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ 2: ТӨВИЙГ САХИХ БАЙДАЛ

Зарчим:

Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэхэд төвийг сахих байдал нь зайлшгүй чухал ач холбогдолтой. Энэ зарчмыг шүүхийн шийдвэрт төдийгүй тухайн шийдвэрийг гаргах зэрэг шүүн таслах ажилд нэгэн адил баримтална.

Хэрэглэх нь:

2.1. Шүүгч нь бусдад давуу байдал олгох, шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүйгээр албан үүргээ хэрэгжүүлнэ.

2.2. Шүүгч нь шүүн таслах ажил төдийгүй шүүхээс гадуурх өөрийн үйл ажиллагаагаар олон нийт, мэргэжлийн хуульчид, шүүх хуралдааны оролцогч талуудаас шүүх болон шүүгчийн төвийг сахих байдалд итгэх итгэлийг хангаж, бэхжүүлнэ.

2.3. Шүүгч нь шийдвэр, шүүн таслах ажлын үндэслэлтэй байдлыг хангаж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй мөрдөх замаар шүүх хуралдаан болон шүүхийн шийдвэр гаргахад шүүгчийг татгалзан гаргах үндэслэл, нөхцөл гаргахгүй байхыг хичээн ажиллана.

2.4. Шүүгч нь өөрөө хянан шийдвэрлэж байгаа, эсхүл өөрт нь хуваарилагдан шийдвэрлэгдэх хэргийн тухайд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд нөлөөлөх бодит магадлалыг бий болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчим болох шударга байдлыг алдагдуулж болохуйц тайлбар, мэдэгдлийг мэдсээр байж хийж болохгүй. Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга байдалд нөлөөлж болох мэдэгдэл, бусад ямар нэгэн тайлбар, ойлголтыг олон нийтэд мэдээлж болохгүй.

2.5. Төвийг сахисан байр сууринаас хэргийг хянан

шийдвэрлэж чадахгүй гэж үзсэн тохиолдолд шүүгч өөрөө үзсэн эсхүл хэн нэгэн энгийн хүнд ингэж харагдахаар байна гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос шүүгч өөрөө татгалзана.

Тухайлбал, дараах зарим тохиолдлыг дээрхэд хамааруулж болох бөгөөд татгалзан гарах үндэслэл үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

2.5.1. Шүүгч хэргийн аль нэг талд шударга бус хандсан, хэт нэг талыг баримталсан хандлага гаргасан, эсхүл хянан шийдвэрлэж байгаа хэргийн үйл баримтын талаар хувийн шугамаар мэдээ, мэдээлэлтэй болсон.

2.5.2. Шүүгч нь тухайн хэрэгт өмнө нь өмгөөлөгчөөр эсхүл гол гэрчээр оролцсон.

2.5.3. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүн нь хэргийн эцсийн шийдвэрийн хувьд эдийн засгийн аливаа сонирхолтой байх.

Тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн өөр бүрэлдэхүүн байхгүй, хэргийг даруй шийдвэрлэх шаардлагатай болсон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх нь шүүн таслах ажилд ноцтой хохирол учруулахаар байвал шүүгч татгалзан гарах шаардлагагүй байж болно.

ҮНЭТ ЗҮЙЛ 3: ШУДАРГА БАЙДАЛ

Зарчим:

Шударга байдал нь шүүхийн үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал ач холбогдолтой.

Хэрэглэх нь:

3.1. Энгийн хүний байр сууринаас харахад, шүүгч нь элдэв шүүмжлэлд өртөхөөргүйгээр шүүгчийн ёс зүйг сахиж, хэвшүүлнэ.

3.2. Шүүгчийн зан байдал, үйл ажиллагаа нь шүүхийн шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг бататган бэхжүүлэхэд чиглэнэ. Шүүхийн үйл ажиллагаа шударга байгаад зогсохгүй, тийнхүү шударга байна гэдгээ батлан харуулах ёстой.

ҮНЭТ ЗҮЙЛ 4: ЗОХИСТОЙ БАЙДАЛ

Зарчим:

Зохистой байдлыг эрхэмлэх, тийнхүү харагдах нь шүүгчийн хийж гүйцэтгэх бүхий л үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.

Хэрэглэх нь:

4.1. Шүүгч өөрийн бүхий л үйл ажиллагаандаа зохисгүй байдал гаргахгүй байж, тийнхүү зохисгүй байдалтай гэж харагдахгүйгээр биеэ авч явбал зохино.

4.2. Шүүгч нь олон нийтийн байнгын хяналтад байдаг тул жирийн хүний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрх, эрх чөлөөг хязгаарласан хэм хэмжээг өөртөө тогтоож, түүнийгээ ямар нэгэн шахалт шаардлагагүйгээр, сайн дураараа хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино.

4.3. Шүүгч нь тухайн шүүхэд тогтмол үйл ажиллагаа явуулдаг хуульчидтай хувийн шугамаар харьцахдаа, хэн нэгэнд ашигтай байдал бий болгосон, нэг талыг барьсан гэх бодит сэжиг, таамаг төрүүлэхээс зайлсхийнэ.

4.4. Шүүгчийн гэр бүлийн гишүүдээс хэн нэгэн нь хэргийн нэг талыг төлөөлөн оролцож байгаа, эсхүл тухайн хэрэгт ямар нэг байдлаар холбоотой тохиолдолд шүүгч хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй.

4.5. Шүүгч нь хэн нэгэн хүн болон хуульчийг үйлчлүүлэгчтэйгээ болон бусадтай уулзахад өөрийн албан өрөө, орон байраа ашиглуулж болохгүй.

4.6. Шүүгч нь бусад иргэний нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг эдлэхдээ шүүхийн өндөр нэр хүнд, бие даасан, төвийг

сахисан байдлыг хүндэтгэн дээдэлж биеэ авч явна.

4.7. Шүүгч нь өөрийн хувийн болон түүнд итгэмжлэгдсэн санхүүгийн ашиг сонирхлын тухайд өөрөө мэдүүлэх, түүнчлэн шүүгчийн гэр бүлийн гишүүдийн санхүүгийн ашиг сонирхлын талаарх мэдээллийг өөртөө авах боломжит арга хэмжээг авна.

4.8. Шүүгч нь түүний гэр бүл, нийгмийн болон өөр бусад харилцаа нь шүүгчийн шүүн таслах ажил, шүүгчийн шийдвэрт зүй бусаар нөлөөлөх байдлыг гаргуулахгүй байх ёстой.

4.9. Шүүгч нь өөрийн болон гэр бүлийн гишүүний, түүнчлэн өөр бусад этгээдийн хувьд давуу байдал бий болгохын төлөө шүүхийн нэр хүндийг ашиглахгүй, тийнхүү ашиглахыг зөвшөөрөхгүй бөгөөд, хэн нэгэнд шүүгчийн нэрийн өмнөөс ийм байдлыг ашиглахыг зөвшөөрөхгүй төдийгүй, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хэн нэгэн хүн зүй бусаар нөлөөлж чадахуйц тийм байдалтай байна гэж бусдад ойлгогдох, тийм сэтгэгдлийг төрүүлэхгүй байх ёстой.

4.10. Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нууц мэдээллийг шүүгчийн албан үүрэгтэй холбоогүй өөр бусад зорилгод ашиглахгүй, задруулахгүй байх ёстой.

4.11. Шүүгч нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулж болно. Үүнд:

4.11.1. Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх болон холбогдох бусад асуудлаарх үйл ажиллагаанд оролцох, багшлах, лекц унших, бүтээл туурвих;

4.11.2. Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх болон холбогдох бусад асуудлаарх төрийн байгууллагын нээлттэй хуралдаан, хэлэлцүүлэгт оролцох;

4.11.3. Улс төрийн хувьд болон бусад асуудлаар төвийг сахисан байр суурьтай байх шүүгчийн ёс зүйд үл харшлах тохиолдолд төрийн байгууллага, засгийн газрын комисс,

хорооны гишүүн байх, зөвлөх багт орж ажиллах;

4.11.4. Шүүхийн нэр хүндэд харшлахгүй, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд саад тотгор болохгүй нөхцөлд өөр бусад үйл ажиллагаанд оролцож болно.

4.12. Шүүгч нь шүүгчээр ажиллаж байх хугацаандаа хуулийн практик үйл ажиллагаа буюу бусдын хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж болохгүй.

4.13. Шүүгч нь шүүгчдийн холбоо байгуулах, түүнд гишүүнээр элсэх, шүүгчийн эрх ашгийг хамгаалах бусад байгууллагад нэгдэх эрхтэй.

4.14. Шүүгч нь өөрөө болон түүний гэр бүлийн гишүүнээр дамжуулан шүүн таслах ажилтай холбоотойгоор аливаа нэг үйлдэл хийсний төлөө буюу хийхийн төлөө, эсхүл хийхгүй байхын төлөө бэлэг, шан харамж, зээл авах, давуу байдал олгохыг хүсэх, түүнчлэн хүлээн авахыг хориглоно.

4.15. Шүүгч нь түүний хамааралд байдаг, түүний чиг үүрэг, эрх мэдлийн хүрээнд хамаарах бусад хүмүүст болон шүүхийн ажилтнуудад шүүн таслах ажиллагаатай холбоотойгоор аливаа нэг үйлдэл хийсний төлөө, хийхээр зорьсон, эсхүл хийгээгүйн төлөө бэлэг, шан харамж, зээл авах, давуу байдал олгохыг хүсэх, түүнчлэн хүлээн авахыг мэдсээр байж зөвшөөрч болохгүй.

4.16. Шүүгч нь тодорхой арга хэмжээнд нийцүүлэн өгч байгаа жижиг бэлэг, шагнал, урамшуулал нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх зорилготой байсан гэх ойлголт төрүүлэхээргүй, түүнчлэн аль нэг талд үйлчилсэн гэх байдал бий болгоогүй тохиолдолд жижиг бэлэг, шагнал, урамшууллыг хуульд заасан тохиолдолд хүлээн авч, хуулиар тогтоосон журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ 5: ТЭГШ БАЙДАЛ

Зарчим:

Шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх нөхцөлийг хангах нь шүүхийн зохистой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.

Хэрэглэх нь:

5.1. Шүүгч нь арьс өнгө, нас хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, бэлгийн хандлага, нийгэм, эдийн засгийн байдал болон өөр бусад байдлаас үүссэн нийгмийн олон талт байдал, ялгааг мэддэг, ойлгодог байвал зохино.

5.2. Шүүгч нь шүүн таслах ажиллагаанд оролцохдоо хэрэгт үл хамаарах үндэслэлээр хэн нэг хүн, хэсэг бүлэг хүмүүст үг хэл, үйл хөдлөлөөрөө шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдлыг гаргаж болохгүй.

5.3. Шүүгч нь шүүн таслах ажиллагаанд оролцохдоо шүүгч, хэргийн оролцогч тал, гэрч, хуульч, шүүхийн ажилтнууд болон шүүхийн бусад этгээдтэй зохистой харьцаж, хэрэгт хамааралгүй, шүүн таслах ажиллагаанд ач холбогдолгүй үндэслэлээр ялгаварлах байдал гаргаж болохгүй.

5.4. Шүүгч нь түүний хамааралд байдаг, түүний чиг үүрэг, хяналтад хамаарах шүүхийн ажилтнууд болон өөр бусад хүний зүгээс, түүний хянан шийдвэрлэж буй хэргийн оролцогч талуудыг хэрэгт хамааралгүй үндэслэлээр ялгаварлах байдал гаргахыг мэдсээр байж зөвшөөрч болохгүй.

5.5. Шүүгч нь шүүхээр хянагдаж байгаа хэргийн хувьд хуульд заасны дагуу ач холбогдолтой, хуулийн дагуу өмгөөллийн зүйл, хэсэг болохоос бусад тохиолдолд шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа хуульчдаас хэрэгт хамааралгүй үндэслэлээр үг хэл, үйл хөдлөлөөрөө шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүй байхыг шаардана.

ҮНЭТ ЗҮЙЛ 6: УР ЧАДВАР БА ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛТЭЙ БАЙДАЛ

Зарчим:

Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэх угтвар нөхцөл нь шүүгч ур чадвартай, хичээл зүтгэлтэй байх явдал мөн.

Хэрэглэх нь:

6.1. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нь шүүгчийн нэн тэргүүний үүрэг юм.

6.2. Шүүгч нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа, шүүхэд шүүн таслах ажиллагаа, түүнтэй холбоотой үүрэг гүйцэтгэх, шийдвэр гаргах болон тэдгээртээ холбоотой бусад асуудалд анхаарал хандуулах зэргээр шүүгчийн албан үүргээ гүйцэтгэхэд зориулна.

6.3. Шүүгч нь шүүгчийн мэдлэг, ур чадвар, хувийн чанарыг дээшлүүлэх, сайжруулах зохих арга хэмжээг тухай бүр авах бөгөөд энэ зорилгоор шүүгчийн албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалт, бусад арга хэрэгслийг зохих ёсоор бүтээлчээр ашиглана.

6.4. Шүүгч нь хүний эрхийн талаарх хэм хэмжээ тогтоосон олон улсын гэрээ, конвенц, баримт бичиг зэрэг олон улсын эрх зүйн хөгжлийн талаар зохих мэдээлэлтэй байхыг эрмэлзэнэ.

6.5. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг үр бүтээлтэй, шударгаар, аль болох хурдан шуурхай шийдвэр гаргахад чиглүүлнэ.

6.6. Шүүгч нь шүүх дэх бүхий л шүүх хуралдааныг зохистой, хэв журамд нийцүүлэн явуулах бөгөөд хэргийн оролцогч талууд, шүүхийн иргэдийн төлөөлөгч, гэрч, хуульч болон шүүгчийн албан үүргийн дагуу харьцаж буй бусад хүнтэй хүлээцтэй, хүндэтгэлтэй, эелдэг, анхааралтай харьцана. Мөн

шүүгч нь түүний хамаарал, чиг үүрэг, хяналтад байдаг бусад хүнийг ийм байдлаар бусадтай харьцаж байхыг шаардана.

6.7. Шүүгч нь шүүх эрх мэдлийг зохистойгоор хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд оролцож болохгүй.

ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Эдгээр зарчмыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл тухайн орны шүүхийн тогтолцоонд байхгүй бол, үндэсний шүүхүүд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн зарчмын дагуу дээрх зарчмуудыг хэрэгжүүлэх үр өгөөжтэй арга хэрэгслийг бий болгох арга хэмжээг батламжилна.

ЗАРЧМУУДЫН НЭР ТОМЪЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Эдгээр зарчмын үг хэллэгийн агуулга нь өөрөөр ойлгож хэрэглэх боломж бий болгосон, эсхүл тийм шаардлагыг бий болгосноос бусад тохиолдолд, зарчмуудын дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“*Шүүхийн ажилтан*” гэж шүүгчийн туслах болон шүүхийн захиргааны ажилтнуудыг ойлгоно.

“*Шүүгч*” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээр томилогдсон буюу сонгогдсон хүнийг ойлгоно.

“*Шүүгчийн гэр бүлийн гишүүн*” гэж шүүгчийн эхнэр/нөхөр, хүү, охин, хүргэн, бэр болон төрөл садан, түүнчлэн шүүгчийн гэрт амьдардаг хүн, шүүгчийн хамтрагч, ажилтан, найз нөхдийг ойлгоно.

“*Шүүгчийн эхнэр/нөхөр*” гэж шүүгчтэй гэр бүлийн харьцаатай хүн, түүнчлэн шүүгчтэй хувийн дотно харьцаатай ямар ч хүйсийн хүнийг ойлгоно.



НҮБ-ын Мансууруулах бодис,
гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ БАНГАЛОРЫН ЗАРЧМУУДЫН ТАЙЛБАР

2007 оны 9 дүгээр сар

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

Өмнөх үг	23
Талархал	26
Төсөл боловсруулсан түүх	27
Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд	47
Удиртгал хэсэг	47
<i>Үнэт зүйл 1: Бие даасан байдал</i>	68
<i>Үнэт зүйл 2: Төвийг сахих байдал</i>	95
<i>Үнэт зүйл 3: Шударга байдал</i>	126
<i>Үнэт зүйл 4: Зохистой байдал</i>	134
<i>Үнэт зүйл 5: Тэгш байдал</i>	180
<i>Үнэт зүйл 6: Ур чадвар ба хичээл зүтгэлтэй байдал</i>	190
Зарчмуудыг хэрэгжүүлэх нь	208
Зарчмуудын нэр томъёоны тодорхойлолт	209
Ном зүй	210

ӨМНӨХ ҮГ

Хараат бус, шударга шүүн таслах ажиллагаа нь ардчилсан ёсыг хангах, хууль дээдлэхэд зайлшгүй шаардлагатай тулгын чулуу юм. Энэ нь бусад бүх хамгаалалт нурсан үед, хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөөний эсрэг чиглэсэн аливаа халдлагаас олон нийтийг хамгаалах хана хэрэм болдог. Энэхүү тайлбар нь тухайн нэг улс төдийгүй дэлхий даяар нэгэн адил хамаатай бөгөөд шүүн таслах ажиллагаа олон улсын хэмжээнд хэрэгжих нь дэлхий нийтэд хууль дээдлэхэд нэг том хамгаалалт болох юм. Тиймээс дэлхий даяар шударга ёсыг хангах нь эрч хүч, ур чадвар, туршлагаа зориулах ёстой үүрэг даалгавар юм.

Үүний төлөө 2000 оноос хойш “Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын бүлэг” (Шүүхийн шударга байдлын бүлэг) хичээн ажиллаж байна. Энэхүү бүлэг нь дэлхийн өнцөг булан бүрээс цугласан Ерөнхий шүүгч, дээд шүүхийн шүүгчдийн туршлага, ур чадварыг нэгтгэн, дээрх эрхэм зорилгод тусгайлан зориулахаар байгуулагдсан албан бус бүлэг юм. Үүнээс хойш тус бүлгийн ажил, ололт амжилт нь дэлхий нийтийн шүүх эрх мэдлийн дүр зурагт чухал нөлөө үзүүлэх хэмжээнд хүрчээ.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг дэлхий даяарх шүүхийн олон салбар төдийгүй, шүүн таслах ажиллагааны шударга байдлыг сонирхсон олон улсын байгууллагууд хүлээн зөвшөөрөх нь нэмэгдэх болов. Үүний үр дүнд, Бангалорын зарчмууд нь бүх шүүхийн байгууллага, эрх зүйн тогтолцооны зүгээс ямар нэг нөхцөлгүйгээр, чөлөөтэй хүлээн зөвшөөрч болох баримт бичиг болсон нь тод харагдаж байна. Товчхондоо, эдгээр зарчим нь бүх соёл, эрх зүйн тогтолцоон дахь шүүхийн чиг үүрэгтэй холбоотой хамгийн дээд уламжлалыг илэрхийлж байна. Тэрхүү үндсэн

зарчмуудын талаар нэгдсэн тохиролцоонд хүрэхэд амаргүй байсан хэдий ч, бүх нийтээр хүлээн зөвшөөрөх заавар бий болгох гэсэн Шүүхийн шударга байдлын бүлгийн тууштай үйл ажиллагаа дээрх замд учирсан саад бэрхшээлийг давах боломжийг олгосон.

Зарим улс Бангалорын зарчмуудыг баталсан төдийгүй, зарим улсын хувьд түүнийг өөрийн орны Шүүгчийн ёс зүйн зарчимд загвар болгон хэрэглэсэн. Мөн тэдгээр улсыг сайшааж олон улсын байгууллагууд, дэмжлэг үзүүлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөл 2006 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 2006/23 тоот тогтоолоороо өөрийн гишүүн орнуудыг шүүгчдэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд, шүүгчдийн мэргэжлийн болон ёс зүйн зан үйлтэй холбоотой дүрмийг шинэчлэх, боловсронгуй болгохдоо Бангалорын зарчмуудыг харгалзан үзэхийг уриалсан. Бангалорын зарчмуудыг НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах алба идэвхтэй дэмжсэн бөгөөд Америкийн Хуульчдын холбоо, Хуульчдын олон улсын комисс зэрэг байгууллага хүлээн зөвшөөрсөн. Мөн Европын Зөвлөлийн гишүүн орнуудын шүүгчид Бангалорын зарчмуудыг дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Бангалорын зарчим бүрийн дэлгэрэнгүй тайлбарын төслийг зарчимтай нь хамт 2007 оны 3 дугаар сарын 1-2-ны өдөр Вена хотноо зохион байгуулагдсан Шүүгчийн ёс зүйн суурь зарчмуудыг бэхжүүлэх талаарх Засгийн газар хоорондын шинжээчдийн бүлгийн чөлөөт хурал дээр бэлтгэж, нарийвчлан хэлэлцсэн. Энэ хуралд 35 гаруй орны төлөөлөгчид оролцсон юм. Мөн Шүүхийн шударга байдлын бүлгийн тав дахь хурал дээр тайлбарын төсөл болон түүнд санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг нарийвчлан авч үзсэн. Эдгээр хурлаас Бангалорын зарчмууд болон түүний нэмэлт тайлбаруудыг баталсан бөгөөд ингэснээр тэдгээр баримт бичгийн ач холбогдол, хүчин

чадал улам нэмэгдсэн. Тайлбар нь Бангалорын зарчмуудыг гүнзгийрүүлж, бэхжүүлж буй бөгөөд цаашид тус зарчмуудыг шүүгчийн ёс зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн тунхаг болгон дэлхий даяар батлахад чухал хувь нэмэр оруулж байна.

Эрх зүйн бүх уламжлалт тогтолцоо шүүхээс шударга байдлын дээд зэргийн стандартыг шаарддаг бөгөөд үүнд дэлхийн бүх томоохон шашны үйл ажиллагаа чиглэдэг гэдгийг хэлэх нь зүйтэй. Үүнийг хүлээн зөвшөөрч, тус тайлбар бүтээлд шүүхийн шударга байдлын талаарх шашны сургаалын товч тоймыг хавсралтаар оруулсан болно.

Бидний хувьд, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллагад хамаарах үнэт зүйл, хэрэгсэл гэж хязгаарлахгүйгээр, олон нийт болон дэлхий дээрх шударга шүүх эрх мэдлийн төлөө байгаа хэн бүхэнд зориулав.

К. Г. ВИРАМАНТРИ

Шүүхийн шударга байдлын бүлгийн ахлагч

ТАЛАРХАЛ

НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албаны зүгээс шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудын тайлбарын төслийг бэлтгэсэн төдийгүй Вена хот дахь НҮБ-ын байранд 2007 оны 3 дугаар сарын 1-2-ны өдөр зохион байгуулагдсан “Шүүгчийн ёс зүйн суурь зарчмуудыг бэхжүүлэх талаарх Засгийн газар хоорондын шинжээчдийн бүлэг”-ийн чөлөөт хуралд идэвхтэй оролцсон шүүхийн шударга байдлын бүлэгт талархал илэрхийлье.

Түүнчлэн Бангалорын зарчмуудын тайлбарын төслийг бэлтгэх, судалгаа хийх ажлыг санхүүжүүлсэн Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага (GTZ) болон дээр дурдсан шинжээчдийн бүлгийн хуралд дэмжлэг үзүүлсэн Норвеги, Швед улсын Засгийн газарт тус тус онцгойлон талархал илэрхийлье.

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН ТҮҮХ

I. Урьдчилсан нөхцөл

2000 оны 04 дүгээр сард Олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Төвийн санаачилгаар, Авлигын эсрэг олон улсын хөтөлбөрийн хүрээнд, НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх асуудлаарх 10 дугаар чуулгантай хамтран Вена хотноо Ерөнхий шүүгч, ахлах шүүгчдийн бүлгийн урьдчилсан хурал хуралдсан. Тус хурлын үйл ажиллагаа нь энэ дэлхийн ихэнх улсад авлига зэрэг олон хүчин зүйлээс болж шүүхийн тогтолцоонд олон хүн итгэхээ больсон талаарх асуудалд чиглэж байв. Энэ асуудал нь шүүхээр үйлчлүүлсэн олон нийтийн судалгаа, төсөөллийн судалгаа, төрөөс байгуулсан судалгаа, дүн шинжилгээний комиссын үйл ажиллагааны үр дүн зэргээр нотлогдож байв. Үүнтэй холбоотой олон шийдлийг санал болгож, зарим шинэтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлж үзсэн ч асуудал хэвээр оршсоор байв. Дээрх хурлаар асуудлыг шинэ хандлагаар шийдвэрлэх зорилготой байв. Энэ бол шүүгчдийг НҮБ-ын ивээл дор түүний байранд ээлж дараалан урьж шүүхийн бие даасан байдлын зарчмыг хэрэгжүүлэхэд шүүгчийн хариуцлагын тухай ойлголтыг хөгжүүлэх, улмаар хууль дээдлэх ёсонд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн анхны тохиолдол байсан. Эхний шатанд, энэ дэлхийд эрх зүйн өөр өөр уламжлалтай орнууд оршин тогтнож буйг хүлээн зөвшөөрч, зөвхөн нийтлэг эрх зүйн бүл /Англи-Америкийн эрх зүйн систем/-д түшиглэхгүйгээр шийдвэрлэсэн. Үүний дагуу, Ази, Африк болон Хойд Номхон далайн төлөөлөл болсон есөн орноос ирсэн эхний оролцогчид олон тооны өөр хуулийг хэрэглэж, шүүхийн нийтлэг уламжлалаасаа хуваалцсан.

II. Шүүхийн шударга байдлын бүлэг

Шүүхийн шударга байдлын бүлэг гэх нэрээр танигдсан Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын бүлгийн анхны хурал 2000 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдөр Вена хот дахь НҮБ-ын байранд болсон. Энэхүү хуралд Бангладешийн ерөнхий шүүгч Латифур Рахман, Энэтхэгийн Карнатака мужийн ерөнхий шүүгч Ю. Бхаскар-Рао, Непалийн ерөнхий шүүгчийг төлөөлөн тус улсын шүүгч Говинд Бахадур Шреста, Нигерийн ерөнхий шүүгч М.Л. Увай, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүхийн дэд ерөнхийлөгч Пий Ланга, Бүгд найрамдах нэгдсэн Танзани улсын ерөнхий шүүгч Ф.Л. Нилали, Угандагийн Шүүхийн үйлчилгээний комиссын тэргүүн, шүүгч Б.Ж. Одоки нар оролцсон. Эдгээр оролцогчийн уулзалтыг Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгч, шүүгч Кристофер Грегори Виранантри удирдан явуулсан. Австралийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Майкл Кирби тус хуралд илтгэгчийн үүрэгтэйгээр оролцсон. Харин Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч Дато Парам Кумарасвами, Олон улсын шүүгчдийн холбооны дэд ерөнхийлөгч, шүүгч, доктор Эрнст Маркел, доктор Жузеппе ди Женнаро нар ажиглагчаар оролцсон.

Хурлаар Шүүхийн шударга байдлын бүлэг хоёр шийдвэр гаргасан. Нэгдүгээрт, хариуцлагатай байдлын зарчим нь, шүүхийн эрх хэмжээ, чадавхын хүрээнд, тогтолцооны шинэтгэлийг бий болгох замаар, шүүхийн шударга байдлыг бэхжүүлэхэд үндэсний шүүх эрх мэдлийн байгууллагаас идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг шаарддаг болохыг зөвшөөрсөн. Хоёрдугаарт, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцсэн, бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөхүйц шүүхийн стандартууд нэн яаралтай хэрэгцээтэй байгааг хүлээн зөвшөөрсөн. Ингэхдээ энэхүү стандартууд нь, үндэсний төвшинд шүүх эрх мэдлийн байгууллагаас гүйцэтгэх

болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын хөндлөнгийн нөлөөгүйгээр, хүндэтгэн сахиж, заавал дагаж мөрдөхүйц байх ёстой гэж үзсэн. Шүүгчийн ёс зүйн зохих стандартыг батлах, нийт шүүгчдэд мөрдүүлэх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хадгалахад чухал ач холбогдолтой алхам болохыг хуралд оролцогч шүүгчдийн зүгээс онцлон тэмдэглэв. Үүний дагуу, тэдгээр шүүгчийн зүгээс шүүгчийн ёс зүйн батлагдсан дүрмүүдийг шинжлэн судалж, үр дүнг тайлагнахыг Шүүхийн шударга байдлын бүлгийн зохицуулагч Нихал Жэйнжикрамаас хүссэн. Ингэхдээ а) тэдгээр ёс зүйн дүрэмд давтагдаж буй үндсэн асуудлыг тодорхойлох, б) тэдгээр дүрэм дэх зохицуулалт нь бүх улсад үүсэхгүй хэдий ч, тухайлсан нэг улсын хувьд батлан мөрдүүлэхэд тохирох эсэх асуудлыг тодорхойлохыг даалгасан байна.

III. Эх сурвалж

Дээр дурдсан шийдвэрийн дагуу Шүүгчийн ёс зүйн дүрмийн төслийг бэлтгэх явцад дараах дүрэм, олон улсын баримт бичиг болон бусад эх сурвалжийг шинжлэн судалжээ. Үүнд:

Үндэсний дүрмүүд:

- 1) Америкийн хуульчдын холбооны Төлөөлөгчдийн танхимаас баталсан Шүүгчийн ёс зүйн дүрэм, 1972 оны 08 дугаар сар.
- 2) Австралийн муж улс болон нутаг дэвсгэрийн Ерөнхий шүүгчдийн гаргасан Шүүхийн бие даасан байдлын зарчмуудын талаарх тунхаглал, 1997 оны 04 дүгээр сар.
- 3) Ардын Бүгд Найрамдах Бангладеш улсын Үндсэн хуулийн 96(4)(а) зүйлийн дагуу Шүүхийн дээд зөвлөлөөс тогтоосон Бангладешийн Дээд шүүхийн шүүгчдийн ёс зүйн дүрэм, 2000 оны 5 дугаар сар.

- 4) Канадын шүүгчдийн зөвлөгөөнөөс хамтран боловсруулж, Канадын шүүхийн зөвлөлөөс сайшаасан Шүүгчдийн ёс зүйн зарчмууд, 1998 он.
- 5) Айдахогийн Шүүгчийн ёс зүйн дүрэм, 1976 он.
- 6) Энэтхэгийн ерөнхий шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан Шүүгчийн амьдралын үнэт зүйлс, 1999 он.
- 7) Айовагийн Шүүгчийн ёс зүйн дүрэм.
- 8) Кенийн шүүхийн ажилтнуудын ёс зүйн дүрэм, 1999 оны 07 дугаар сар.
- 9) Малайзын холбооны Үндсэн хуулийн 125(3А) дугаар зүйлийн дагуу, ерөнхий шүүгчид, давж заалдах шатны шүүхийн ерөнхийлөгч, дээд шүүхүүдийн ерөнхий шүүгчдийн зөвлөмжийн дагуу, хааны тогтоосон Малайзын шүүгчдийн ёс зүйн дүрэм, 1994.
- 10) Намибийн Магистратуудын ёс зүйн дүрэм.
- 11) АНУ-ын Нью-Йорк мужийн Шүүгчийн ёс зүйг зохицуулах дүрмүүд.
- 12) Нигерийн холбооны бүгд найрамдах улсын Шүүхийн ажилтнуудын ёс зүйн дүрэм.
- 13) Пакистаны давж заалдах шатны шүүх болон дээд шүүхийн шүүгчдийн мөрдөж буй Ёс зүйн дүрэм.
- 14) Филиппиний Шүүгчийн ёс зүйн дүрэм, 1989 оны 09 дүгээр сар.
- 15) Филиппиний Хуульчдын холбооноос санал болгож, Манилагийн анхан шатны шүүхийн шүүгчид зөвшөөрч, дээд шүүхийн захиргааны хяналт дор хотын болон орон нутгийн шүүхийн шүүгчид зэрэг бүх шүүгчид удирдамж болгон баталсан Филиппиний шүүгчийн ёс зүйн зарчмууд, 1946 оны 8 дугаар сар.
- 16) Соломоны арлууд дахь Шүүхийн бие даасан байдлын зарчмууд, 2000 оны 11 дүгээр сар.

- 17) Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгч, ерөнхий шүүгч болон дээд шүүхийн ерөнхийлөгч, хөдөлмөрийн давж заалдах шатны шүүхийн ерөнхийлөгч, Газрын нэхэмжлэлийн шүүхийн ерөнхийлөгч нарын гаргасан Өмнөд Африкийн Шүүгчдийн удирдамж, 2000 оны 03 дугаар сар.
- 18) Шүүгчид болон магистратуудын зөвлөгөөнөөс баталсан Танзани улсын Шүүхийн ажилтнуудын ёс зүйн дүрэм, 1984 он.
- 19) Техас мужийн Шүүгчийн ёс зүйн дүрэм.
- 20) Дээд шүүхийн болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн баталсан Угандагийн Шүүгч, магистрат, шүүхийн бусад ажилтны ёс зүйн дүрэм, 1989 оны 7 дугаар сар.
- 21) АНУ-ын Шүүгчдийн зөвлөгөөний Ёс зүйн дүрэм.
- 22) Виржинийн дээд шүүхийн баталж, тунхаглан зарласан Виржинийн улсуудын холбооны Шүүгчийн ёс зүйн зарчмууд, 1998 он.
- 23) АНУ-ын Вашингтон муж улсын дээд шүүхийн баталсан Шүүгчийн ёс зүйн дүрэм, 1995 оны 10 дугаар сар.
- 24) Замби улсын парламентын баталсан Шүүхийн (ёс зүйн) хууль, 1999 оны 12 дугаар сар.

Бүс нутгийн болон олон улсын баримт бичгүүд:

- 1) Эрүүгийн эрх зүйн олон улсын холбоо, Олон улсын хуульчдын комисс болон шүүгч, хуульчдын бие даасан байдлын төвийн хамтын шинжээчдийн хорооноос боловсруулсан Шүүхийн бие даасан байдлын зарчмуудын төсөл (Сиракусын зарчмууд), 1981 он.
- 2) Олон улсын хуульчдын холбооноос баталсан Шүүхийн бие даасан байдлын наад захын стандартууд, 1982 он.

- 3) НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас сайшаасан Шүүхийн бие даасан байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд, 1985 он.
- 4) Шүүхийн бие даасан байдлын талаарх судалгааны үндсэн дээр НҮБ-ын Тусгай илтгэгч доктор В.Л. Сингхвигийн бэлтгэсэн Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай бүх нийтийн тунхаглалын төсөл (Сингхвигийн тунхаглал), 1989 он.
- 5) Ерөнхий шүүгчдийн 6 дугаар зөвлөгөөнөөс баталсан Ази, номхон далайн бүс нутаг дахь Шүүхийн бие даасан байдлын зарчмуудын тухай Бээжингийн мэдэгдэл, 1997 оны 08 дугаар сар.
- 6) Сайн засаглал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг дэмжих талаарх Харарегийн зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор төрийн гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн хоорондын харилцааг зохистой удирдах улсуудын холбооны сайн туршлагын талаарх Латимэр Хаусын удирдамж, 1998 он.
- 7) Европын зөвлөлөөс баталсан Шүүгчдийн эрх зүйн байдлын талаарх Европын дүрэм, 1998 оны 07 дугаар сар.
- 8) Бие даасан шүүгч, хуульчдын төвийн мэргэжилтнүүдийн бүлгээс баталсан Авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон шүүхийн тогтолцооны шударга байдлыг хангах талаарх бодлогын хүрээ, 2000 оны 02 дугаар сар.

IV. Шүүгчийн ёс зүйн Бангалорын дүрмийн төсөл

Шүүхийн шударга байдлын бүлгийн хоёрдугаар хурал 2001 оны 02 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Энэтхэгийн Бангалорт болсон. Энэ хурлыг Энэтхэгийн Карнатака мужийн Дээд шүүх болон мужийн захиргаанаас зохион байгуулж, ИБУИНВУ-ын Олон улсын хөгжлийн газраас хамтран зохион байгуулагчаар ажилласан бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас дэмжин ажиллажээ. Тус бүлгийн хурлаар, өмнө нь бэлтгэсэн төслийг нягтлан боловсруулах замаар үндсэн үнэт зүйлсийг тодорхойлж, холбогдох зарчмыг томъёолж, Шүүгчийн ёс зүйн дүрмийн Бангалорын төслийг (Бангалорын төсөл) дэмжжээ. Шүүхийн шударга байдлын бүлгээс ийнхүү хүлээн зөвшөөрсөн ч, Бангалорын төслийг анхнаас нь нийтлэг эрх зүйн бүл /Англи-Америкийн эрх зүйн бүл/-ийн шүүгч нар боловсруулсан тул, шүүгчийн ёс зүйн олон улсын дүрэм болохынх нь хувьд Бангалорын төслийг эрх зүйн бусад уламжлал бүхий орны шүүгчид нягтлан шалгаж, зөвшөөрч, баталгаажуулах нь нэн чухал байв.

Энэхүү хуралд Бангладешийн ерөнхий шүүгч Майнур Рейз Чоуххури, Энэтхэгийн Карнатака мужийн ерөнхий шүүгч П.В. Редди, Непалийн ерөнхий шүүгч Кешав Прасад Упадхай, Нигерийн ерөнхий шүүгч М.Л. Увай, Өмнөд Африкийн ерөнхий шүүгчийн орлогч Пий Ланга, Шри-Ланкийн ерөнхий шүүгч С.Н. Силва, Бүгд найрамдах нэгдсэн Танзани улсын ерөнхий шүүгч Б.А. Самата, Угандагийн ерөнхий шүүгч Б.Ж. Одоки нар оролцсон. Мөн Канадын Дээд шүүхийн шүүгч бөгөөд Хуульчдын олон улсын комиссын ерөнхийлөгч Клэр Лероу Дубе хүндэт зочноор оролцсон. Харин шүүгч Вирамантри хурал даргалагчаар, шүүгч Кирби илтгэгчийн үүрэгтэйгээр тус тус оролцсон. Түүнчлэн, Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч Дато Парам Кумарасвами, НҮБ-ын Хүний эрхийн хорооны тэргүүн болон

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрыг төлөөлөн шүүгч П.Н. Бхагавати нар тус тус ажиглагчаар оролцсон.

V. Зөвлөлдөх үйл явц

Үүний дараа, Бангалорын төслийг хорин сарын хугацаанд нийтлэг эрх зүйн бүл болон иргэнлэг эрх зүйн бүлийн аль алиных нь шүүгчдийн дунд өргөн хүрээнд хэлэлцүүлсэн. Тухайлбал, тус төслийг нийтлэг эрх зүйн болон иргэнлэг эрх зүйн бүлийн аль алиных 75 гаруй орны ерөнхий шүүгч, ахлах шүүгчдийн оролцсон хэд хэдэн удаагийн шүүгчдийн зөвлөгөөн, хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн. Мөн Америкийн хуульчдын холбооны Төв болон Зүүн Европ дахь салбарын санаачилгаар, Бангалорын төслийг Босни-Герцеговин, Болгар, Хорват, Румын, Серби, Словак зэрэг улсуудын үндэсний хэлээр орчуулж шүүгчид, шүүгчдийн холбоод, Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүхүүд хянан үзэж, санал өгсөн. Тэдгээр санал ихээхэн үнэ цэнтэй байв.

2002 оны 06 дугаар сард Францын Страсбург хотноо болсон хурлаар, Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн Ажлын хэсэг иргэнлэг эрх зүйн тогтолцооны үүднээс бүхэлд нь нээлттэй хэлэлцэж, Бангалорын төслийг бүхэлд нь хянан үзсэн. Энэхүү хуралд Австри улсын Шүүгчдийн холбооны дэд ерөнхийлөгч Герхард Рейзнер, Чех улсын давж заалдах шатны шүүхийн шүүгч Роберт Фремр, Франц улсын Парис хот дахь давж заалдах шатны шүүхийн шүүгч Ален Лакбарсат, ХБНГУ-ын Холбооны Захиргааны хэргийн шүүхийн шүүгч Отто Маллманн, Итали улсын магистрат Рафаэл Сабато, Литва улсын давж заалдах шатны шүүхийн шүүгч Виргил, Люксембургийн давж заалдах шатны шүүхийн тэргүүн зөвлөх Жан-Клод Вивиниус, Португал улсын давж заалдах шатны шүүхийн зөвлөх шүүгч Орланд Афонсо, Словени улсын дээд шүүхийн шүүгч Душан Огризек, Швед улсын давж заалдах

шатны шүүхийн ерөнхийлөгч Иохан Хирсфелдт, ИБУИНВУ-ын Тэргүүн шүүгч Мэнсон нар оролцсон. Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн Ажлын хэсгээс хэвлүүлсэн Бангалорын төслийн талаарх саналын эмхэтгэл болон Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжүүд, ялангуяа шүүхийн бие даасан байдлын стандартын талаарх 1 дүгээр зөвлөмж нь Бангалорын төслийг боловсронгуй болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан.

Улмаар, Бангалорын төслийг Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн боловсруулсан шүүгчийн мэргэжлийн зан үйл, ёс зүйг зохицуулж буй зарчим, дүрмийн талаарх зөвлөмжийн төсөл болон 2002 оны 6 дугаар сард Австралийн ерөнхий шүүгчдийн зөвлөлөөс хэвлүүлсэн Шүүгчийн ёс зүйн удирдамж, Балтийн улсуудын Шүүгчийн ёс зүйн загвар дүрэм, БНХАУ-ын Шүүгчийн ёс зүйн дүрэм, Македонийн шүүгчдийн холбооны Шүүгчийн ёс зүйн дүрэм зэрэг тухайн үеийн шинээр боловсруулсан шүүгчийн ёс зүйн эх сурвалжийг тус тус харгалзан үзэж, шинэчилсэн.

VI. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд

Бангалорын төслийн шинэчилсэн хувилбарыг, Олон улсын шүүх байрладаг Нидерландын Гааг хот дахь Энхтайвны ордны Японы өрөөнд 2002 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан иргэнлэг эрх зүйн орнуудын ерөнхий шүүгчид, тэдгээрийн төлөөлөгчдийн дугуй ширээний уулзалтын өмнө бэлэн болгосон. Тус уулзалтыг Женев дэх НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар болон Вена дахь Олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Төвийн дэмжлэгтэйгээр, ИБУИНВУ-ын Олон улсын хөгжлийн газраас Гааг дахь Карнеги сангийн ерөнхий захирлын тусалцаатайгаар хамтран зохион байгуулжээ.

Тус уулзалтыг өмнө нь Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгч, орон тооны бус шүүгчээр ажиллаж байсан Виранттри шүүгч даргалж, бусад шүүгч оролцжээ. Тодруулбал, тус уулзалтад Бразилын холбооны давж заалдах шатны шүүхийн шүүгч Владимир де Фрайти, Бүгд найрамдах Чех улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч Ива Брзова, Египетийн Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгч Мохаммед Фати Нажма (шүүгч, доктор Адель Омар Шерифийн туслалцаатайгаар), Францын Кастацийн шүүхийн зөвлөх Кристин Чанет, Мексикийн Дээд шүүхийн ерөнхийлөгч Женару Дэвид Гонора Пимимел, Мозамбик улсын Дээд шүүхийн ерөнхийлөгч Марио Магува, Нидерландын Дээд шүүхийн ерөнхийлөгч Пим Хаак, Норвегийн Дээд шүүхийн шүүгч Тронд Долва, Филиппиний Дээд шүүхийн ерөнхий шүүгч Илариу Давиде (шүүгч Рейнато С. Пуногийн туслалцаатайгаар) нар оролцсон. Мөн тус уулзалтын нэг салбар хуралдаанд Олон улсын шүүхийн шүүгчид оролцжээ. Тодруулбал, Олон улсын шүүхийн шүүгч Раймон Ранджева (Мадагаскар), шүүгч Геза Херцег (Унгар), шүүгч Карл-Август Флейшхауэр (Герман), шүүгч Абдул Г. Корума (Сьерра-Леоне), шүүгч Розалин Хиггинс (ИБУИНВУ), шүүгч Франсиско Резек (Бразил), шүүгч Набиль Элараби (Египет), орон тооны бус шүүгч Томас Франк (АНУ) нар дээрх уулзалтад оролцжээ. Үүнээс гадна, Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч Дато Парам Кумарасвами тус уулзалтад байлцжээ.

Дээрх уулзалтад оролцсон нийтлэг болон иргэнлэг эрх зүйн тогтолцоотой орны шүүгчид суурь үнэт зүйлсийн асуудлаар тохиролцоонд хүрсэн хэдий ч, бүтэц болон үнэт зүйлийг хэрхэн дараалалд оруулах талаар тохиролцсонгүй. Тухайлбал,

- 1) “бие даасан, хараат бус байдал”, “төвийг сахих байдал”, “шударга байдал”-ыг “зохистой байдал” (Бангалорын

төслийн эхэнд байсан) болон “тэгш байдал”-ын өмнө байршуулах эсэх дээр асуулт гарсан.

- 2) иргэнлэг эрх зүйн шүүгчдийн зүгээс, мэргэжлийн зан үйлийн стандарт нь хууль тогтоомж, сахилгын дүрмээс өөр тул “дүрэм” гэх үгийг хэрэглэх саналаа илэрхийлсэн (Европын хуулийн мэргэжилтнүүдийн хувьд дүрмийг ихэвчлэн тухайн харилцааг бүрэн гүйцэд зохицуулсан хууль зүйн хэрэгсэл гэж ойлгодог).
- 3) Бангалорын төслийн оршил хэсэг дэх “шүүх эрх мэдлийн жинхэнэ эх сурвалж нь олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны эрх мэдэл болон шүүхийн шударга байдал юм” гэсэн хэсэгт асуулт гарсан. Ингэхдээ “жинхэнэ эх сурвалж” бол Үндсэн хууль бөгөөд шүүх эрх мэдлийг нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар хэмжих нь зарим тохиолдолд аюултай байж магадгүй гэх зэргээр мэтгэлцсэн.

Үнэт зүйл болон зарчмыг хэрэглэхтэй холбоотойгоор иргэнлэг эрх зүйн шүүгчид:

- 1) яагаад шүүгчид өөрсдийн гэр бүлийн санхүүгийн ашиг сонирхлыг өөрсдөө мэдэгдэх нийтлэг үүрэгтэй байх ёстой вэ? (Бангалорын төсөлд ийм үүрэг хүлээлгэсэн) гэх асуулт гарч, энэ нөхцөл нь шүүгчийн үйл ажиллагаа, шударга байдалд учрах аливаа боломжит эрсдэлтэй хамааралгүй гэж үзсэн.)
- 2) хэрэв шүүгч тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэх чадваргүй бол шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзахын оронд, талууд зөвшөөрсөн тохиолдолд үргэлжлүүлэх (нийтлэг эрх зүйн шүүгчид ийм нөхцөлийг зөвшөөрч болно гэх хандлагатай байсан) нь зохисгүй гэж үзсэн.
- 3) Бангалорын төсөлд бусад хуульчтай гэр бүл байх, хувийн ойр харилцаатай байх гэх мэт харьцангуй

нийтлэг нөхцөлийг өргөн хүрээнд зохицуулах гэсэн нь зохистой эсэх тал дээр асуулт гарсан бөгөөд тухайн нэг хэрэгт анхаарал хандуулж харилцааг хориглохын оронд, өөрийн ойр дотны хүнтэй бусад этгээд хувийн харилцаатай тохиолдолд шүүгч тухайн хэргийг шийдвэрлэхээс татгалзах нөхцөлийг санал болгосон.

- 4) шүүгчид “зөвшөөрөгдсөн” эрх зүйн бус үйл ажиллагааны жагсаалт оновчтой эсэх дээр асуулт гарсан. Буяны байгууллагын өмнөөс хөрөнгө босгох, өв хөрөнгийн харилцаанд гүйцэтгэгч, зохион байгуулагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, асран хамгаалагч, бусад харгалзан дэмжигчийн үүрэг гүйцэтгэх, судалгаа шинжилгээний комисст томилсныг зөвшөөрөх, гэрчийн хувиар мэдүүлэг өгөх ёсгүй гээд, үүнийг олон улсын стандартаар ерөнхийдөө зөвшөөрдөг гэж үзсэн.

Гол ялгаатай байр суурь нь шүүгчийн улс төрийн үйл ажиллагаатай холбоотой асуудал байв. Европын нэг оронд шүүгч намын гишүүнчлэлийнхээ үндсэн дээр сонгогддог. Европын зарим оронд, шүүгч улс төрд оролцох эрхтэй бөгөөд орон нутгийн зөвлөлийн гишүүнээр сонгогдох (шүүгчийн албан үүргээ хэвээр хадгална), парламентын гишүүнээр сонгогдох (энэ тохиолдолд шүүгчийн албан тушаалаас түдгэлзүүлдэг) боломжтой. Тиймээс иргэнлэг эрх зүйн шүүгчдийн зүгээс, өнөөгийн нөхцөлд шүүгч улс төрд чөлөөтэй оролцож болох эсэх талаар олон улсын хэмжээнд нийтлэг зөвшилцөл байхгүй гэж үзсэн. Тэдний хувьд улс бүр нийгмийн амьдралтай холбоотой асуудлаар, шүүгчид хоорондоо үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрхэн тэнцвэртэйгээр зохицуулах эсэхээ өөрсдөө шийдэх нь зүйтэй бөгөөд энэ талаарх шаардлагыг хатуу тогтоохгүйгээр, төвийг сахисан байдлаар тогтоохыг санал болгосон. Тэдний хувьд, шүүгчдийн

улс төрийн намын гишүүнчлэл, нийгмийн суурь асуудалтай холбоотой олон нийтийн мэтгэлцээн дэх оролцоог хориглохгүй байхыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч, шүүгчид түүний хараат бус, шударга байдалд нөлөөлөх эрсдэлтэй улс төрийн аливаа үйл ажиллагаанаас татгалзах ёстой гэж үзсэн.

Ийнхүү тус уулзалтаар Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг тогтоосон. Тус баримт бичигт бие даасан, хараат бус байдал, шударга байдал, төвийг сахих байдал, зохистой байдал, тэгш байдал, ур чадвар, хичээл зүтгэлтэй байдал гэсэн суурь үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр үнэт зүйлс нь холбогдох зарчим, тэдгээрийг хэрэглэх нарийвчилсан хэсэгтэйгээр баталгаажсан.

VII. Хүний эрхийн комисс

2003 оны 04 дүгээр сард Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч Дато Парам Кумарасвами НҮБ-ын Хүний эрхийн комиссын 59 дүгээр чуулганд танилцуулсан тайландаа Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг хавсралтаар танилцуулсан. 2003 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр НҮБ-ын Хүний эрхийн комиссоос санал нэгтгэйгээр баталсан 2003/43 тоот тогтоолд, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг цохон тэмдэглэж, тэдгээр зарчмыг “Гишүүн орнууд анхааралдаа авч, НҮБ-ын холбогдох байгууллагууд, засгийн газар хоорондын болон засгийн газрын бус байгууллагууд анхаарч үзэх”-ийг даалгасан.

2004 оны 04 дүгээр сард Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч доктор Леандро Деспуй Хүний эрхийн комиссын 6 дахь чуулганы тайланд танилцуулсан тайландаа “... *Зарим оронд олон нийтийн зүгээс шүүхийг авлигажсан байгууллага гэж үзэх хандлагатай байгаа нь шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг алдагдуулах ноцтой асуудал юм. Энэ асуудлын шийдэлд шүүгчийн ёс*

зүйн дүрмүүд нэн чухал ач холбогдолтой. Европын Хүний эрхийн шүүхийн онцолсноор, шүүгчид шударга байдлын бодит шалгуур үзүүлэлтийг хангахаас гадна бодит байдал тийнхүү шударга гэж харагдаж байх ёстой. Тиймээс эрх зүйн хоёр гол уламжлал (занилын эрх зүй болон иргэнлэг эрх зүй)-ын төлөөлөл өөрсдөө хамтран бэлтгэж, Хүний эрхийн комиссын 59 дүгээр чуулганаас сайшаасан Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудыг түгээж, түүнийг хэрэгжүүлэх яагаад чухал болохыг эндээс харж болно.” гэж тэмдэглэжээ.

Ийнхүү НҮБ-ын тусгай илтгэгчийн зүгээс, Бангалорын зарчмуудыг бүх хууль зүйн сургууль, шүүгч, хуульчдын мэргэжлийн холбоодод орчуулан хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлэхийг зөвлөсөн.

VIII. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар

Шүүгч, хуульч, хууль сахиулагчдын оролцсон хэд хэдэн хурлаар, Бангалорын зарчмуудыг хэрэглэхэд зохих зааварчилга бүхий тайлбар буюу гарын авлага хэрэгцээтэй байгаа талаар онцолсныг 2005 оны 10 дугаар сард Вена хотноо болсон Шүүхийн шударга байдлын бүлгийн 4 дүгээр хурлаар цохон тэмдэглэжээ. Тус бүлгээс, тэрхүү тайлбар буюу гарын авлага нь шүүгч болон шүүгчийн ёс зүй заадаг багш нарт Бангалорын зарчмуудыг бүрэн ойлгоход чухал шаардлагатай төдийгүй тэдгээр зарчим, үнэт зүйлсийг цаашид үүсэж болох аливаа асуудал, нөхцөл байдалд тохируулан өргөн хүрээнд хэрэглэхэд ач холбогдолтой болохыг зөвлөсөн байна. Үүний дагуу, тус бүлгээс эхний ээлжид, бүлгийн Зохицуулагчийн зүгээс тайлбарын төслийг бэлтгэж, бүлэгт танилцуулах, түүнийг бүлгийн зүгээс хянан хэлэлцэж батлахаар шийдсэн.

IX. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийн шүүхийн асуудлаарх Комисс

2006 оны 04 дүгээр сард Вена хотноо хуралдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийн шүүхийн асуудлаарх Комиссын 15 дугаар чуулган болж, “Шүүгчийн ёс зүйн үндсэн зарчмуудыг бэхжүүлэх тухай” тогтоолын төслийг батлахыг Эдийн засаг, нийгмийн зөвлөлд санал нэгтгэйгээр зөвлөсөн. Энэхүү тогтоолын төслийг Египет, Франц, Герман, Нигер, Филиппиний засгийн газар хамтран боловсруулсан. Тус тогтоолын төсөлд дараах зүйлийг тусгасан. Үүнд:

- 1) Гишүүн орнуудыг шүүгчдэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд, шүүгчдийн мэргэжлийн болон ёс зүйн зан үйлтэй холбоотой дүрмийг шинэчлэх, боловсронгуй болгохдоо Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг (тус тогтоолын хавсралтаар орсон) харгалзан үзэхийг уриалсан;
- 2) Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд нь шүүхийн бие даасан байдлын талаарх зарчмуудын нэмэлт бөгөөд түүнийг улам боловсронгуй болгож буйг цохон тэмдэглэсэн;
- 3) НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албаны зохих дэмжлэгтэйгээр, чухал ажил гүйцэтгэсэн Шүүхийн шударга байдлын бүлэг болон шүүхийн бие даасан, хараат бус, шударга байдлыг бэхжүүлэх, энэ талаарх зохих стандартыг боловсронгуй болгох, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулсан олон улсын болон бүс нутгийн шүүхийн форумуудад талархал илэрхийлсэн;
- 4) Шүүхийн шударга байдлын бүлгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжихийг НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас хүссэн;

- 5) Шүүхийн шударга байдлын бүлгийн үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албаны үйл ажиллагаанд сайн дураар хувь нэмрээ оруулсан Гишүүн орнуудад талархал илэрхийлсэн;
- 6) НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийн шүүхийн асуудлаарх сангаас Шүүхийн шударга байдлын бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон Авлигын эсрэг олон улсын хөтөлбөрийн дагуу хөгжиж буй орон, эдийн засгийн шилжилтийн үедээ буй орнуудад хүсэлтийнх нь дагуу шүүх эрх мэдлийн байгууллагын шударга байдал, чадавхыг бэхжүүлэхэд нь сайн дураар зохих хувь нэмрээ оруулахыг Гишүүн орнуудад уриалсан;
- 7) Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудтай холбоотой байр сууриа зохих нэмэлт, өөрчлөлтийн талаарх саналын хамт Ерөнхий нарийн бичгийн даргад өргөн барихыг Гишүүн орнуудад уриалсан;
- 8) НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албыг Шүүхийн шударга байдлын бүлэг, бусад олон улс, бүс нутгийн шүүхийн форумуудтай хамтран, засгийн газар хоорондын шинжээчдийн бүлгийн чөлөөт хурал зохион байгуулж, улмаар Гишүүн орнуудаас гаргасан байр суурийг харгалзан үзэж, Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудын тайлбарыг боловсронгуй болгохыг хүссэн;
- 9) Тогтоолын хэрэгжилтийн талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийн шүүхийн асуудлаарх Комиссын 16 дугаар чуулган дээр тайлагнахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас тус тус хүссэн.

Х. Эдийн засаг, нийгмийн зөвлөл

2006 оны 07 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл “Шүүгчийн ёс зүйн үндсэн зарчмуудыг бэхжүүлэх тухай” 2006/23 тоот тогтоолыг санал хураалтгүйгээр баталсан.

XI. Засгийн газар хоорондын шинжээчдийн бүлгийн хурал

2006 оны 03 дугаар сард Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын төслийг Шүүхийн шударга байдлын бүлгийн зохицуулагч, доктор Нихал Жэйнжикрама бэлтгэж, НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас зохион байгуулсан Шүүхийн шударга байдлын бүлэг болон засгийн газар хоорондын шинжээчдийн чөлөөт бүлгийн хамтарсан хуралд танилцуулсан. Тус хамтарсан хурлыг шүүгч Виранантри болон Өмнөд Африкийн ерөнхий шүүгч Пий Ланга нар хамтран даргалсан. Шүүхийн шударга байдлын бүлгийн бусад гишүүн болох Угандагийн ерөнхий шүүгч Б.Ж. Одоки, Бүгд найрамдах нэгдсэн Танзани улсын ерөнхий шүүгч Б.А. Самата, Египетийн ерөнхий шүүгчийн орлогч, доктор Адель Омар Шериф, Нигерийн ерөнхий шүүгч асан М.Л. Увай нар тус хуралд оролцсон. Харин Австралийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Майкл Кирби тус хуралд оролцож чадаагүй бөгөөд өөрийн санал, дүгнэлтээ бичгээр ирүүлсэн.

Засгийн газар хоорондын шинжээчдийн хуралд дараах шүүгч, засгийн газрын албан тушаалтан, хувь шинжээчид оролцсон. Үүнд: Алжирын шүүгч Нура Хачани; Аргентин улсын дээд шүүхийн дэд ерөнхийлөгч, шүүгч Елена Хайнон де Николко; Азербайжаны шүүгч Назим Тагиев, Раф Гулиев, Гуларза Кавадов нар; Бүгд Найрамдах Доминикан улсын шүүгч, доктор Отавио Листист; Египетийн Дээд шүүхийн шүүгч Мохаммед Алекс Сееф, шүүгч Элхам Наубб Наж, Египетийн

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид; Финляндын тойргийн шүүхийн шүүгч Райтта Кисис, Францын Кастацийн шүүхийн зөвлөх, шүүгч Кристин Чанет; НҮБ-ын Хүний эрхийн хорооны тэргүүн; Германы тойргийн шүүхийн шүүгч Хансжер Шерер; Унгарын Дээд шүүхийн шүүгч Урсула Везекеня; Индонезийн ерөнхий шүүгчийн орлогч, доктор, проф. Пол Эффенди Лотулунг; Исламын Бүгд Найрамдах Иран Улсын Дээд шүүхийн шүүгч Мохаммед Али Шахидарбар; Латви улсын Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын орлогч Каспарс Беркис; Ливийн Араб Жамахириягийн доктор Муфтах Мохамед Казит, Абдель-Хахим Алфитури Аль-Хамроуни, Нада Абдел-Салам Бурккан, Ахмед Ел Халам нар; Молдавын Юрий Прикоп; Касабланкагийн давж заалдах шатны шүүхийн дэргэдэх танхимын ерөнхийлөгч, шүүгч Абделлативата Черкау, Дээд шүүхийн дэргэдэх танхимын ерөнхийлөгч, шүүгч Хадиджа Уаццани Тухами, Мороккогийн зөвлөх Бутейн Бенмусса; Намибийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Коллинз Паркер; Непалийн дээд шүүхийн шүүгч Рам Кумар Прасад Шах; Нидерландын Гадаад Харилцааны яамны Хүний эрх, энх тайвны асуудал хариуцсан зөвлөх Денис де Жон; Нигерийн шүүгч, Үндэсний шүүхийн институтийн зохицуулагч Тимоти Адепоже Ойпипо, Холбооны Хууль зүйн яамны Төрийн ерөнхий зөвлөхийн туслах Фенома Чинэ Увуанд, Үндэсний шүүхийн институтийн судлаач Хадиза Ибрахима Сайе; Пакистаны Гадаад хэргийн яамны газрын захирал Сирид Хаува Шах; Панамын шүүгч Хиомара Булгин Де Вилсон; Румыны Хууль зүйн яамны зөвлөх Кристи Данили; БНСУ-ын шүүгч Хён Вон Бон; Сербийн Хууль зүйн яамны Жован Косик; Испани улсын Барселонагийн Давж заалдах шатны шүүхийн Худалдааны хэлтсийн Ерөнхийлөгч, шүүгч Игнасио Сано Гарагалло; Шри-Ланкийн Хууль зүй, эрх зүйн шинэтгэлийн яамны байнгын нарийн бичгийн дарга Сухада Гамлат; Сирийн

Арабын Бүгд Найрамдах Улсын Байнгын төлөөлөгчийн газрын Башар Сафии; Угандагийн Хенри Хадулу; АНУ-ын Хууль зүйн яамны ахлах зөвлөх Кевин Дрисколл.

Түүнчлэн тус хуралд Америкийн хуульчдын холбооны Хууль дээдлэх ёсны санаачилгын гишүүн Олга Руда, Симон Конте нар; Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс Лорд Жонатан Мэнсон; Германы техникийн хамтын ажиллагааны байгууллагаас доктор Дедо Гейниц, Жонна Бейтс Вислюк, Георг Хубер-Брабенвартер нар; Итали улсын Болонья хот дахь Шүүхийн тогтолцооны судалгааны хүрээлэнгээс профессор Жузеппе Ди Федерико, доктор Франсисио Контини нар; Итали улсын Сиракуза хот дахь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны ахисан төвшний судалгааны олон улсын институтээс Жованни Паскуа, шүүгч Халед Ахмед нар; НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Аркан Эл Сэллани; НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас Кит Вольц, доктор Стюарт Гилман, доктор Оливер Столл, Фил Мацеца, Александра Соуза Мартинс, Угонная Грейс Эзеквем нар; Бүгд найрамдах нэгдсэн Танзани улсын ерөнхий шүүгчийн хувийн нарийн бичгийн дарга Фердинанд Л.К. Вамбалли; болон Шри-Ланкын өмгөөлөгч Нешан Гунасекера нар оролцсон.

Бангалорын төслийг заалт бүрээр нь тусад нь шинжилж, нарийвчлан хэлэлцсэн. Ингээд нэмэлт, өөрчлөлт оруулах, тодорхой хэсгийг хасах дээр тохиролцсон болно. Энэхүү тайлбар нь Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын талаар илүү сайн ойлгоход хувь нэмэр оруулах зорилготой юм.

ХII. Эх сурвалж

Энэхүү тайлбарыг бэлтгэхийн тулд олон тооны эх сурвалж ашиглан, санаа сэдэл авсан. Үүнд олон улсын баримт бичгүүд, шүүгчийн ёс зүйн талаарх үндэсний дүрмүүд, тэдгээрийн тайлбар, олон улс, бүс нутгийн болон үндэсний

шүүхийн шийдвэрүүд, шүүгчийн ёс зүйн зөвлөлдөх хорооны дүгнэлтүүд, хэлэлцүүлгийн материалууд хамаарна. Ашигласан эх сурвалжийг эшлэл хэсэгт дурдаж, талархал илэрхийлсэн болно. Тайлбарт үндэсний болон бүс нутгийн бичвэрийн хэлбэрийг авсан бөгөөд шүүхийн бүх тогтолцоонд ашиглахад тохиромжтой анхдагч эх сурвалжийг бичвэрт дурдаагүй болно. Гэхдээ бүх эх сурвалжийг эшлэлээр оруулж, дээр дурдсан 3 дахь хэсэг болон “Ном зүй” хэсэгт дурдсан болно. Эдгээр эх сурвалжийн үнэлж баршгүй хувь нэмрийг үнэлж, гүнээ талархал илэрхийлье.

Ялангуяа дараах гурван эх сурвалжийг зориуд дурдах нь зүйн хэрэг юм:

Канадын шүүхийн зөвлөлийн *Шүүгчийн ёс зүйн зарчмууд (1998)*;

Европын Зөвлөлийн *Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжүүд (2001-2006)*;

Хятадын засаг захиргааны тусгай бүс Хонг Конгийн *Шүүгчийн ёс зүйн удирдамж (2004)*.

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ БАНГАЛОРЫН ЗАРЧМУУД

УДИРТГАЛ ХЭСЭГ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр тулгасан аливаа эрүүгийн хариуцлага болон эрх үүргээ тодорхойлон тогтоолгохдоо хараат бус, төвийг сахисан шүүхээр эрх тэгш байх үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй гэсэн суурь зарчмыг хүлээн зөвшөөрсөн байна.

ТАЙЛБАР

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлд заасан дараах нөхцөлийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр тунхагласан:

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, төвийг сахисан шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

2. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг ямар нэг санал зөрөлдөөнгүйгээр баталсан бөгөөд тус тунхаглал НҮБ-ын Дүрмийг хүндэтгэн сахиж, дагаж мөрдөхөөр амласан НҮБ-ын гишүүн орнууд дахь эрхийн “нийтлэг ойлголт”-ыг илэрхийлсэн. Энэ нь бүх нийтээр хэрэглэх хүний эрхийн анхны цогц тунхаглал байв. Хүний эрхийн түгээмэл тунхаглал өөрөө заавал дагаж мөрдөх баримт бичиг биш, олон улсын гэрээнд хамаарахгүй, тунхаглал юм. Гэхдээ тус тунхаглалын хувьд, НҮБ-ын Дүрэмд заасан “хүний эрх, суурь эрх чөлөө”

гэх илэрхийллийг тайлбарлахад туслах хууль зүйн эх сурвалж гэж тооцогддог. Үнэндээ, 1971 оны эхээр тунхаглалыг шүүхээс хүлээн зөвшөөрч “Хэдийгээр Тунхаглалд баталгаажуулсан нөхцөл нь заавал дагаж мөрдөх олон улсын конвенцийн шинжгүй боловч ... тэдгээр нөхцөл нь ... заншлын эрх зүйн төрөлжсөн хэм хэмжээ үүсгэсэн буюу ... ерөнхийдөө, хуулиар хүлээн зөвшөөрч тусгаж буй учраас ... заншлын үндсэн дээр улс орнуудад хүчин төгөлдөр” гэжээ.¹



¹ *Legal Consequences for States of the Continued Presence of South Africa in Namibia (South-West Africa) Notwithstanding Security Council Resolution 276 (1970)*, ICJ Reports 1971, separate opinion of Vice-President Ammoun, at p.76.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байх, түүнчлэн хүн бүр зохисгүй удаашруулалгүйгээр, шударга, нээлттэй шүүх хуралдаанаар, чадварлаг, хараат бус, төвийг сахисан, хуульд заасан журмын дагуу байгуулагдсан шүүхээр эрүүгийн хариуцлага, иргэний эрх, үүргээ тодорхойлон тогтоолгох ажиллагааг хийлгэх эрхтэй болохыг баталгаажуулжээ.

ТАЙЛБАР

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт

3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дараах нөхцөлийг тусгасан:

Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, төвийг сахисан шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр санал нэгтгэйгээр баталсан бөгөөд Пактыг соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа буюу 1976 оны 3 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон. 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, 160 улс Пактад нэгдэн орсон буюу соёрхон баталж, олон улсын эрх зүйн дагуу заавал дагаж мөрдөхөө хүлээн зөвшөөрсөн байна.

Улсын үүрэг

5. Пактад нэгдэн орох буюу соёрхон баталснаар улсын хувьд дотооддоо хэрэгжүүлэх гурван үүрэг хүлээдэг. Нэгдүгээрт, энэхүү Пактад оролцогч улс бүр “нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний” энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах” үүрэгтэй. Хоёрдугаарт, Пактад оролцогч улс бүр Үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж батлах, бусад арга хэмжээг авах үүрэгтэй. Гуравдугаарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах; эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг сайжруулах; эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах үүрэгтэй.

Олон улсын эрх зүйн статус

6. Тухайн улс дахь олон улсын эрх зүйн статусыг ерөнхийдөө тухайн улсын хуулиар тодорхойлдог. Үүний үр дүнд, өөр өөр харьяалалд ялгаатай дүрэм хэрэглэдэг. Монист онолыг дагаж буй тохиолдолд, олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүй нь нэгэн зэрэг үйлчлэх бөгөөд тэдгээр нь зөрчилдсөн тохиолдолд олон улсын эрх зүй нь давуу хүчинтэй байна. Харин дуалист онолыг дэмждэг бол, олон улсын эрх зүй болон дотоодын эрх

зүй нь эрх зүйн тусдаа тогтолцоо бөгөөд ялгаатай асуудлыг зохицуулдаг. Тэдгээр нь хоорондоо харилцан хамааралгүй бөгөөд дотоодын хууль тогтоомжоор зохицуулаагүй асуудалд олон улсын эрх зүй нь нөлөө үзүүлэхгүй. Энэ шалтгаанаар, олон улсын гэрээгээр заавал дагаж мөрдөх үүрэг хүлээлгэсэн бол дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах буюу хууль тогтоомжоо түүнд нийцүүлэх шаардлагатай болдог. Гэхдээ, дуалист онолыг баримталдаг ихэнх орны хувьд ерөнхийдөө хүний эрх, эрх чөлөөг хангах нь түүний үүрэг гэж хүлээн зөвшөөрч, тэр нь дотоодын хууль тогтоомжийг батлахад зохих нөлөө үзүүлж байна.

Дээр дурдсан суурь зарчмууд, эрхийн талаарх заалтууд нь бүс нутгийн хэмжээний хүний эрхийн баримт бичгүүд, дотоодын үндсэн хууль, салбар хууль, жишгийн эрх зүй, шүүн таслах ажиллагааны зарчмууд болон жишиг тогтоосон шүүхийн шийдвэрүүдэд мөн тусгалаа олж, хүлээн зөвшөөрөгдсөн болно.

ТАЙЛБАР

Европын хүний эрхийн конвенц

7. Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай 1950 оны Европын конвенцийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах нөхцөлийг тусгасан:

Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан бие даасан, төвийг сахисан шүүхээр нээлттэй, шударгаар, зохих цаг хугацааны дотор шүүлгэх эрхтэй.

Америкийн хүний эрхийн конвенц

8. Хүний эрхийн тухай Америкийн 1969 оны конвенцийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах нөхцөлийг тусгасан:

Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний, хөдөлмөрийн, санхүүгийн болон бусад хэрэгт эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан чадварлаг, бие даасан, төвийг сахисан шүүхээр нээлттэй, шударгаар, зохих цаг хугацааны дотор шүүлгэх эрхтэй.

Африкийн хүний болон ард түмний эрхийн тухай Дүрэм

9. Африкийн хүний болон ард түмний эрхийн тухай 1981 оны Дүрмийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах нөхцөлийг тусгасан:

Хувь хүн бүр өөрт тулгарсан асуудлыг шийдүүлэх эрхтэй. Энэ эрхэд бие даасан, төвийг сахисан шүүхээр зохих цаг хугацааны дотор шүүлгэх эрх багтана.

26 дугаар зүйлд дараах нөхцөлийг баталгаажуулсан:

Энэ Дүрмийн оролцогч улсууд шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулах үүрэгтэй.

Чадварлаг, бие даасан, төвийг сахисан шүүх нь хүний эрхийг хамгаалахад онцгой ач холбогдолтой бөгөөд бүх эрх, эрх чөлөөний хэрэгжилт нь шүүн таслах ажиллагааг зохистой хэрэгжүүлэхээс хамаардаг.

Шүүхүүд үндсэн хуульт болон хууль дээдлэх ёсыг сахиулах үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд шүүх чадварлаг, бие даасан, төвийг сахисан байх зайлшгүй шаардлагатай.

ТАЙЛБАР

Үндсэн хуульт ёс

10. Үндсэн хуульт ёсыг дараах нөхцөлөөр тайлбарлаж болно:

Үндсэн хуульт ёсны үзэл санаа нь төрийн эрх мэдлийг тогтоосон дүрмийн дагуу зохих хэмжээнд хэрэгжүүлэх, тэрхүү дүрмээр зөвшөөрсөн агуулгын хүрээнд хууль тогтоох болон гүйцэтгэх үйл ажиллагаа нь тогтоосон хязгаарлалтаас хэтрэхгүй байхтай холбоотой. Үндсэн хуульт ёс нь улс төрийн хүчин дур зоргоороо үйл ажиллагаа явуулахыг зохих дүрмээр хязгаарлаж, хувь хүний эрх чөлөөнд саад тотгор учруулахаас сэргийлснээр бодитой болдог.²

Хууль дээдлэх ёс

11. Хууль дээдлэх ёсыг сахиулахад бие даасан, төвийг сахисан шүүх хэр ач холбогдолтойг дараах байдлаар тодорхойлсон:

Бие даасан шүүх эрх мэдэл яагаад олон нийтэд чухал болох шалтгаан бол, зөвхөн хууль дээдлэх ёс урт хугацаанд үйлчилж буй нөхцөлд чөлөөт нийгэм

² S.A. de Smith, *The New Commonwealth and its Constitutions* (London, Stevens, 1964), p.106.

оршин тогтнодог. Тэрхүү хууль дээдлэх ёс хэрэгжих үед удирдан зохицуулах үйл ажиллагаа шударга байж, бүх нийтийн тэгш байдлын эсрэг заналхийлэлд шаардлагатай хариу арга хэмжээ авдаг. Энэ нь ойлгомжтой зүйл шиг санагдаж магадгүй ч, хууль дээдлэх ёс нь эрэгтэй, эмэгтэй бүх хүний зүрхэнд хүсэл тэмүүлэл болдог. Энэхүү хүсэл тэмүүлэл нь шүүгч хуулийг зохих чадвартайгаар, шударгаар бүрэн хэрэглэхээс хамаарна. Энэ нь нэн тэргүүнд, шүүгч хараат бус байж, хариуцлагатай ажиллах үндсэн шаардлага болдог. Бид шүүхийн бие даасан байдлыг Гүйцэтгэх засаглалын нөлөөнөөс бие даасан байх нөхцөлөөр ойлгож дассан байна. Гэхдээ орчин цагт шийдвэр маш олон янзаар гардаг бөгөөд бие даасан, хараат бус байдлыг аливаа нөлөөллөөс ангид, хараат бусаар, үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцөлөөр ойлгох боллоо.³

Бие даасан, төвийг сахисан шүүх

12. Шүүх бие даасан, төвийг сахисан байх нь дараах өргөн хүрээтэй ойлголт юм:

Шүүхийн бие даасан байдлын талаарх ойлголт нь бие даасан байдал гэж юу вэ? гэсэн асуулт асуухад хүргэдэг. Хамгийн энгийн тодорхой хариулт бол, засгийн газраас бие даасан байх тухай юм. Түүнчлэн шүүгчид шийдвэр гаргах үүргээ хэрэгжүүлэхдээ, засгийн газраас хараат бус байх ёстой гэдэгт эргэлзэхгүй болов уу. Үүнээс гадна, шүүгчид хууль тогтоох байгууллагаас хараат бус байж, парламентын санаа бодлыг төлөөлөн

³ Sir Gerard Brennan, Chief Justice of Australia, “Judicial Independence”, The Australian Judicial Conference, 2 November 1996, Canberra, available from www.hcourt.gov.au.

илэрхийлэхгүй, тухайн хэргийг шийдвэрлэхдээ парламентын дэмжлэгийг авах буюу парламентын шүүмжлэлээс зайлсхийх гэж оролдох ёсгүй. Мөн шүүгчийн төвийг сахих байдал нь мэргэжлийн, худалдааны, хувийн зэрэг аливаа холбоодыг үгүйсгэхгүй байдлаар илэрнэ.⁴



⁴ Lord Bingham of Cornhill, Lord Chief Justice of England, “Judicial Independence”, *Judicial Studies Board Annual Lecture 1996*, available from www.jsboard.co.uk.

Шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь орчин үеийн ардчилсан нийгмийн амин сүнс болж байна.

ТАЙЛБАР

Шүүхэд итгэх олон нийтийн итгэл

13. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, шударга байдал болон түүний төвийг сахисан, үр ашигтай байдлын талаарх олон нийтийн итгэл нь тухайн улс дахь шүүхийн тогтолцоог хэрхэн дэмждэг нэгэн шүүгчийн зүгээс дараах зүйлийг онцлон тэмдэглэжээ:

Шүүхийн эрх бүхий байгууллага мөнгө, илдгүй байлаа ч, ёс суртахууны хариуцлага хүлээлгэж чадаж буй эсэх дээр олон нийтийн итгэл оршдог. Энэ мэдрэмж нь, шүүхийг бодит байдал дээр төдийгүй харагдах байдлын хувьд ч улс төрийн байр сууринаас асуудалд хандахаас зайлсхийж, улс төрийн хүчний нөлөөллөөс бүрэн ангижрахыг шаарддаг.⁵

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁵ *Baker v. Carr*, Supreme Court of the United States of America, (1962) 369 US 186, per Justice Frankfurter.

Шүүн таслах ажлыг олон нийтийн зүгээс хүлээлгэсэн итгэл хэмээн ойлгож, дээдлэн хүндэлж, шүүгчид дангаараа болон хамтдаа шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж, бэхжүүлж байх нь зайлшгүй чухал юм.

ТАЙЛБАР

Хамтын хариуцлага

14. Шүүгчийн хувьд зөвхөн өөрөө ёс зүйн стандартыг хангах бус, тэрхүү стандартыг хамтдаа бий болгох, дэмжих, дээдлэх үүрэгтэй. Шүүгчийн ёс зүйн зөрчлийн нэг удаагийн тохиолдол байлаа ч, тэр нь шүүхийн нэр хүндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

Шүүн таслах ажил

15. Нэгэн Ерөнхий шүүгч шинээр томилогдсон шүүгчдэд хандан хэлсэн үгэндээ дараах зүйлийг онцлон хэлжээ:

Шүүгчийн үүрэг бол, хуулийн дагуу шударга ёсыг сахиулах үндсэн ажлаараа олон нийтэд үйлчлэх юм. Шүүн таслах ажил бол танд бололцоо, давуу эрх олгодог. Шүүн таслах ажил танаас үйлчлэхийг шаардах бөгөөд энэ нь албаны үүрэг юм. Танд шүүгчээр ажиллахаар шийдсэн хувийн болон мэргэжлийн олон шалтгаан байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ шүүгч нь олон нийтэд үзүүлэх үйлчилгээний ач холбогдлыг байнга ухамсарлахгүй бол амжилтад хүрч чадахгүй төдийгүй, албан үүрэгтээ сэтгэл ханамжтай байж чадахгүй. Бидний эрхэмлэдэг нийгмийн онцгой үнэт зүйлс болох эрх чөлөө, энх тайван, дэг журам, сайн төр бол шүүгч энэхүү албаны үүргээ хэр шударга, зөв хэрэгжүүлсэн талаарх эцсийн үнэлгээнээс хамаарна.

Шүүн таслах ажлыг зохих чадвартай, шударгаар гүйцэтгэсэн гэдэгт олон нийт зөвхөн хууль дээдлэх ёс ноёрхож буй нөхцөлд л итгэдэг. Үүнийг мэдэж байхад, таны албан үүргийн ач холбогдол улам тодорхой болно. Өгсөх, уруудах, бусдад ад үзэгдэх зэргээр олон зүйл таны амьдралд тохиолдож болох ч, шантралгүй, цааш алхах цор ганц шалтгаан бол та амьдарч буй нийгэмдээ чухал үүрэг гүйцэтгэхээр дуудагдсан явдал юм. Та албан үүргээ биелүүлэхдээ онцгой давуу эрхтэй байх хэдий ч, цаг нь ирэхээр энэ албаа орхих болно. Энэ үед, таны олон нийтэд юу хэлсэн, юу хийсэн нь эргээд таны өөрийн амьдралд төдийгүй, шүүхийн нэр хүндэд нөлөөлөх болно. ... Та бол сүр жавхлангийн төлөө бус, бусдад үйлчлэх албанд нэгдсэн. Энэ нь хувийн сэтгэл ханамжийн ундарга мөн. Бардамнах зүйл биш. Таны авах цалин нэмэгдэхгүй; та бусад найз нөхдөөсөө ч илүү шаргуу, удаан ажиллана. Таны үг, үйлдэл бүр олон нийтийн шүүмжлэлийн бай болж, шүүхийн талаарх олон нийтийн үнэлэмж шударга бус санагдсан ч, энэ талаар ярьж болохгүй байж болно. Гэхдээ тухайн өдрийн эцэст, та хуулийн дагуу шударга ёсыг сахиулах замаар олон нийтэд үйлчлэх мэдрэмжийг хүндэлж явдаг, хамт ажилладаг хүмүүстэйгээ хуваалцаж, та маш их сэтгэл хангалуун амьдрах болно. Сайхан сэтгэлтэй, халуун зүрхтэй бай. Бүх зүйл сайхан болно.⁶

⁶ Sir Gerard Brennan, Chief Justice of Australia, addressing the National Judicial Orientation Programme, Wollongong, Australia, 13 October 1996. The full text of the speech is available at www.hcourt.gov.au/speeches/brennanj/brennanj_wollong.htm

**Шүүгчийн ёс зүйг өндөр хэмжээнд байлгах,
түүнийг сайжруулах нь улс бүрийн шүүхийн
байгууллагын тэргүүлэх, хүндтэй үүрэг мөн.**

ТАЙЛБАР

Шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулах нь

16. Шүүгчийн ёс зүйн аливаа дүрэм, шүүхийн бие даасан байдлын талаарх зарчмуудын шүүх өөрөө боловсруулах ёстой. Энэ нь шүүхийн бие даасан байдал болон эрх мэдэл хуваарилах зарчимд нийцнэ. Эхний ээлжид, ихэнх улсад хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь түүний төлөөлөгч, албан хаагчид ямар зан үйлтэй байх, ёс зүйн ямар үүрэгтэй байхыг зохицуулдаг. Энэ загвар нь шүүх эрх мэдлийн байгууллагад ч нэгэн адил тохиромжтой. Хэрэв шүүхийн зүгээс шүүгч, шүүхийн ажилтнуудын ёс зүйн өндөр стандартыг тогтоон, хэрэгжилтийг хангах үүрэг хариуцлагаа биелүүлж чадахгүй буюу үл ойшоовол, олон нийтийн санаа бодол болон улс төрийн ашиг сонирхлын дагуу, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг бусад байгууллага шүүхэд хөндлөнгөөс нөлөөлөхөд хүргэж болно. Энэ тохиолдолд, шүүхээс бие даасан, хараат бус байдлаа тогтвортой хэрэгжүүлэхэд ихээхэн, магадгүй ноцтой хэмжээнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэсэн бөгөөд энэ талаар нэн тэргүүнд улс гүрнүүдэд хандсан байдаг.

ТАЙЛБАР

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд

17. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмуудыг Итали улсын Милан хотноо болсон НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх асуудлаарх чуулганаас 1985 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр баталсан бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/32, 12 дугаар сарын 13-ны өдрийн 40/136 тоот тогтоолоор тус тус санал хураахгүйгээр сайшаасан. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1985 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 40/136 тоот тогтоолд засгийн газруудыг “эдгээр зарчмыг хүндэтгэж, үндэсний хууль тогтоомж, практикийн хүрээнд хүлээн авах”-ыг уриалсан. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмуудыг “Гишүүн орнууд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг дэмжих, баталгаажуулахад нь туслахаар боловсруулсан” бөгөөд дараах нөхцөлтэй. Үүнд:

ШҮҮХИЙН БИЕ ДААСАН, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг төрөөс хангах бөгөөд тухайн улсын Үндсэн хууль болон бусад хуульд тусган баталгаажуулна. Засгийн газар болон бусад байгууллага шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэж, сахин биелүүлнэ.

2. Шүүх аливаа хэргийг шударгаар, нотлох баримтад үндэслэн хуулийн дагуу аливаа хязгаарлалт, хөндлөнгийн нөлөө, дарамт шахалт, заналхийлэлгүйгээр, шууд болон шууд бус хөндлөнгийн оролцоонд авталгүй шийдвэрлэнэ.

3. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд шүүхэд хандсан аливаа асуудлыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдэх онцгой эрхтэй байна.

4. Шүүн таслах ажиллагаанд хууль бусаар буюу аливаа зохисгүй хэлбэрээр нөлөөлж болохгүй бөгөөд шүүхийн гаргасан шийдвэрийг хянах этгээд байж болохгүй. Энэ зарчим нь шүүхийн хяналт хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн байгууллагаас хуульд заасны дагуу шийдвэрийг өөрчлөхөд хамаарахгүй.

5. Хүн бүр ердийн болон дагнасан шүүхээр хуульд заасан журмын дагуу шүүлгэх эрхтэй. Ердийн болон дагнасан шүүхээс өөр байгууллага шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.

6. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх зарчим нь шүүхээс шүүн таслах ажиллагаа явуулахдаа талуудын эрх, эрх чөлөөг хүндэтгэн, эрх тэгш хандах үүрэг юм.

7. Гишүүн улс нь шүүхийг үндсэн чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай, хангалттай нөөц эх үүсвэрээр хангах үүрэгтэй.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

8. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасны дагуу шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнууд бусад иргэний нэгэн адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрхтэй ба энэхүү эрхээ эдэлж байгаа шүүгчид албаны нэр хүнд, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хадгална.

9. Шүүгчийн хувьд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, мэргэшлийн сургалтыг дэмжих, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх зорилго бүхий шүүгчдийн холбоо болон бусад байгууллагыг үүсгэн байгуулах, тэдгээрт чөлөөтэй нэгдэх эрхтэй.

ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, СУРГАЛТ

10. Шүүгчээр сонгогдсон этгээд хувь хүний хувьд шударга, зохих сургалтад хамрагдсан, хуульд заасан мэргэжлийн ур чадварыг хангасан байна. Шүүгч сонгон шалгаруулах арга хэлбэр нь аливаа зохисгүй сэдлээр шүүгчийг томилохын эсрэг байна. Шүүгчийг сонгон шалгаруулахдаа арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, яс үндэс, нийгмийн гарал, өмч хөрөнгө, нийгмийн байдал зэрэг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах ёсгүй. Шүүгчид нэр дэвшигч нь тухайн улсын иргэн байх шаардлагыг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

11. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус, аюулгүй байдал, зохимжтой цалин хөлс, ажлын болон тэтгэврийн нөхцөл, тэтгэвэрт гарах насыг хуулиар тусгайлан зохицуулна.

12. Шүүгч томилогдсон, сонгогдсон эсэхээс үл хамааран тэтгэвэрт гарах, бүрэн эрхийн хугацаа дуусах хүртлээ шүүгчийн бүрэн эрхээ баталгаатай эдэлнэ.

13. Шүүгчийг дэмждэг буюу дэвшүүлдэг тогтолцоо нь бодит хүчин зүйл, эзэмшсэн ур чадвар, туршлагад суурилсан байх ёстой.

14. Тухайн шүүхийн шүүгчдэд хэрэг хуваарилах ажиллагаа нь шүүхийн захиргааны дотоод үйл ажиллагаа байна.

МЭРГЭЖЛИЙН НУУЦЛАЛ БОЛОН ЭРХИЙН БАТАЛГАА

15. Нээлттэй шүүх хуралдаанаас бусад, шүүн таслах ажиллагааны хүрээнд албан үүргийн дагуу олж мэдсэн шүүхийн мэргэжлийн нууцыг задруулахыг хориглох бөгөөд тэрхүү нууцтай холбоотойгоор мэдүүлэг авахыг хориглоно.

16. Үндэсний хуульд заасны дагуу мэргэжлийн, сахилгын үйл ажиллагаа, тухайн улсын нөхөн олговор олгох харилцааг хөндөхгүйгээр шүүгч нь шүүн таслах ажиллагаа явуулсны төлөө мөнгөн хохиролтой холбоотой иргэний нэхэмжлэлээс халдашгүй байх эрхийг баталгаатай эдэлнэ.

ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ОГЦРУУЛАХ

17. Шүүгчийн мэргэжил, ур чадвартай холбоотойгоор түүний эсрэг аливаа хэрэг, гомдлыг зохих журмын дагуу шударгаар, шуурхай хянан хэлэлцэнэ. Шүүгч нь шударга сонгол явуулахыг шаардах эрхтэй. Шүүгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хянан шалгах анхдагч ажиллагаа нууц байна.

18. Шүүгчийг зөвхөн мэргэжлийн болон зан байдлын хувьд албан үүргээ хэрэгжүүлж чадахгүй гэх үндэслэлээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, огцруулах арга хэмжээ авч болно.

19. Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах, албан үүргээс нь түдгэлзүүлэх, огцруулахтай холбогдсон аливаа ажиллагааг шүүгчийн ёс зүйн тогтоосон стандартын дагуу явуулна.

20. Сахилгын шийтгэл оногдуулах, албан үүргээс нь түдгэлзүүлэх, огцруулах шийдвэрийг бие даасан хяналтын байгууллага гаргана. Энэ зарчмыг хууль тогтоох байгууллагын шийдвэрээр хяналтын шатны шүүхийн шүүгчид хамааруулахгүй байж болно.

Дараах зарчмууд нь шүүгчийн ёс зүйн стандартыг тогтоох зорилготой. Эдгээр зарчмууд шүүгчийн ёс зүйг зохицуулах хүрээнд шүүхээс хийх зүйлийг тодорхойлох, шүүгчдэд зөвлөмж өгөхөд зориулагдсан болно.

Түүнчлэн эдгээр зарчмууд нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын төлөөлөл, хуульчид, олон нийтийн зүгээс шүүхийг илүү сайн ойлгох, дэмжихэд нь туслах зорилготой юм.

Эдгээр зарчмууд нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг бүхий бие даасан, төвийг сахисан байгууллагын өмнө шүүгчид хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг урьдчилан тогтоож буй бөгөөд өнөөгийн хүчин төгөлдөр хуулиар тогтоосон журам, ёс зүйн хэм хэмжээг үгүйсгэхгүйгээр боловсронгуй болгох зорилготой юм.

ТАЙЛБАР

Суурь болон түгээмэл үнэт зүйлс

18. Шүүгчийн ёс зүйн талаарх зарчмууд нь суурь болон түгээмэл зургаан үнэт зүйлд суурилж, зарчим тус бүрийг хэрэглэх нөхцөлийг тусгасан бөгөөд, шүүгчдэд зөвлөмж өгөх, үндэсний ёс зүйн хэм хэмжээний бусад механизмтай эсэхээс үл хамааран шүүхээс шүүгчдийн зан үйлийг зохицуулах боломж олгоход зориулагдсан. Зарчим бүрийг хэрэглэх нөхцөлийг боловсруулахдаа, хэт ерөнхий буюу ойлгомжгүй заавар өгөх, шүүгчийн өдөр тутмын амьдралд тулгардаг янз бүрийн олон асуудал буюу хэт нарийвчлан тайлбарлахаас зайлсхийв. Иймд тухайн улс бүрийн онцлогтой уялдуулан тэдгээр нөхцөлийг тохируулан хэрэглэж болно.

Дүрмийн зөрчил бүр сахилгын шийтгэл хүлээх нөхцөл болохгүй

19. Шүүгчийн ёс зүйн зарчмаар шүүгчдэд үүрэг хүлээлгэсэн явдал нь тэдгээр зарчмыг зөрчсөн тохиолдол бүрд сахилгын арга хэмжээ авахуулах зорилгыг агуулаагүй. Тухайн нэг шүүгчийн алдаа бүр ёс зүйн зарчмуудын зөрчлийн хэмжээнд хамаарахгүй буюу ёс зүйгүй үйлдэлд тооцогдохгүй. Сахилгын арга хэмжээг зөвхөн ноцтой зөрчилд авах бөгөөд, бусад хүчин зүйлээс хамаарч болохгүй. Иймд ноцтой зөрчилд, зохисгүй үйлдлийн хэв маягаас үл хамааран, бусдад буюу шүүхийн тогтолцоонд бүхэлд нь сөргөөр нөлөөлөх хэмжээний зохисгүй үйлдлийг ойлгоно.

Шүүх эрх мэдлийн чиг үүргийг ойлгох талаар

20. Ардчилсан улс болгонд шүүх эрх мэдлийн чиг үүргийн талаарх ойлголт, ялангуяа шүүгчийн зүгээс хуулийг шударгаар, шуурхай хэрэглэх үүргийн талаарх ойлголт нь, нийгмийн болон улс төрийн болзошгүй дарамт шахалтаас үл хамааран харилцан адилгүй байна. Үүнийг дагаад шүүхийн үйл ажиллагаанд итгэх итгэлийн төвшин жигд бус байна. Шүүхийн чиг үүргийн талаар хангалттай мэдээлэлтэй байх нь шүүх эрх мэдэл ардчилсан үндсэн хуульт тогтолцооны гол тулгуур төдийгүй төр, иргэний харилцааны хил хязгаар юм гэсэн ойлголтыг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж чадна. Шүүгчийн ёс зүйн талаарх зарчмууд нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын төлөөлөл, хуульчид, хэргийн оролцогчид, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааны мөн чанар, шүүхэд төдийгүй шүүхээс гадуур шүүгчийн баримталбал зохих ёс зүйн өндөр стандарт, шүүгчид албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой учирдаг бэрхшээлийг сайтар ойлгоход туслах зорилготой юм.

Ёс зүйн стандарт тогтоох хэрэгцээ, шаардлага

21. Нэгэн шүүгч шүүн таслах ажилд тохиромжтой ёс зүйн стандарт тогтоох хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

Шүүгчид шүүхэд төдийгүй, шүүхээс гадуур ёс зүйн тодорхой стандартын дагуу бие авч явах ёстой гэдэгт хэн ч эргэлздэггүй. Харин үүнийгээ сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх үү, эсвэл өөрийн болон олон нийтийн эрх ашгийн үүднээс тодорхой мэргэжлийн ёс зүйг дагаж мөрдөх ёстой юу? Энэ суурь асуулт нь энгийн ажиглалт хийх шаардлагыг бий болгож байна. Бид олон нийтийн дунд тодорхой бүлэгт ангилагддаг. Бид нэр хүндтэй мэргэжлийн бүлгийн шалгарсан хэсгээс бүрддэг. Бид өдрөөс өдөрт ач холбогдол нь өсөн нэмэгдэж байгаа эрх мэдлийг хэрэгжүүлэхээр итгэмжлэгдсэн хүмүүс. Энэхүү эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ, бидний өмнө зогсож байгаа хүмүүсийн амьдрал, эд баялгийн талаар шийдвэр гаргадаг. Эдгээр хүмүүсийн хувьд, тэд өөрсдөө болон тэдний эд баялаг хэзээ нэгэн цагт бидний шийдвэрээс хамаарна гэдэгт итгэж яддаг. Тиймээс тэд ийм эрх мэдлийг шударга, чадвартай, ёс зүйтэй эсэх нь эргэлзээтэй хэн нэгэнд өгөхийг хүсэхгүй. Иймд одоогийн эрх зүйн тогтолцооны тасралтгүй байдлыг хангах, шүүхэд итгэх итгэлийг бий болгохын тулд шүүхэд болон шүүхээс гадуур баримтлах ёс зүйн стандарт хэрэгтэй.⁷

⁷ J.B. Thomas, *Judicial Ethics in Australia* (Sydney, Law Book Company, 1988), p.7.

ҮНЭТ ЗҮЙЛ 1: БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ

Зарчим:

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь хууль дээдлэх ёс, шүүн таслах ажиллагааг шударгаар хэрэгжүүлэх үндсэн баталгаа, урьдчилсан нөхцөл болдог. Иймд шүүгч нь хувийн амьдралдаа болон албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг байнга хүндэтгэн дээдэлж, өөрөө үлгэр жишээч байвал зохино.

ТАЙЛБАР

Шүүн таслах ажлыг эрх ямба бус, үүрэг хариуцлага дагалддаг

22. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бол хувь шүүгчийн хувьд эрх ямба юм уу, эрх мэдлийн тухай асуудал биш юм. Энэ нь шүүгч бүрт хэрэг маргааныг гадны ямар нэгэн дарамт нөлөөгүй, хэн нэгний хөндлөнгийн оролцоогүй, хуулийн дагуу үндэслэлтэй шийдвэрлэх хариуцлага хүлээлгэдэг. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын үндсэн зарчим нь шүүхэд ирсэн хэрэг, маргааныг шүүгч хянан хэлэлцэх, шийдвэрлэх бүрэн эрх бөгөөд засгийн газар, ашиг сонирхлын бүлэг, хувь хүн, бусад шүүгч хэн боловч шүүгчийг хэрэг хянан хэлэлцэх, шийдвэр гаргахад нь нөлөөлөх, нөлөөлөхөөр оролдохыг хориглосон.⁸

⁸ See *R v Beauregard*, Supreme Court of Canada, [1987] LRC (Const) 180 at 188, per Chief Justice Dickson.

Хувийн болон албаны бие даасан, хараат бус байдал

23. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь, шийдвэр гаргахад хувийн болон албаны хувьд бие даасан байдалтай байх шаардлагыг илэрхийлдэг. Тиймээс, бие даасан, хараат бус байдал нь оюун санааны болон албаны байдал, үйл ажиллагааны зохицуулалтын аль алинд хамаарна. Эхэн үед, шүүгчийг үйл баримтаас хараат бус байхад анхаарч байсан бол сүүлийн үед, шүүх ба бусад этгээдийн хоорондын харилцаанд, ялангуяа төрийн бусад эрх мэдлээс бодитоор төдийгүй харагдах байдлын хувьд ч бие даасан, хараат бус байх нөхцөлийг баталгаатай болгоход анхаарах болов. Тэгэхээр, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх дээрх хоёр онцлогоос шалтгаалан, хувь шүүгч оюун санааны хувьд хараат бус байж болох ч, шүүх нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрийн бусад эрх мэдлээс бие даасан байж чадахгүй бол шүүгчийг хараат бус гэж үзэхгүй.⁹

Бие даасан, хараат бус байдал нь төвийг сахихаас ялгаатай болох нь

24. “Бие даасан, хараат бус байдал” болон “төвийг сахих байдал” гэх ойлголт нь маш ойролцоо боловч, тусдаа, ялгаатай ойлголт юм. “Төвийг сахих байдал” нь тухайн хэргийн талууд болон хэргийн асуудалтай холбоотойгоор, шүүх бүрэлдэхүүнээс оюун санаа, зан төлөвийн хувьд хараат бус байх нөхцөлийг хэлнэ. “Төвийг сахих” гэдэг үг нь бодит байдал дээр төдийгүй ухамсрын хувьд алдаа дутагдалгүй байхыг илэрхийлдэг. “Бие даасан, хараат бус” гэх үг нь бие даасан, хараат бус байдлын талаарх Үндсэн хуулийн үнэт зүйлийг буюу уламжлалыг илэрхийлдэг. Иймд, энэ ойлголт нь шүүхийн чиг үүргийг бодитоор хэрэгжүүлэхэд оюун санаа, зан төлөвийн хувьд хараат бус байхтай холбоогүйгээр, шүүхийг бусад этгээдээс,

⁹ See *Valente v The Queen*, Supreme Court of Canada, [1985] 2 SCR 673.

ялангуяа төрийн гүйцэтгэх эрх мэдлийн салбараас бие даасан байх бодит нөхцөл, баталгаан дээр тулгуурладаг.

Шүүгч Засгийн газрын өмнө өдөр тутмын үүрэг хүлээдэггүй

25. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх Үндсэн хуулийн зохицуулалт нь тэр даруй шүүхийг шууд бие даасан болгож чаддаггүй. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг төрийн гурван эрх мэдэл нэгэн зэрэг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх ёстой. Ялангуяа, шүүгчид Засгийн газрын өмнө өдөр тутмын үүрэг хүлээдэггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Тэд засгийн газрыг урсах ус, хийсэх салхи мэт хардаг. Тэд ямар ч сайдад төрийн албан хаагчид шиг үнэнч байх үүрэггүй. Мөн шүүгчид бол сэнтийд суусан арслангууд. Гэхдээ тэд энэ сэнтийг Ерөнхий сайдын үзэмжээр бус, хууль болон олон нийтийн эрх ашгийн үзэл баримтлалд үндэслэн эзэгнэдэг. Энэ үндэслэл нь шүүгч бол хууль болон үзэл баримтлалд үнэнч байх тухай ойлголт юм. Энэ нь тэдний хүч чадал, үнэт зүйл заримдаа сул тал, аюул заналхийлэл болдог.¹⁰

Дэлхийн 2 дугаар дайны үеэр нэгэн шүүгч дараах тэмдэглэгээг хийжээ.¹¹ Үүнд:

Энэ улсад зэвсэгт мөргөлдөөн гарч байхад үед хууль чимээгүй байгаагүй . Хууль өөрчлөгдөж дайны үе тогтсон ч бай, энх тайван байдалтай үеийн нэгэн адил хууль нэгэн ижил хэлээр ярьдаг. Энэ нь бидний өдгөө тэмцэж буй эрх чөлөөний тулгуур баганын нэг төдийгүй, эрх чөлөөний талаарх зарчмуудын нэг байсаар ирсэн зүйл. Шүүгч бол гүйцэтгэх эрх мэдлийн

¹⁰ J.A.G. Griffith, *The Politics of the Judiciary*, 3rd ed. (London, Fontana Press, 1985), p.199.

¹¹ *Liversidge v. Anderson*, House of Lords, United Kingdom [1942] AC 206 at 244, per Lord Atkin.

байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах гэсэн оролдлогыг дэмжигч, зөвшөөрөгч биш, харин аливаа албадлагын арга хэмжээ нь хуульд нийцсэн байх ёстойг сэрэмжлүүлэн сануулагч юм.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын угтвар нөхцөл

26. Шүүхийг бусад эрх мэдлийн байгууллагаас “бие даасан, хараат бус” эсэхийг тогтоохын тулд ихэвчлэн шүүгчдийн томилгоо, бүрэн эрхийн хугацаа, үйл ажиллагаа явуулах нөхцөл, гадны дарамт шахалтын эсрэг баталгаа, шүүх бие даасан байдалтай харагдаж буй эсэх зэрэг зүйлийг харгалзан үздэг. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь наад захын дор дурдсан гурван нөхцөлийг хангасан байх ёстой.¹² Үүнд:

- 1) Албаны бүрэн эрхийн баталгаа: тухайлбал, шүүгчийг бүх насаар нь томилдог, тэтгэвэрт гарах хүртэл нь томилдог, эсвэл томилох хугацаа нь холимог байдаг эсэхээс үл хамааран гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага эсхүл шүүгчийг томилох эрх бүхий этгээдийн зүгээс дур зоргоор, саадгүй нөлөөлөхийн эсрэг баталгаа.
- 2) Санхүүгийн баталгаа: тухайлбал, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь шүүхийн бие даасан байдалд нөлөөлөхүйц байдлаар, хуулиар тогтоосон шүүгчийн цалин, тэтгэвэр авах эрхэд дур зоргоороо нөлөөлж болохгүй. Харин энэхүү шаардлагын хүрээнд, засгийн газрууд шүүхийн төрөл тус бүрт тохирсон цалин хөлсний тусгай төлөвлөгөө боловсруулж болно. Энэ нь хамгаалагдсан эрх, чанарыг хангасан нөхцөлд санхүүгийн баталгааны шаардлага, тэгш байдалд нийцсэн санхүүгийн олон янзын схем байна.

¹² *Langborge v Sweden*, European Court of Human Rights, (1989) 12 EHRR 416.

- 3) Институцийн бие даасан байдал: тухайлбал, шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой захиргааны үйл ажиллагаа нь шүүхийн бие даасан байдлыг хүндэтгэх ёстой. Шүүгчийн шийдвэр¹³, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан товлох зэрэг шүүхээс шийдвэр гаргах чиг үүрэгтэй холбоотой асуудлаар шууд, гэнэтээр нөлөөлөх гаднын хүчин зүйл байж болохгүй. Харин шүүхэд нөлөөлөх, хувь хүний маргааныг шийдвэрлэхээс бусад хууль болон үндсэн хуулийн үнэт зүйлийг дээдлэхтэй холбоотой асуудлаар, шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хоорондоо харилцаатай байж болно.¹⁴

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹³ In *The Queen v Liyanage* (1962) 64 NLR 313, the Supreme Court of Ceylon (now Sri Lanka) held that a law which empowered the Minister of Justice to nominate judges to try a particular case was ultra vires the Constitution in that it interfered with the exercise of judicial power which was vested in the judiciary.

¹⁴ See *Valente v The Queen*, Supreme Court of Canada, [1985] 2 SCR 673.

Хэрэглэх нь:

1.1. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг үйл баримтын талаарх өөрийн үнэлэлтэд тулгуурлан, хуулийг ухамсартайгаар ойлгож, оролцогч талуудын шууд ба шууд бус аливаа нөлөө, зүй бус урамшуулал, дарамт шахалт, заналхийлэл, саад тотгоргүйгээр хараат бусаар хэрэгжүүлнэ.

ТАЙЛБАР

Гадны нөлөөгөөр шийдвэрийн агуулгыг тодорхойлох ёсгүй

27. Шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд гадны зохисгүй нөлөө байна гэж ойлгогдох үед шүүхэд итгэх итгэл алдардаг. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал болон шүүхийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг хадгалахад зайлшгүй шаардлагатай зүйл бол шүүгчийн шийдвэрт гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллага, бусад шүүгч нөлөөлж, шийдвэрийн агуулгыг тодорхойлсон гэх ойлголт төрүүлэхгүй байх явдал юм. Тухайн нэг шүүгчид үзүүлэх нөлөөлөл нь олон янз төдийгүй, хязгааргүй байдаг. Үүнийг ойлгож, ямар нэг айдас, тааламжтай нөхцөлд автахгүйгээр, эцсийн шийдвэр олон нийтэд таалагдах эсэхээс үл хамааран үйл баримтын талаарх өөрийн үнэлгээнд тулгуурлаж, хууль хэрэглэх нь шүүгчийн үүрэг юм. Жишээ нь Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгчийн зүгээс Өмнөд Африкийн Нийгэмлэгийн гомдолд, хүн амины ноцтой хэрэгт цаазаар авах ял оноох нь харгис хэрцгий, хүнлэг бус буюу доромжилсон хэлбэрийн шийтгэл юм гэж хариу өгөхдөө, дараах зүйлийг хэлжээ.¹⁵

¹⁵ *S v. Makwanyane*, Constitutional Court of South Africa, 1995 (3) S.A. 391, per President Chaskalson.

Бидний өмнө тулгарсан асуудал бол Өмнөд Африкчуудын олонх нь цаазаар авах ялыг байх ёстой ял шийтгэл гэж үзэж буй ч хэрэглэж болох тухай юм. Энэ ялыг Үндсэн хуулиар зөвшөөрсөн. Олон нийтийн санаа бодол бол харгалзан үзэх зүйл байж болох ч, энэ нь өөрөө Үндсэн хуулийн шүүхээс ямар нэг айдас, тааламжтай нөхцөлд автахгүйгээр, Үндсэн хууль болон түүний заалтуудыг тайлбарлах үүргийг орлохгүй талаарх ойлголт юм. Хэрэв олон нийтийн санаа бодлоор асуудалд хандах ёстой юм бол, Үндсэн хуулийн шүүх байх, шийдвэр гаргах шаардлагагүй юм. Олон нийтэд таалагдах шийдвэр гаргах замаар Үндсэн хуулийн бие даасан байдлыг хангаж, шүүгчийн үүргээ гүйцэтгэхээс татгалзахыг шүүх өөртөө хэрхэвч зөвшөөрч болохгүй.

Шүүгч нь алдар хүнд, шүүмжлэлээс үл хамааран ажиллах ёстой

28. Олон нийтийн дунд маргаан дагуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн цар хүрээтэйгээр мэдээлж буй тухайн нэг хэргийг хянан хэлэлцэж буй шүүгчийн хувьд, өөрийгөө олны хараанд буйгаар тодорхойлж болох юм. Заримдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж буй мэдээ, нийтлэлийн агуулга тодорхой нэг хүссэн үр дүн рүү чиглэх хандлагатай байдаг. Гэхдээ шүүгчийн хувьд, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ хэвлэл мэдээллийн нөлөөнөөс ангид байх ёстой. Шүүгч нь хууль хэрэглэж шийдвэр гаргахдаа, хэргийн оролцогч тал олны танил, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, засгийн газарт өндөр албан тушаал хашдаг, шүүгчийн өөрийнх нь найз нөхөр, гэр бүл эсэхийг харгалзан үзэх ёсгүй. Шүүгч нь тодорхой хэсэг бүлгийн ашиг сонирхол, олон нийтийн анхаарал, шаардлагад автахгүй байх ёстой. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь гадны нөлөөллийн бүх хэлбэрээс ангид байх тухай ойлголт юм.

Шийдвэрт нөлөөлөх аливаа оролдлогоос зайлсхийх ёстой

29. Зөвхөн хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч шүүх хуралдааны танхимд нээлттэйгээр шүүхэд нөлөөлөх аливаа оролдлого хийж болдог. Шүүгч нь шүүхээс хянан хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх гэсэн шүүхээс гадуур, бусад этгээдийн оролдлоготой тулгарч болзошгүй. Тиймээс тэрхүү оролдлогын эх сурвалж нь улс төрийн, албан тушаалын, сэтгүүл зүйн, гэр бүлийн болон бусад этгээдийн байсан ч эрс зайлсхийх ёстой. Заримдаа, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд чиглэсэн аюул заналхийлэл нь тодорхой нэг хэргийг шүүгч хэрхэн шийдвэрлэх ёстой талаар нөлөөлөхийг оролдох буюу ямар нэг аргаар шүүгчтэй харьцах нарийвчилсан арга хэлбэртэй байдаг. Иймэрхүү шууд буюу шууд бусаар шүүгчид нөлөөлөх гэсэн аливаа оролдлогоос шүүгч зайлсхийх ёстой. Ялангуяа нөлөөллөөс зайлсхийсэн ч, дахин давтан нөлөөлөх оролдлого хийсээр байвал шүүгчийн зүгээс арга хэмжээ авч зохих эрх бүхий этгээдэд мэдэгдэх ёстой. Шүүгч, шүүхийн шийдвэр гаргахад зохисгүйгээр нөлөөлөх гэр бүл, нийгэм, улс төрийн аливаа харилцааг зөвшөөрөх ёсгүй.

Зохисгүй нөлөөллийг тодорхойлох нь

30. Зохисгүй нөлөөлөл гэж юу болохыг тодорхойлоход хэцүү байдаг. Жишээ нь, шүүхийн процессыг улс төр, хэвлэл мэдээллийн болон бусад эх сурвалжийн гажуудал, дарамтаас хамгаалах хэрэгцээ, нийтийн ашиг сонирхол болон хэвлэлийн эрх чөлөөний асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийх сонирхлын хооронд зохистой тэнцвэрийг бий болгох ёстой бөгөөд шүүгчийн зүгээс олны танил, алдартан, хэт мэдрэмтгий, эмзэг хэн нэгэн байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Ардчилсан нийгэмд нийтийн албан тушаалтныг шүүмжлэх нь түгээмэл байдаг. Хуулиар зохицуулсан хязгаарын хүрээнд, хэрэг шийдвэрлэсэн байдал, үндэслэл, шийдвэрийн талаарх шүүмжлэлээс шүүгч нь халдашгүй байх ёсгүй.

1.2. Шүүгч нь олон нийт болон тухайн хянан шийдвэрлэж буй маргааны оролцогч талуудаас хараат бус байна.

ТАЙЛБАР

Бүрэн тусгаарлалт ашигтай байдаггүй

31. Шүүгч нийгмээс хэрхэн хараат бус байх ёстой вэ? Шүүгчийн ажил мэргэжлийг “санваартны ажил шиг” гэж дүрсэлсэн тохиолдол бий.¹⁶ Өөр нэг шүүгч “Ерөнхий шүүгч сүм рүү орж байж л шүүн таслах ажлаа зогсоодог” гэж бичсэн.¹⁷ Өнөөдрийн өнцгөөс харвал ийм хязгаарлалтууд хэтэрхий ихийг шаардаж байна гэж хэлж болох ч, шүүгчид оногдуулсан дэглэм нь магадгүй олон шинжээрээ “сүм хийдийн санваартан” шиг байхыг шаарддаг.¹⁸ Шүүгчийн хувьд, бусад хүнтэй харьцуулахад илүү хүнд, хязгаарлагдсан амьдралын хэлбэртэй байхыг шаарддаг ч, энэ нь түүнийг орон гэр, гэр бүл, найз нөхдийн дунд өнгөрөх хувийн амьдрал нь нийгмээс өөрийгөө тусгаарлах үндэслэл болохгүй. Шүүгчийг амьдарч буй нийгмээс нь бүрэн тусгаарлах нь ашигтай байдаггүй.

Нийгэмтэй харилцах шаардлагатай

32. Хэрэв шүүгч ажлын цаг дууссаны дараа гэрээ битүүмжилдэггүй л юм бол, түүний үзэл бодолд найз нөхөд, хамт ажиллагсад, хэвлэл мэдээллийн нөлөө тусгалаа олдог. Үнэндээ, олон нийтийн талаарх мэдлэг бол шударга ёсыг

¹⁶ Lord Hailsham, Lord Chancellor of England, cited in A.R.B. Amerasinghe, *Judicial Conduct Ethics and Responsibilities* (Sri Lanka, Vishvalekha Publishers, 2002), p.1.

¹⁷ William H. Taft, Chief Justice of the United States Supreme Court, cited in David Wood, *Judicial Ethics: A Discussion Paper* (Victoria, Australian Institute of Judicial Administration Incorporated, 1996), p.3.

¹⁸ Justice Michael D. Kirby, Judge of the High Court of Australia, cited in David Wood, *Judicial Ethics*, p.3.

сахиулахад зайлшгүй шаардлагатай зүйл юм. Шүүгч зөвхөн дэлхийн бодит мэдлэгээр сайжрахгүй. Орчин үеийн эрх зүйн мөн чанар нь шүүгчийг “энэ дэлхий дээрх үзэл бодлоор амьдарч, амьсгалж, бодож, хүртэх”-ийг шаардаж байна.¹⁹ Өнөөдөр, шүүгчийн чиг үүрэг зөвхөн маргааныг шийдвэрлэхээр хязгаарлагдахгүй. Шүүгч нь нийгмийн үнэт зүйлс, хүний эрхийн өргөн хүрээтэй олон асуудалд анхаарлаа хандуулах, нийгмийн ёс суртахуунтай холбоотой маргааныг шийдвэрлэх, нийгмийн олон ургач үзэлтэй холбоотой асуудалтай тулгарах нь улам бүр нэмэгдсээр байна. Нийгэмтэйгээ холбоогүй шүүгч үр нөлөөтэй байдаггүй. Шүүгч нь өөрийн үйлчилж буй олон нийтийн зүгээс хэтэрхий тусгаарлагдсан тохиолдолд, шүүгчийн хувийн хөгжил, нийтийн ашиг сонирхолд ч сайн нөлөө үзүүлэхгүй. Хууль зүйн стандартууд нь оюун ухаант хүний шалгуурыг хэрэглэхийг байнга уриалдаг. Шүүн таслах ажлын чухал хэсэг болох маргааны үйл баримтыг зөв тогтоох, эрүүл саруул сэтгэлгээ, туршлагын дагуу нотлох баримт үнэлэхийг шүүгчээс шаардаж байна. Тиймээс, шүүгчийн онцгой үүрэгт нийцүүлэн шүүгч нийгэмтэй ямагт нягт холбоотой байх ёстой.

Ёс зүйн дилемм

33. Ёс зүйн дилеммийг маш товчхоноор дараах байдлаар тоймлосон байна.²⁰ Үүнд:

Шүүхийн ажилтнуудаас нэг талаар харилцан ойлголцол, даруу байдал, шийдэмгий байдал, эрүүл саруул сэтгэлгээ, оюуны чадамжийг дээд зэргээр хөгжүүлсэн, нөгөө талаас бүрэг, зожиг, эв дүйгүй, явцуу, хөшүүн, сэхүүн биш байдлыг хүлээж болох уу? Мэдээж хэрэг, нэгэн зэрэг үлгэр дуурайл үзүүлж, энгийн иргэнд эдгээр бүх үйлдлийг давхар харуулах

¹⁹ See United States of America, Supreme Court of Wisconsin, Judicial Conduct Advisory Committee, *Opinion 1998-10R*.

²⁰ David Wood, *Judicial Ethics*, p.2.

боломжгүй. Заримдаа бусдын магтаалд тоомжиргүй байх нь, иргэдийн зүгээс хүйтэн хөндий, албаны гэж муулуулах нөхцөл болдог. Харин эсрэгээрээ, зарим хүмүүсийн хөнгөмсөг, шүүхийн албыг хүндэтгэхгүй байгаагийн илрэл гэж үздэг хошин зан, хөнгөмсөг хандлагыг шүүхийн ажилтнууд харуулбал, бусад нь алга ташиг хүлээн авч болох юм.

Магадгүй Оливер Венделл Холмес шүүгчдэд хандан “амьдарсангүй гэж шүүгдэх аюултай тул, сэтгэл хөдлөлөө тухай бүр бусадтай хуваалц” гэж зөвлөгөө амьдарч буй цаг хугацаанаасаа түрүүлсэн байж болох юм.

Сайн практикийн жишээ

34. Шүүгч нийгэмтэйгээ харилцахдаа дараах нийтлэг заавар, зөвлөмжийг баримтлах шаардлагатай. Эдгээр заавар, зөвлөмжийг ихэвчлэн тусгай ашиг сонирхлын бүлгүүдтэй харилцдаг шүүгчдэд зориулан шүүхийн ёс зүйн зөвлөлдөх хорооноос бэлтгэсэн болно.²¹

- 1) Хувийн уулзалт хийх хүсэлтийг шүүгч заавал хүлээн авах албагүй.
- 2) Хүсэлтийг хүлээн авах эсэхийг шийдэхийн өмнө, шүүгч нь уулзалтын зорилгын талаар сайтар асууж лавлавал зохино.
- 3) Шүүгч нь тухайн уулзалтад ялагч, өмгөөлөгч талаас хэнийг оролцуулах эсэхийг хянан үзсэн байвал зохино. Ихэнхдээ шүүгчтэй уулзах хүсэлт эрүүгийн хэргийн шүүхтэй холбоотой байдаг. (Тухайлбал, согтуугаар жолоо барьсан хэрэгт хохирогч талын ээжүүдийн төлөөллийг оролцуулах эсэх)
- 4) Буруу ойлголт төрүүлэхгүйн тулд тусгай ашиг сонирхлын бүлгийн хүсэлт нь бичгээр үйлдэгдсэн

²¹ See United States of America, Supreme Court of Wisconsin, Judicial Conduct Advisory Committee, *Opinion 1998-13*.

- байхыг шаардана. Ингэснээр, шүүгч тухайн уулзалт болон асуудал хэлэлцэх үндсэн дүрмийг бичмэл байдлаар баталгаажуулна.
- 5) Тухайлсан нэг хэрэгт зөвхөн нэг талын ашиг сонирхол бүхий харилцаа холбоог бүрэн хориглох бөгөөд энэ талаар уулзалт эхлэхээс өмнө хүсэлт гаргагчид тодорхой танилцуулсан байх ёстой.
 - 6) Шүүгч нь уулзалтын үеэр шүүхийн сурвалжлагч/хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан/, тэмдэглэл хөтлөгч байх эсэхийг хянан үзсэн байвал зохино. Энэ нь уулзалтын үеэр юу болсон талаар ирээдүйд буруу ойлголт бий болохоос зайлсхийнэ. Мөн хожим шүүгчийн талаар буруу бичигдсэн зүйлээс болж ичгүүртэй байдалд орохоос хамгаална.

Олон нийтийн итгэл зайлшгүй шаардлагатай

35. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь шүүгчийн зүгээс бүхэлдээ хараат бус байх нөхцөл гэж үздэг. Шүүгч нь талуудын хоорондын маргааныг шийдвэрлэхэд, түүний хараат бусаар шийдвэр гаргах чадварт нөлөөлөх буюу нөлөөлсөн гэж харагдах аливаа харилцаа, сонирхол, уруу татах зүйлээс ангид байх ёстой. Ингэж харвал, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь “хэн ч өөрөө өөрийнхөө хэргийн шүүгч байх ёсгүй” гэх суурь зарчмын дээд хувилбар юм. Мөн дээрх зарчим нь, маргааны талуудыг өөртөө багтаасан энэ нийгэм нь бүхэлдээ шүүхэд итгэхүйц байх ёстой гэж үзэхэд илүү чухал ач холбогдолтой.

1.3. Шүүгч нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын зүй бус харилцаа холбоо, нөлөөнөөс ангид байх төдийгүй тэдгээрээс үл хамаарах хөндлөнгийн этгээд байна.

ТАЙЛБАР

Эрх мэдэл, чиг үүргийн хуваарилалт

36. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын гол үзэл баримтлал бол эрх мэдэл хуваарилах зарчим буюу онол юм. Орчин үеийн ардчилсан улс дахь үндсэн, суурь баганын нэг нь шүүх эрх мэдэл бөгөөд чиг үүргээ нөгөө хоёр багана болох хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс бие даан хэрэгжүүлэх ёстой. Төрийн эрх мэдлийн салбар хоорондоо харилцан хүндэтгэлтэй хандаж, бие биеэ хүлээн зөвшөөрч, бусдынхаа зохих чиг үүргийг хүндлэн харилцах ёстой. Энэ нь тухайн эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгодог. Хууль тогтоох байгууллагын хувьд их, бага хэмжээний хууль батлах, тэдгээрийг хэрэгжүүлэх, ингэхдээ Үндсэн хууль болон тухайн улсын эрх зүйн эх сурвалж болох бусад хууль, олон улсын гэрээнд нийцүүлэх ёстой. Иймд шүүхээс нөгөө хоёр эрх мэдэлтэй харилцах чиг үүрэг, хариуцлага нь чухал ач холбогдолтой. Эдгээр чиг үүргээ биелүүлэх, хууль зүйн шийдвэрийнхээ бие даасан байдлыг хангахын тулд шүүх бусдад бүрэн ангид, чөлөөтэй байж, төрийн бусад салбарын зохисгүй харилцаа, нөлөөллөөс ангид байх ёстой. Иймээс бие даасан, хараат бус байдал нь төвийг сахих баталгаа болдог.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх олон нийтийн ойлголт

37. Шүүх эрх мэдлийн хувьд бие даасан, хараат бус байдалтай гэж ойлгогдох нь чухал бөгөөд, үүнд бие даасан, хараат бус байдлын шалгуурт ойлголт хамаардаг. Энэ нь, шүүхийн бие даасан, хараат бус байдлын бодит нөхцөл, баталгаа тухайн шүүхэд хэрхэн үйлчилж буй тухай ойлголт бөгөөд, харин шүүх хэрхэн үйлчилж буй тухай ойлголт биш юм. Хувь хүний хувьд, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд учрах сорилт нотлогдох шаардлагагүй гэж үздэг. Бие даасан, хараат бус байдалд учрах сорилтыг нотлох замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой ч, энэ нь хувь хүний хувьд төдийлөн ач холбогдолгүй байдаг. Харин үүний оронд, шийдвэр гаргах этгээд алдаа гаргасан эсэхийг тодорхойлох шалгуурыг шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын шалгууртай адилтган үздэг. Иймд, шүүх нь ухаалаг ажиглагчийн зүгээс өөрийгөө бие даасан, хараат бус гэж ойлгогдохуйц байх ёстой эсэх асуудал үүсэж байна. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь бодит нөхцөл, баталгааг хангасан эсэхээс гадна, шүүхийн чиг үүргийг бодитоор хэрэгжүүлэх оюун санааны нөхцөл, хандлага юм. Иймд, шүүхийг бие даасан, шүүгчийг хараат бус гэж үзэж буй эсэх бодит ойлголт нь бие даасан, хараат бус байдлын нэг шалгуур юм.

Зохисгүй харилцаа, нөлөөллийн жишээ

38. Шүүх буюу шүүхийн ёс зүйн зөвлөлдөх хорооноос тодорхойлсон, гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын “харилцаа, нөлөөлөл”-ийн жишээг дор харуулав. Ингэхдээ эдгээр жишээг зааварчилгаа маягаар бэлтгэв. Тохиолдол тус бүрийг ухаалаг ажиглагч хэрхэн ойлгохоос түүний үр дагавар хамаарна.

- 1) Хэрэв хууль тогтоогчийн зүгээс шүүгчид бичгээр хандаж, шүүгчийг хууль тогтоогчийн ашиг сонирхлын дагуу буюу шүүх бүрэлдэхүүний өмнөөс гэрлэлт цуцлалт, хүүхдийн асрамжийн хэргийг түргэн шуурхай, ашигтайгаар шийдвэрлэх талаар мэдэгдэхэд, шүүгч өөрөө буюу төлөөлөгчөөрөө дамжуулан хариу өгч, мэдээлсэн төдийд энэ нь шүүгчийн ёс зүйн зарчмаар хориглосон “шүүгчид нөлөөлөх этгээдээс бичиг хүлээн авах, харгалзан үзэх, хариу өгөх” харилцаа болно. Мөн хэрэг шийдвэрлэлтийн явц болон шийдвэр гаргах өдрийн талаар хууль тогтоогчид хариулах нь хориотой. Учир нь, энэ нь шүүхийн шийдвэрийг түргэн шуурхай гаргахад болон хэргийн оролцогчдод онцгой анхаарал хандуулахад хууль тогтоогчийн зүгээс шүүхэд нөлөөлөх чадвартай юм байна гэж харагдуулдаг.²²
- 2) Шүүгч чөлөөт цагаараа гүйцэтгэх эсхүл хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад бодлогын төвшний, өндөр зэрэглэлийн, цагийн ажил эрхлэхийг (жишээ нь шүүхийн шинэтгэлтэй холбоотой тусгай зөвлөхийн ажил) зөвшөөрөх нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчимтай үл нийцнэ. Гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын өндөр албан тушаалд шилжиж шүүгчийн чиг үүргийг тухайн чиг үүрэгтэй хольж хутгах явдлыг шүүхээс найрсгаар дэмжих нь эрх мэдэл хуваарилах зарчим, үзэл баримтлалаас зугтаж буй хэрэг юм. Энэ нь шүүгчийн хараат бусаар гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой шүүгчийн болон шүүн таслах ажлын талаарх ойлголтод нөлөөлөх магадлалтай. Нөлөөлөхгүй байсан ч, энэ нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс бие даасан

²² See United States of America, Commonwealth of Virginia Judicial Ethics Advisory Committee, *Opinion 2000-7*.

байх ёстой шүүхийн талаарх олон нийтийн ойлголтод сөрөг нөлөөтэй. Харин, шүүгч болохоос өмнө гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад ажиллаж байсан, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа тэдгээр байгууллагад ажиллах нь дээрхээс ялгаатай. Эдгээр тохиолдолд, шүүгчийг томилох, чөлөөлөх үйл явцад шүүгч, шүүхийн тогтолцоог ажиглагчийн хувьд тодорхой байж, нэг салбараас нөгөө салбарт ажиллах хил, заагийг маш тодорхой зохицуулсан байх шаардлагатай.²³

- 3) Хэрэв шүүгчийн эхнэр/нөхөр идэвхтэй улс төрч бол, шүүгчийн хувьд гэр бүлийн гишүүний зан үйлээс өөрийгөө тусгаарлах шаардлагатай. Ингэснээр, олон нийтийн зүгээс, шүүгчийг улс төрийн нэр дэвшигчийг дэмжиж байна гэж төсөөлөхгүй. Шүүгчийн эхнэр/нөхөр улс төрийн уулзалт, цуглаануудад оролцох үед, шүүгч түүнийг дагалдаж болохгүй. Мөн шүүгчийн гэрт тийм уулзалт, ярилцлага зохиож болохгүй. Хэрэв шүүгчийн эхнэр/нөхөр тийм үйл ажиллагааг хүчлэн зохион байгуулж буй бол, шүүгчийн зүгээс оролцогчдод харагдахгүй байх, шаардлагатай бол тухайн арга хэмжээний үеэр гэртээ байхгүй байх зэргээр өөрийгөө тус үйл ажиллагаанаас хамааралгүй байлгах ухаалаг арга хэмжээ авах ёстой. Эхнэр/нөхөр нь улс төрийн аливаа хандив өгөх бол, шүүгчийн нэр, хөрөнгийг оролцуулахгүй, өөрөөр хэлбэл шүүгчтэй хамтран эзэмшдэг данснаас бус зөвхөн өөрийнхөө нэрээр, өөрийнхөө хөрөнгөнөөс өгөх ёстой бөгөөд ийм зориулалттай хөрөнгө, дансаа тусдаа байлгах шаардлагатай. Ингээгүй нь шүүхийн буюу шүүх эрх

²³ See United States of America, The Massachusetts Committee on Judicial Ethics, *Opinion No.2000-15*.

мэдлийн нэр хүндийг өсгөхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.²⁴ Харин, шүүгчийн хувьд эхнэр/нөхрийн хамт парламентын үйл ажиллагааны нээлт, төрийн хүлээн авалт зэрэг цэвэр төрийн ёслолын шинжтэй үйл ажиллагаанд оролцох тохиолдол, тухайн нөхцөл байдлаас хамаарч зохисгүй гэж тооцогдохгүй байж болно.

- 4) Хууль зүйн сайдын зүгээс шүүгчийг шүүн таслах ажиллагаанд оролцсоных нь төлөө хүндэтгэлийн шагналаар шагнах буюу тийм шагналд тодорхойлох нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчмын зөрчилд тооцогдоно. Шүүгчийн үүргээ гүйцэтгэж байх үед, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шүүхийн тэргүүлэх оролцоогүйгээр, шүүгчийн шүүн таслах ажиллагааг ялгавартайгаар үнэлэх нь шүүх бие даасан, шүүгчийн хараат бус байдалд аюултай.²⁵ Харин тухайн үеийн засгийн газрын бие даасан байгууллагаас шүүгчид хүндэтгэлийн шагнал өгөх буюу тийм шагналд тодорхойлох нь тухайн нөхцөл байдлаас хамаарч зохисгүй гэж тооцогдохгүй байж болно.

- 5) Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаатай нь холбоотойгоор шүүгчид “шагнал” хэлбэрээр төлбөр төлөх (тухайлбал тодорхой урамшуулал олгох) нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцэхгүй.²⁶

²⁴ See United States of America, The Massachusetts Committee on Judicial Ethics, *Opinion No.1998-4*.

²⁵ Decision of the Constitutional Court of Hungary, 18 October, 1994, Case No.45/1994, (1994) 3 *Bulletin on Constitutional Case-Law*, 240.

²⁶ Decision of the Constitutional Court of Lithuania, 6 December 1995, Case No.3/1995, (1995) 3 *Bulletin on Constitutional Case-Law*, 323.

- б) Шүүн таслах ажиллагааны явцад олон улсын гэрээг тайлбарлахтай холбоотой асуудал гарч, шүүх өөрөө олон улсын гэрээг тайлбарлах нь шүүн таслах ажиллагаанд хамаарахгүй гэж үзэж, улмаар гадаад хэргийн сайдын дүгнэлт, зөвлөмжийг авч, түүний дагуу шийдвэр гаргавал, энэ нь шүүхээс хууль зүйн асуудлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын төлөөлөгчийн заавраар шийдвэрлэсэн гэж үзэхэд хүргэнэ. Сайдын зүгээс шийдвэрийн арга замыг дэвшүүлэх байдлаар, эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дагавартай холбогдсон үйл баримт болон тухайн бэрхшээл маргааны талуудад нээлттэй биш байгаа нь, уг хэргийг бүрэн эрхтэй бие даасан шүүх хянан шийдвэрлээгүй гэж үзэх нөхцөл болно.²⁷



²⁷ *Beaumartin v France*, European Court of Human Rights, (1984) 19 EHRR 485.

1.4. Шүүгч нь албан үүргээ гүйцэтгэж, төвийг сахин шийдвэр гаргахдаа бусад шүүгч, шүүхийн ажилтнаас хараат бус байна.

ТАЙЛБАР

Бусад шүүгчээс хараат бус байх ёстой

39. Шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шүүгч өөрийн дотоод ухамсартай холбоотой бие даасан хэмжүүрийг хэрэглэдэг.²⁸ Тиймээс, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь шүүхийг төрийн бусад эрх мэдлийн байгууллагаас бие даасан байхыг шаардаад зогсохгүй, шүүгчийг бусад шүүгчээс хараат бус байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь гаднын зохисгүй нөлөөнөөс ангид байхаас гадна, бусад шүүгчийн үйлдэл, зан төлөвийн зохисгүй нөлөөнөөс ангид байхаас хамаардаг. Хэдийгээр, шүүгч заримдаа ээдрээтэй асуудал дээр хамт ажиллагсдынхаа “ухаан бодлыг сонгох” тусламж авдаг ч, шүүхийн шийдвэр гаргах нь хувь шүүгчийн үүрэг хариуцлага бөгөөд, энэ нь дээд шатны шүүхийн шүүгч бүрт нэгэн адил хамаатай.

Шүүхийн шаталсан тогтолцоо нь шүүгчид нөлөөлөх ёсгүй

40. Шүүгч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хэн нэгний ажилтан бус байна. Шүүгчийг зөвхөн төрийн албан хаагч гэж хэлж болох бөгөөд, шүүгч хууль болон өөрийн дотоод итгэл үнэмшлийг тогтмол ашиглаж байх үүрэгтэй. Шүүгч аливаа хэргийг шийдвэрлэхдээ давж заалдах тогтолцооны нөлөөнөөс ангид байж, шүүхийн гаднах болон дотоод дахь гуравдагч этгээдийн

²⁸ Roger Perrot, “The role of the Supreme Court in guaranteeing the uniform interpretation of the law”, Sixth Meeting of the Presidents of European Supreme Courts, Warsaw, October 2000.

аливаа заавар, тушаалыг биелүүлэхгүй байх нь нэгэнт тогтсон аксиом юм. Шүүхийн шаталсан тогтолцоо болон ямар нэгэн төвшин, зэрэглэлийн ялгаа нь шүүгч шийдвэрээ чөлөөтэй, гаднын үзэл бодол, бусдын нөлөөнд авталгүйгээр гаргах эрхэд халдах арга зам байх ёсгүй.

Шүүгч шийдвэрлэсэн хэргийнхээ талаар тайлагнах үүрэггүй

41. Хэн нэгэнд, ялангуяа шүүгчийн үйлдэлд гомдолтой үлдэх хэн нэгэнд тайлагнах үүрэгтэй байх нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нийцэхгүй. Хуульд заасны дагуу шүүхийн үндэслэл, бусад журамд тийнхүү тайлбарлах үүрэг хүлээснээс бусад тохиолдолд, шүүгч нь хэргийн талаар бусдад тайлагнах үүрэггүй бөгөөд бусад шүүгчдэд ч нэгэн адил тайлагнах ёсгүй. Хэрэв шийдвэр нь сахилгын зөрчлийг нотлоход огт хамаарахгүй бол шүүгч “тайлагнах” үүрэггүй ч, хуулийн дагуу явуулж буй албан ёсны хянан шалгах ажиллагаанд тайлбар гаргана.

Хэргийг зохих ёсоор хянах нь шийдвэрийн үр ашгийг нэмэгдүүлдэг

42. Шүүхийн хяналтын тогтолцоотой орнуудын шүүгчид тодорхой шийдвэрийнхээ ач холбогдол, тохиромжтой байдалд санаа зовох ёсгүй. Мөн шүүгчийн шийдвэрлэсэн хэргийг хуулийн дагуу анхааралтай хянасны үндсэн дээр шийдвэрлэх үүргээ дээд шатны шүүх зохих ёсоор биелүүлэхдээ бүтээмж, үр ашигтай байдалд анхаарал хандуулах ёсгүй.

1.5. Шүүгч нь албаны үүргээ хэрэгжүүлэхдээ шүүхийн үйл ажиллагааны болон институтийн бие даасан байдлын баталгааг хангах, бэхжүүлэхийг эрмэлзэнэ.

ТАЙЛБАР

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг доройтуулах гэсэн оролдлогыг эсэргүүцэх ёстой

43. Шүүгч нь түүний албаны болон үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг доройтуулах гэсэн аливаа оролдлогоос сэрэмжлэх ёстой. Гэхдээ шүүхийн бие даасан байдлыг алдагдуулах эрсдэлгүй бол, шүүхийн зохион байгуулалтыг өөрчлөх санал бүрийг эсэргүүцэх шаардлагагүй. Шүүгч нь өөрийн хараат бус байдлын баттай хамгаалагч байх ёстой.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаар олон нийтийн ойлголттой байх байдлыг дэмжих хэрэгтэй

44. Хүн бүр шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын үзэл баримтлал болон тэр нь шүүхийн чиг үүрэгт хэрхэн нөлөөлдөг талаар сайн ойлголтгүй байдаг. Үүнийг шүүгчийн зүгээс хүлээн зөвшөөрөх ёстой. Иймээс, шүүхийн талаарх олон нийтийн итгэлийг бууруулах буруу ойлголт төрүүлэхгүйн тулд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэх талаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэх нь засгийн газрын төдийгүй шүүхийн өөрийн чухал чиг үүрэг болдог. Олон нийтийн хувьд, хэвлэл мэдээллийн хэрэгслээс тэр болгон шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчмын талаар бүрэн тэнцвэртэй мэдээлэл авдаггүй. Учир нь, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой тойм, олон нийтийн

мэтгэлцээнд шүүгчийг хамгаалах ёстой гэх явцуу утгаар, буруу дүрсэлсэн байх нь түгээмэл. Тиймээс шүүгчийн хувьд, олон нийтийн ашиг сонирхлын үүднээс, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын гол ач холбогдлыг олон нийтэд ойлгуулахад туслах зорилгоор боломж бүрийг ашиглах ёстой.

1.6. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах гол тулгуур болох шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхийн тулд, шүүгч нь ёс зүйн өндөр хэм хэмжээг үлгэр жишээчээр даган мөрдөж, өөрийн биеэр батлан үзүүлнэ.

ТАЙЛБАР

Олон нийтийн итгэлийг хадгалахад шүүгчийн ёс зүйн өндөр стандарт зайлшгүй шаардлагатай

45. Шүүхийн шийдвэрийг олон нийт хүлээн авч зөвшөөрөх эсэх нь шүүгчийг шударга, хараат бус гэх олон нийтийн итгэлээс хамаардаг. Энэ нь бас шүүхийн ёс зүйн өндөр стандартыг шүүгч хэрхэн мөрдөж буйгаас хамаарна. Тиймээс, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг батлах нэг чухал бүрдэл болох шүүгчийн ёс зүйн өндөр стандартыг шүүгч даган мөрдөж, дэмжих ёстой.

Шүүх хуралдаанд тавигдах наад захын шаардлага

46. Шүүхийн ёс зүйн өндөр стандарт нь шүүх хуралдааны наад захын баталгааг бүрдүүлэхийг шаарддаг. Тухайлбал, хэргийн оролцогчдын дараах эрхийг шүүгч хүлээн зөвшөөрөх ёстой.²⁹ Үүнд:

- 1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, зорилгын талаар холбогдох мэдээлэл авах;
- 2) Тухайн хуралдаанд бэлтгэх бололцоотой байх;
- 3) Бичгээр болон аман хэлбэрээр өөрийн үндэслэл, нотлох баримтаа танилцуулах, эсрэг талын үндэслэл, нотлох баримттай танилцах;
- 4) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд

²⁹ See Draft UN Body of Principles on the Right to a Fair Trial and a Remedy, UN document E/CN.4/Sub.2/1994/24 of 3 June 1994.

- өмгөөлөгч буюу өөрийн сонгосон чадварлаг этгээдтэй зөвлөлдөх, түүгээр төлөөлүүлэх;
- 5) Хэрэв хэргийн оролцогч шүүхэд хэлэлцдэг, хэрэглэдэг хэл мэдэхгүй бол, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд хэлмэрчийн туслалцаа авах, зөвлөлдөх;
 - 6) Зөвхөн нээлттэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр талуудын мэдэж буй нотлох баримтад үндэслэн хэргийн оролцогчийн эрх зүйн байдалд нөлөөлөх;
 - 7) Шийдвэрийг хойшлуулахгүйгээр гаргуулах, өөрт холбогдох шийдвэрийн талаар зохих хэлбэрээр мэдээлэл авах, шийдвэрийн үндэслэлийг тайлбарлуулах;
 - 8) Тухайн хэргийг эцсийн шатны шүүх шийдвэрлэснээс бусад тохиолдолд, шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах.

Зөвхөн хуулийн дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарлана

47. Шүүгч нь хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх, эрх чөлөөг хязгаарлаж болохгүй. Шаардлагатай, хангалттай үндэслэл байгаа эсэх талаарх бодит үнэлгээгүйгээр, шүүгч захирамж гаргаж бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлаж болохгүй. Өөрөөр хэлбэл худал хуурмаг буюу холбогдох хуулийг буруу хэрэглэж цагдан хорих шийдвэр гаргах нь дур зоргын авир төдийгүй, холбогдох нотлох баримтыг бодитой үнэлэхгүйгээр шүүх шийдвэр гаргасан асуудал юм.

Яллагдагч, шүүгдэгчийн эрх

48. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шударгаар шүүлгэх эрхийг тодорхойлсон байдаг. Үүнд “хүн бүр” шүүхийн өмнө “эрх тэгш” бөгөөд өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх болон иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа, хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий,

бие даасан, төвийг сахисан шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэйг хүлээн зөвшөөрсөн.³⁰

49. Пактын 14 дүгээр зүйлийн 2-7 дахь хэсэг болон 15 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шалгах, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шударгаар шүүх ерөнхий зарчмыг хэрэглэх дараах тусгай нөхцөлийг тусгасан. Эдгээр нөхцөлийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд буюу урьдчилсан үйл явц, хянан шалгах төдийгүй шүүх хуралдааны үеэр хэрэглэнэ. Гэхдээ эдгээр нөхцөл нь наад захын баталгаа бөгөөд шүүн таслах ажиллагааны шударга байдлыг бүрэн хангах нөхцөл болохгүй.

- 1) Гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх;
- 2) Шийтгэгдсэн буюу цагаатгагдсан нэг гэмт хэрэгт нэг удаа л шүүлгэх эрх;
- 3) Ямар гэмт хэрэгт буруутгагдаж буй талаар болон оногдуулах ялын талаар өөрийн ойлгох хэлээр нэн даруй, нарийвчилсан мэдээлэл авах эрх;
- 4) Өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэх хангалттай хугацаа, бололцоотой байх эрх;
- 5) Сонгосон өмгөөлөгчтэйгөө харилцах эрх;
- 6) Зүй бус хойшлуулалтгүйгээр шүүлгэх эрх;
- 7) Хэргийг нь шүүх ажиллагаанд биеэр оролцох эрх;
- 8) Өөрийгөө өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх;

³⁰ For an authoritative interpretation of ICCPR 14, see Human Rights Committee, General Comment 13 (1984). A revised and more extensive general comment is expected shortly. For a comparative analysis of the jurisprudence on the right to a fair trial, see Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence* (Cambridge University Press, 2002), pp. 478-594.

- 9) Шүүн таслах ажлын шаардлагаар ямар ч тохиолдолд өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрх;
- 10) Өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах эрх;
- 11) Эсрэг гэрчтэй адил нөхцөлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах болон шалгуулах эрх;
- 12) Шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагч, хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх;
- 13) Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийн бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй байх эрх;
- 14) Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний нас болон засаж хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлүүштэйг харгалзсан байх эрх;
- 15) Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдэхүй байвал хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй, түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байсан ялаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй.
- 16) Нээлттэй шүүлгэх эрх;
- 17) Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлсэн хүн бүр шийтгэл болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.

Ял шийтгэлтэй холбоотой эрх

50. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйл (5 дахь хэсэг), 7 дугаар зүйл, 14 дүгээр зүйл (7 дахь хэсэг), 15 дугаар зүйлд ял шийтгэгдсэн хүмүүсийн дараах эрхийг хүлээн зөвшөөрсөн. Үүнд:

- 1) Гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байсан ялаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй.
- 2) Үйлдсэн гэмт хэрэгтээ эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тухайн гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.
- 3) Хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон шийтгэлээр шийтгүүлэхгүй байх эрхтэй.
- 4) Цаазаар авах ялыг халаагүй орнуудад арван найман нас хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, тухайн гэмт хэрэг үйлдэх үед дээрх ял хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бол хуулийн дагуу оногдуулж болно.

ҮНЭТ ЗҮЙЛ 2: ТӨВИЙГ САХИХ БАЙДАЛ

Зарчим:

Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэхэд төвийг сахих байдал нь зайлшгүй чухал ач холбогдолтой. Энэ зарчмыг шүүхийн шийдвэрт төдийгүй тухайн шийдвэрийг гаргах зэрэг шүүн таслах ажилд нэгэн адил баримтална.

ТАЙЛБАР

Бие даасан, хараат бус байдал нь төвийг сахих байдлын зайлшгүй урьдчилсан нөхцөл болох нь

51. Бие даасан, хараат бус байдал болон төвийг сахих байдал нь тусдаа, ялгаатай үнэт зүйлс юм. Гэхдээ эдгээр үнэт зүйл нь шүүхийн албыг бэхжүүлэхэд харилцан хамааралтай. Бие даасан, хараат бус байдал нь төвийг сахих байдлын зайлшгүй урьдчилсан буюу угтвар нөхцөл болдог. Тодруулбал, шүүгч хараат бус байсан ч, төвийг сахихгүй байж болдог (тодорхой хэрэг маргааныг шийдэхэд), харин хараат бус байдалгүй бол албан үүргийн хувьд төвийг сахих бололцоогүй.³¹

Төвийг сахих байдлын талаарх ойлголт

52. Төвийг сахих байдал нь шүүгчээс шаарддаг үндсэн чанар бөгөөд шүүхийн суурь шинж юм. Төвийг сахих нь үйл баримтын хувьд төдийгүй, тийнхүү төвийг сахиж буй эсэх талаарх бодитой ойлголтод нэгэн адил хамаарна. Хэрэв алагчлах байдал байна гэх бодит төсөөлөл бий болбол, дургүйцэл,

³¹ See *Reference re: Territorial Court Act (NWT)*, Northwest Territories Supreme Court, Canada, (1997) DLR (4th) 132 at 146, per Justice Vertes.

шударга бус байдлыг мэдэрч, улмаар шүүхийн тогтолцоонд итгэх итгэлийг алдагдуулна. Төвийг сахих байдлын талаарх ойлголтыг ухаалаг ажиглагчийн стандартаар хэмждэг. Шүүгч төвийг сахихгүй байна гэх ойлголт нь сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, шүүгчийн албан үүргээ гүйцэтгэж буй зан үйл, түүний нийгмийн харилцаа, үйл ажиллагаа буюу гишүүнчлэл зэрэг олон арга замаар бүрдэх боломжтой.

Төвийг сахих байдлын шаардлага

53. Европын хүний эрхийн шүүхээс төвийг сахих шаардлагын хоёр үзэл баримтлалыг тайлбарласан. Нэгдүгээрт, шүүх субъектив байдлаар төвийг сахих ёстой. Жишээлбэл, шүүх бүрэлдэхүүний аль ч гишүүн ямар нэг хувийн сэдлээр ялгаварлах, сэжиглэх байдал гаргах ёсгүй. Үүний эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд л хувийн зүгээс төвийг сахисанд тооцогдоно. Хоёрдугаарт, шүүх нь объектив байдлаар төвийг сахих ёстой. Жишээлбэл, энэ талаар ямар нэг хууль ёсны эргэлзээ гаргахгүй байх хангалттай баталгааг санал болгох ёстой.³² Энэ шалгуурын дагуу, шүүгчийн зан үйл нь түүний төвийг сахих байдлын талаар эргэлзэхэд хүргэх ёсгүй. Үүнтэй холбоотойгоор, бусдад хэрхэн харагдах байдал ч нэгэн адил чухал юм. Ардчилсан нийгмийн шүүхүүд олон нийтэд, тэр дундаа яллагдагч, шүүгдэгч этгээдэд итгэл үнэмшил төрүүлэхүйц байх ёстой. Иймд, шүүгч төвийг сахихгүй гэж үзэх хууль ёсны үндэслэл байвал, тухайн шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой.³³

Яллагдагч, шүүгдэгчийн байр суурь

54. Яллагдагч, шүүгдэгчийн байр сууринаас тухайн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч төвийг сахихгүй

³² *Gregory v United Kingdom*, European Court of Human Rights, (1997) 25 EHRR 577.

³³ *Castillo Algar v Spain*, European Court of Human Rights, (1998) 30 EHRR 827.

байна гэж үзэх нь хууль ёсны, үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэхэд чухал хэдий ч, илэрхий зүйл биш юм. Илэрхий зүйл бол, нийгмийн төлөөлөл болох ухаалаг ажиглагчийн зүгээс тухайн хэргийг хуулийн дагуу, бодит үндэслэлтэйгээр шийдвэрлэнэ гэдэгт эргэлзээ, болгоомжлол төрүүлэхгүй байх явдал юм.

Хэрэглэх нь:

2.1. Шүүгч нь бусдад давуу байдал олгох, шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүйгээр албан үүргээ хэрэгжүүлнэ.

ТАЙЛБАР

Алагчлах байдал гаргаж байна гэх ойлголт төрүүлэх нь олон нийтийн итгэлийг эвддэг

55. Хэрэв шүүгч бусдад алагчлах байдал гаргаж байна гэж харагдвал шүүхэд итгэх олон нийтийн итгэл буурна. Тиймээс шүүгч нь шийдвэр гаргахад гадаад хүчин зүйлийн нөлөө орсон гэж хардуулах бүх үйлдлээс зайлсхийх ёстой. Ийм хардлага нь шүүгч хэргийн нэг тал буюу үр дүнгийн талаар ашиг сонирхол бүхий этгээдтэй хувийн харилцаатай байх зэргээс үүсдэг.

Алагчлах байдлын талаар ойлгох чадвар

56. Төвийг сахихын тулд зөвхөн бодит алагчлал, гадуурхлаас зайлсхийх бус, тийм ойлголт төрүүлэхгүй байх нь чухал юм. Энэ нь ихэвчлэн шүүх зөвхөн ажлаа хийх бус, хийсэн ажлаа ил тод харуулах ёстой гэдгээс тодорхой харагддаг.³⁴ Ихэвчлэн, ухаалаг ажиглагчийн зүгээс шүүгч төвийг сахихгүй байна гэж бодитоор буюу итгэл үнэмшилтэйгээр харж буй эсэх шалгуур тогтсон байдаг. Алагчлалыг ойлгох чадвартай эсэхийг ухаалаг ажиглагчийн үзэл бодлоор үнэлдэг.

“Алагчлал, гадуурхал”-ын утга санаа

57. Алагчлал, гадуурхлыг аль нэг талд буюу өөр, тодорхой үр дүнгийн талд орох, хазайх, тонгойх, бөгтийх, сонирхол нэгтэй байх гэж тодорхойлдог. Үүнийг шүүхээс хэрэг

³⁴ *R v Sussex Justices, ex parte McCarthy*, King’s Bench Division of the High Court of Justice of England and Wales [1924] 1 KB 256 at 259, per Lord Chief Justice Hewart.

хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхдээ, асуудал буюу шалтгааныг тухайн нэг этгээдийг гэм буруутай гэх бодлоо орхихгүйгээр, тодорхой аргаар нэг талд ашигтай шийдэхийг илэрхийлдэг. Алагчлах нь нэг тал руу гуйвсан буюу өнгөн дүгнэлт хийх оюун санааны нөхцөл, хандлага, үзэл бодол бөгөөд шүүгч тодорхой хэргийг төвийг сахин шийдвэрлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй гэдгийг харуулдаг.³⁵ Гэвч, алагчлах үзлийн мөн чанарыг баттай болгохгүйгээр үүнийг хэлэх боломжгүй. Жишээ нь, шүүгч хүний үндсэн эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмын дагуу хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас өөр арга замыг илэрхийлбэл, түүнийг хуулиар хориглосон алагчлах үзэл гаргасан гэх ойлголт төрүүлсэн гэж үзэхгүй.

Алагчлал, гадуурхлын илрэл

58. Алагчлах нь өөрөө үгээр буюу үйлдлээр илэрч болдог. Энэ нь зүйрлэл, үл тоох байдал, нэр хоч, сөрөг ойлголт, нас хүйс, соёл, арьс өнгө зэрэг хоорондоо холбоотой хэвшмэл ойлголт дээр суурилан хошигнох, заналхийлэх, арьс өнгө, үндэс угсаа болон гэмт хэргийн хамаарлаар айлгах, дайсагнах үйлдэл, хувь хүний онцлог шинж чанартай холбоогүй мэдээлэл хүсэх зэргээр илэрдэг. Мөн алагчлах, гадуурхах үзэл нь шүүхэд болон шүүхээс гадуурх биеийн хэл, харагдах байдал, зан үйлээр илэрч болдог. Биеийн үйлдлээр гэрчид үл итгэж байгаагаа харуулах, улмаар шүүхийн иргэдийн төлөөлөгчид зохисгүй хэлбэрээр нөлөөлөх байдлаар илэрдэг. Нүүрний хувирлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талууд, хуульчид, иргэдийн төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад этгээдийг алагчилж буйг харуулах боломжтой. Алагчлах, гадуурхах нь хэргийн нэг тал, гэрч, өмгөөлөгчийн эсрэг шууд чиглэсэн байж болдог.

³⁵ *R v Bertram* [1989] OJ No.2133 (QL), quoted by Justice Cory in *R v S*, Supreme Court of Canada, [1997] 3 SCR 484, paragraph 106.

Жигшил, зэвүүцлийг зохисгүйгээр ашиглах нь алагчлал, гадуурхлын илрэл мөн

59. Шүүн таслах ажиллагааны үеэр жигшил зэвүүцэлтэй байх, гарах боломжтой тул шүүгч шүүх хуралдааны танхимын уур амьсгалыг хянаж, дэг сахиулахад анхаарна. Учир нь шүүгч эрүүгийн хэргийн мөн чанарт тохирсон үр нөлөөтэй шийтгэл оногдуулах үүрэгтэй бөгөөд зөвхөн хуулийн хүчин төгөлдөр болсон, шаардлага хангасан, үндэслэлтэй шийдвэрийн дараа жигшил зэвүүцлийг хамгийн сүүлийн арга болгон ашиглаж болно. Энэ бол маш анхаарал, болгоомжлол шаардсан ажил. Жигшил, зэвүүцлийг урвуулан ашиглах нь алагчлал, гадуурхлын илрэл болдог. Энэ нь шүүгч өөртөө тавих хяналтаа алдах, хувийн ашиг сонирхол хөндөгдөх, ялангуяа ашиг сонирхлын зөрчил үүссэн оролцогч, өмгөөлөгч, гэрчийн эсрэг хариу арга хэмжээ авахад илэрдэг.

Алагчлал, гадуурхалд тооцогдохгүй зүйлс

60. Шүүгчийн хувийн үнэт зүйл, философи, хуулийн талаарх итгэл үнэмшил нь алагчлалд тооцогдохгүй. Тухайн хэрэгтэй шууд холбоотой эрх зүйн болон нийгмийн асуудлын тухай шүүгч ерөнхий үзэл бодолтой байх нь түүнийг шүүх хуралдаанд оролцохоос татгалзах нөхцөл болохгүй.³⁶ Алагчлах байдал гаргахгүй бол, бусад үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх боломжтой. Үүнийг “шүүгч цэвэрхэн хуудас шиг байх ёстой” гэж хэлдэг.³⁷ Шүүгч оюун санааны хувьд тусгаарлагдсан, нотлох баримт болгоныг хянан үзэхгүй гэж харагдаж буйгаас бусад тохиолдолд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан нотлох баримтын талаарх шүүгчийн үнэлгээ, тайлбар нь хориглох зүйлд хамаарахгүй.

³⁶ See Jeffrey M. Shaman, Steven Lubet and James J. Alfini, *Judicial Conduct and Ethics*, 3rd ed. (Charlottesville, Virginia, The Michie Company, 2000).

³⁷ *Laird v Tatum*, United States Supreme Court (1972) 409 US 824.

2.2. Шүүгч нь шүүн таслах ажил төдийгүй шүүхээс гадуурх өөрийн үйл ажиллагаагаар олон нийт, мэргэжлийн хуульчид, шүүх хуралдааны оролцогч талуудаас шүүх болон шүүгчийн төвийг сахих байдалд итгэх итгэлийг хангаж, бэхжүүлнэ.

ТАЙЛБАР

Шүүгч торгуулийн хэмжээг тэнцвэртэй тогтоох ёстой

61. Шүүгч нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэг журам, шүүхийн процессыг урвуулан ашиглахгүй байх нөхцөлийг хангана. Энэ зорилгоо хүрэхийн тулд зарим талаар тууштай, шийдэмгий арга хэмжээ авах шаардлага тулгардаг. Иймээс шүүгчийн зүгээс процессыг үр дүнтэй явуулаад зогсохгүй, ухаалаг ажиглагчийн тархинд “төвийг сахихгүй байна” гэх аливаа сэтгэгдэл төрүүлэхгүйн үүднээс торгуулийн хэмжээг тэнцвэртэй тогтоох хэрэгтэй болдог. Шүүгч нь ухаалаг ажиглагчийн санаанд “шүүхийн албан үүргээ гүйцэтгэхдээ төвийг сахихгүй байна” гэх бодит сэжиг төрүүлэх аливаа үйлдлээс зайлсхийх ёстой. Энэ нь нь зөвхөн шүүх дэх хэргийн оролцогчдод бус, шүүхийн талаарх олон нийтийн итгэлд нөлөөлдөг.

Шүүх дэх зайлсхийх ёстой үйлдэл

62. Хэргийн оролцогчид өндөр хүлээлттэй байдаг. Зарим нь тэдний талд ашиггүй шийдвэр гарахад тэр даруй л огт шударгаар хандаагүй, алагчилсан гэж үздэг. Иймд, дээрх ойлголтод хүргэх буюу эргэлзээг хамгийн бага төвшинд байлгах үүднээс хангалттай үндэслэлтэй шийдвэр гаргахад чиглэсэн бүхий л хүчин чармайлтыг шүүгч гаргах ёстой. Шүүгч нь алагчилж, гадуурхсан гэх ойлголт төрүүлэх зан үйлээс татгалзахын тулд

маш сэрэмжтэй байх ёстой. Өмгөөлөгчийг тохиромжгүйгээр шүүмжлэх, хэргийн оролцогч, гэрчүүдийг доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, урьдчилсан дүгнэлт гаргаж буй байдалтай мэдээлэл хийх, биеэ барихгүй байх, тэвчээргүй зан гаргах зэрэг нь төвийг сахих байдлыг алдагдуулдаг тул, эдгээр үйлдлээс шүүгч нь болохоор зайлсхийх ёстой.

Шүүх хуралдааны явцад байнга хөндлөнгөөс оролцохоос з айлсхийх ёстой

63. Шүүгч нь асуудлыг тодруулах үүднээс асуулт тавих эрхтэй боловч, байнга хөндлөнгөөс нөлөөлөх, иргэний маргааны оролцогчдын эрх, үүрэг, эрүүгийн хэрэг дэх яллах чиг үүрэг, тухайн хэргийг шийдвэрлэх дүгнэлтэд хүрсэн мэт ойлголт төрүүлэх асуулт асуух, өмгөөлөгч, гэрч, зарим үед шүүгчийн байр сууринаас хандаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлбэл хэргийн оролцогч шударгаар шүүлгэж чадахгүй.

Нэг талын ашиг сонирхол бүхий харилцаа тогтоохоос зайлсхийх ёстой

64. Төвийг сахих зарчим нь шүүгч болон хэргийн аль нэг тал, тэдгээрийн төлөөлөгчид, гэрчүүд, шүүхийн иргэдийн төлөөлөгчд хоорондоо хувийн харилцаа тогтоохыг ерөнхийдөө хориглодог. Хэрэв шүүгч хуралдаанд оролцогчидтой хувийн харилцаа бол, энэ тухай хэргийн бусад оролцогчдод бүрэн гүйцэд, нэн даруй мэдэгдэж, шүүхийн тэмдэглэлд зохих ёсоор тусгуулна.

Шүүхээс гадуурх зайлсхийх ёстой үйлдэл

65. Шүүгч нь шүүхээс гадуур ч нэгэн адил, төвийг сахихгүй байна гэх ойлголт төрүүлэх үг, үйлдлээс зайлсхийх ёстой. Шүүгчийн зүгээс хүлээн зөвшөөрөхүйц гэж үзэж буй шүүгчийн холбоо, бизнесийн ашиг сонирхол нь шүүгч төвийг

сахидаг гэх ойлголтыг сарниулж болдон. Нэг талын ашиг сонирхол бүхий улс төрийн бүхий л үйл ажиллагаа, нэгдэл холбоо нь шүүхийн албаны талаарх ойлголтыг үгүй хийдэг. Шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа, олон нийтийн дунд маргаан дэгдээсэн асуудлаар шүүхээс гадуурх мэдэгдэл нь төвийг сахих байдлыг сулруулж, улмаар нэг талаас шүүх, нөгөө талаас гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын хоорондын харилцааны мөн чанарын талаар олон нийт төөрөгдөхөд хүргэдэг. Тухайлбал, шүүгчийн улс иөрийн үйл ажиллагаа, олон нийтийн өмнө хийсэн мэдэгдэл нь нэг талыг нөгөөгөөс нь ялган сонгож буй хэрэг юм. Хэрэв алагчилж байна гэх ойлголт нэгэнт батажсан бол, шүүгчийн үйл ажиллагаа нь шүүмжлэл, эсэргүүцлийн бай болно. Товчхондоо, шүүгч нь шүүхийн давуу байдлыг ашиглаж улс төрийн үйл ажиллагаанд оролцох нь шүүхийн төвийг сахих байдлын талаарх олон нийтийн итгэлийг эрсдэлд оруулна. Гэхдээ энд зарим нэгэн ялгаатай зүйлс бий. Тодруулбал, шүүгч нь зарим тохиолдолд шүүх эрх мэдлийг хамгаалж мэдэгдэл гаргах, олон нийт болон мэргэжлийн хүмүүст хууль, шүүхийн шийдвэртэй холбоотой асуудлаар тайлбараар хийх, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёсыг хамгаалах үйлдэл хийх боломжтой. Хэдийгээр ийм тохиолдлууд гардаг боловч, шүүгч улс төрийн ашиг сонирхлын үүднээс гэж үзэж болох маргаантай асуудлаас аль болох зайлсхийх ёстой. Шүүгч тухайн хүний улс төр, нийгмийн талаарх үзэл бодлоос үл хамааран бүх хүнд үйлчилдэг. Иймд шүүгчийн зүгээс итгэл, найдлагыг хадгалахыг хичээх ёстой бөгөөд ингэх ч боломжтой юм.

2.3. Шүүгч нь шийдвэр, шүүн таслах ажлын үндэслэлтэй байдлыг хангаж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй мөрдөх замаар шүүх хуралдаан болон шүүхийн шийдвэр гаргахад шүүгчийг татгалзах үндэслэл, нөхцөл гаргахгүй байхыг хичээн ажиллана.

ТАЙЛБАР

Байнга татгалзахаас зайлсхийх ёстой

66. Шүүгч нь шүүхэд ирсэн хэргийг шийдвэрлэх ёстой. Гэхдээ хэргийн оролцогчийн эрхийг хамгаалах, шүүхийн шударга байдлын талаарх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд татгалзан гарах тохиолдол байж болно. Нөгөөтээгүүр, байнга татгалзан гарах нь тухайн шүүх бүрэлдэхүүн, шүүгчид олон нийт таагүй хандах, шүүгчийн хамтран ажиллагсдад үндэслэлгүй дарамт учруулах болно. Энэ нь тухайн хэргийг хүлээн авах, шийдэх эсэхээ шүүгч өөрийн дураар шийддэг гэх сэтгэгдлийг хэргийн оролцогчдод төрүүлж болох бөгөөд энэ нь хүсмээргүй зүйл юм. Тиймээс, шүүгч хүн шүүгчийн албан үүрэгтэй зөрчилдөх магадлалыг хамгийн бага байлгахуйцаар өөрийн хувийн болон ажил хэргийн асуудлаа зохицуулах ёстой.

Ашиг сонирхлын зөрчил

67. Шүүгчийн буюу түүнтэй ойр хэн нэгний хувийн ашиг сонирхол нь шүүгчийн төвийг сахин шийдвэр гаргах үүрэгтэй зөрчилдөх үед ашиг сонирхлын зөрчил үүсдэг. Шүүх төвийг сахих гэдэгт, шүүгч бодитоор төвийг сахихаас гадна тийнхүү төвийг сахиж байна гэж ухаалаг ажиглагч ойлгож буйг хамааруулан ойлгоно. Шүүх дэх ашиг сонирхлын зөрчилд, шүүгчийн хувийн ашиг сонирхол нь төвийг сахиж шийдвэр

гаргах үүрэгтэй зөрчилдөх, ухаалаг ажиглагчийн зүгээс ашиг сонирхлын зөрчил бодитоор үүссэн гэж ойлгох нөхцөл байдлыг хамаатуулан. Тухайлбал, шүүгчийн гэр бүлийн гишүүн улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах эрхтэй боловч, шүүгчийн төвийг сахих байдлын талаарх олон нийтийн ойлголтод шүүгчийн гэр бүлийн гишүүний улс төрийн үйл ажиллагаа нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүсэх ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах үүрэг

68. Шүүгчийн санхүүгийн үйл ажиллагаа нь шүүхэд ирсэн хэрэг, маргааныг шийдэх үүрэгт нөлөөлөх ёсгүй. Хэдийгээр зарим нөхцөлд шүүгч шүүн таслах ажиллагаанаас заавал татгалзах ёстой байдаг ч, шүүхтэй байнгын харилцаанд байдаг байгууллага, хуулийн этгээдийн санхүүгийн ашиг сонирхол, шүүгчийн хувийн санхүүгийн ашиг сонирхлоос үүсэх нөхцөл зэргийг ялгаж, шүүгч нь шаардлагагүй ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг багасгах ёстой. Тухайлбал, олон нийт хувьцааг нь эзэмшдэг томоохон корпорацийн ердөө нэг хувь буюу түүнээс доош хувийг эзэмшихийг ихэвчлэн "хэтэрхий бага буюу ялимгүй ач холбогдолтой" гэж үздэг бөгөөд тухайн корпорацитай холбоотой хэргийг "ялимгүй ая холбогдолтой" хувь эзэмшдэг шүүгч тухайн этгээдтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд оролцохоос татгалзахыг шаарддаггүй. Гэхдээ шүүх ажиллагаанд оролцохоос татгалзах асуудалд ихэвчлэн хэд хэдэн зүйлийг анхаарч үздэг бөгөөд тэдгээрийн аль нэг нь байгаа бол татгалзах шаардлагатай. Корпорацийн хэмжээтэй харьцуулахад хэт бага буюу ялимгүй үнэ цэнтэй байхаас үл хамааран, шүүгчийн эзэмшиж байгаа хувьцаа түүний хувьд чухал ач холбогдолтой бол татгалзах нь зүйтэй. Мөн адил, олон нийтийн зүгээс шүүгчийн хувьцааны эзэмшил оролцохоос татгалзах нөхцөл байдал мөн гэж үзэж

байгаа эсэхийг шүүгч ухамсарлах ёстой. Мэдээж хэрэг, шүүгч хэт бага буюу цөөн хувьцаа эзэмшдэг хэрнээ шүүх таслах ажиллагаанаас зориуд татгалзаад байж болохгүй. Хэрэв шүүгч хувьцааны эзэмшлээсээ болж байнга татгалздаг бол тухайн хувьцаанаас өөрийгөө тусгаарлах ёстой.³⁸

Гэр бүлийн гишүүдийн үйл ажиллагааг хязгаарлах үүрэг

69. Шүүгчийн албан үүргийг давуу байдал болгон ашиглаж буй нь тодорхой харагдах үйл ажиллагаанд гэр бүлийн гишүүдээ оролцуулахгүй байх ёстой. Энэ нь шүүгчийн албан үүргийг давуу тал болгон ашиглах буюу нөгөө талд шударга бус давуу байдал бий болгож байна гэж харагдахаас зайлсхийж, татгалзан гарах нөхцөлийг багасгахад шаардлагатай юм.



³⁸ United States of America, Commonwealth of Virginia Judicial Ethics Advisory Committee, *Opinion 2000-5*. See *Ebner v Official Trustee in Bankruptcy*, High Court of Australia, [2001] 2 LRC 369, (2000) 205 CLR 337.

2.4. Шүүгч нь өөрөө хянан шийдвэрлэж байгаа, эсхүл өөрт нь хуваарилагдан шийдвэрлэгдэх хэргийн тухайд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд нөлөөлөх бодит магадлалыг бий болгох, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчим болох шударга байдлыг алдагдуулж болох тийм тайлбар, мэдэгдлийг мэдсээр байж хийж болохгүй. Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга байдалд нөлөөлж болох мэдэгдэл, бусад ямар нэгэн тайлбар, мэдэгдлийг олон нийтэд мэдээлж болохгүй.

ТАЙЛБАР

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ямар хугацаанд шүүгчийн хяналтад байх ёстой вэ?

70. Шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг давж заалдах гомдол гаргах хүртэл удирдан явуулна. Тухайн хэргийг шүүхэд шилжүүлнэ гэж үзэх бодит үндэслэл байгаа бол, шүүгчийн хяналт эхэлж байна гэж үзэж болно. Тухайлбал, гэмт хэргийг мөрдөн шалгах, хэн нэгнийг баривчлах ажиллагаа, тодорхой ял төлөвлөөгүй байдал буюу хүний нэр хүндийн асуудал үүсэн, нэр төр сэргээлгэх ажиллагаа эхлээгүй байдал зэрэг нь үүнд хамаарна.

Зохисгүй мэдэгдлийн жишээ

71. Шүүгчдийн зүгээс гэмт хэрэг үйлдсэн гэмт этгээдүүд анх удаа гэмт хэрэг үйлдсэн, давтан үйлдсэн эсэхээс үл хамаарч бүгдэд нь хорих ял оноох болно гэсэн мэдэгдэл хийсэн бол нөхцөл байдлаас хамааран шүүгдэгч, түүний үйлдсэн гэмт

хэрэгт оноох ялын талаар урьдчилсан дүгнэлт гаргасан гэсэн үндэслэлээр, тухайн шүүгчээс татгалзах эрхтэй. Ялын хэмжээг шүүгч өөрийн дотоод итгэлийн дагуу тогтоох нь үнэн хэдий ч, тухайн гэмт хэргийн талаарх үйл баримт, хэрэглэх хуулиас хамаарч ялын хэмжээг тогтоох ёстой. Шүүгч нь олон нийтийн шуугианыг дагаж буюу олон нийтийн шүүмжлэлээс айж аливаа мэдэгдэл хийсэн бол, тэр нь зохисгүй харагдана. Мөн хянан шийдвэрлэх ажиллагаа эхлээгүй байхад олон нийтэд тайлбар өгч болохгүй.³⁹

Зөвшөөрөгдөх мэдэгдэл

72. Шүүгч албаны чиг үүргийн дагуу олон нийтийг мэдээллээр хангах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор судалгааны илтгэл танилцуулах зэргийг хориглодоггүй. Мөн шүүгч иргэнийхээ хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, тайлбар өгөхийг хориглодоггүй. Харин, шүүн таслах ажиллагаанд шүүгч нь албан үүргийн дагуу оролцож байгаа бол мэдүүлгээс өөр тайлбар өгөх ёсгүй.

Хэргийн оролцогчидтой харилцах харилцаа

73. Хэрэв хэргийн талаар шийдвэр гарсны дараа шүүгч урам хугарсан шүүгдэгч, бусад этгээдээс өөрийнх нь шийдвэр буюу хамт ажиллагсдынх нь шийдвэрийг шүүмжилсэн захидал, бусад хэлбэрийн мэдээлэл хүлээн авсан бол, тэдэнтэй маргалдах, зөрчилдөх харилцаанд орж болохгүй.

Хэвлэл мэдээллийн шүүмжлэл

74. Гэм буруугийн асуудлыг хөндөхгүйгээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь мэдээлэл цуглуулах, олон нийтэд

³⁹ See United States of America, Advisory Committee on the Code of Judicial Conduct, New Mexico, *Judicial Advisory Opinion 1991-2*.

түгээх болон шүүхээс шийдвэрлэсэн хэргийн талаар тайлбар гаргах чиг үүрэгтэй төдийгүй эрхтэй юм. Энэ эрхийг зөвхөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан нөхцөлд л хязгаарлана. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн төлөөлөл шүүхээс гарсан шийдвэрт шүүмжлэлтэй хандвал шүүгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр хариу мэдээлэл, тэрхүү шүүмжлэлийн талаар тайлбар хийхээс зайлсхийх ёстой. Шүүгч зөвхөн хэргийг хянан шийдвэрлэсэн үндэслэл болон шийдвэрээ л тайлбарлах ёстой. Шүүгч нь шүүхийн шийдвэр, түүний үндэслэлийг хамгаалсан мэдэгдлийг олон нийтийн өмнө хийх нь ерөнхийдөө зохисгүй байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн худал, ташаа мэдээ

75. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаар худал, ташаа мэдээлэл тараасан, уг алдааг залруулах ёстой гэж шүүх, шүүгч үзвэл шүүхийн захиргааны байгууллагаас мэдээ гаргах замаар бодит мэдээллийг олон нийтэд хүргэх буюу залруулга хийх арга хэмжээ авна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах талаар

76. Бангалорын зарчмуудын 2.4 дэх хэсэгт тусгайлан заагаагүй ч, энэ хэсэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах асуудлыг тусгасан. Энэ хүрээнд дараах гурван зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- 1) Нэгдүгээрт, шүүхийн байранд болон шүүхийн гадна хэрэгжүүлэх шүүгчийн албан үүрэг, ажил хэргийг дэмжих буюу шүүхийн шийдвэрийн талаар үнэн зөв мэдээлэх, анхаарах асуудлыг зөв танилцуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглана. Шүүгч хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөнд шууд автах нь Бангалорын зарчмуудын 1.1 дэх хэсэг болон 2.1, 2.2, 3.2, 4.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн зөрчил болно.

- 2) Хоёрдугаарт, шүүгч шүүхээс гадуур хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харилцах асуудал. Ихэнх улсад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нээлттэйгээр буюу шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх нээлттэй мэдээлэл, баримт бичгээс мэдээлэл авдаг. Зарим улсад (ялангуяа шүүхийн баримт бичиг нууцын зэрэглэлд байдаг), шүүх болгонд тодорхой нэг шүүгч хэвлэл мэдээллийн байгууллагатай харьцаж, аливаа хэргийн талаарх бодит мэдээллийг хүргэх чиг үүргийг хэрэгжүүлдэг тогтолцоотой байдаг. Иймд тухайн шүүгч хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд албан мэдээлэл өгөх үүрэгтэйгээс бусад тохиолдолд, шүүгч нь өөрийн болон бусад шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн талаар өөрийн зүгээс мэдээлэл, тайлбарыг шүүхээс гадуур өгөх нь зохисгүй байдаг.
- 3) Гуравдугаарт, шүүгчийн өөрийн болон бусад шүүгчийн гаргасан шийдвэрийн талаарх тайлбар, эрдэм шинжилгээний өгүүлэлтэй холбоотой асуудал. Зөвхөн тухайн хэргийг шийдвэрлэхэд авч үзсэн нийтлэг ашиг сонирхолтой холбоотой цэвэр эрх зүйн үзэл санааны талаар хийсэн тайлбарыг зөвшөөрдөг. Гэхдээ, өмнө гарсан шийдвэрүүдийн талаарх хэлэлцүүлэг нь цэвэр сургалтын орчинд шилжиж байна. Шүүгч болгон дээрх асуудлын талаар өөр өөр үзэл бодолтой байдаг бөгөөд ерөнхий нөхцөлийн тодорхойлох боломжгүй юм. Гэхдээ, шүүгч бусад шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн шийдвэр талаар шаардлагагүй маргаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр, ялангуяа, албан ёсоор хэвлэгдсэн шийдвэрт үндэслэл нэмэх гэж оролдсон маргаан, өрнүүлэхгүй байх нь зүйтэй гэсэн ойлголт хэвээр байна.

2.5. Төвийг сахисан байр сууринаас хэргийг хянан шийдвэрлэж чадахгүй гэж үзсэн тохиолдолд шүүгч өөрөө үзсэн эсхүл хэн нэгэн энгийн хүнд ингэж харагдахаар байна гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос шүүгч өөрөө татгалзана.

ТАЙЛБАР

Ухаалаг ажиглагч

77. “Ухаалаг, шударга, мэдээлэлтэй хүн”-ий зүгээс шүүгч хэргийг төвийг сахисан байр сууринаас хянан шийдвэрлэж чадахгүй байна гэж үзэж болно гэж Бангалорын төсөлд тусгасан. Гаг хотод хуралдсан 2002 оны 11 дүгээр сарын хурлаар “ухаалаг ажиглагч” нь шударга, мэдээлэлтэй байх нөхцөлийг тохиролцсоны дагуу, Бангалорын зарчмуудад “ухаалаг ажиглагчид тэгж ойлгогдох” гэх томъёоллыг оруулсан.

“Өөрийнхөө асуудалд өөрөө шүүгч байж болохгүй”

78. Өөрийнхөө асуудалд өөрөө шүүгчээр оролцохгүй байх нь суурь зарчим юм. Шүүхээс боловсруулсан энэ зарчимд адил төстэй ч, ялгаатай үр дагавар бүхий хоёр хэрэглээ бий. Нэгдүгээрт, энэ нь шууд утгаараа хэрэглэгдэх бөгөөд хэрэв шүүгч тухайн нэхэмжлэлийн нэг тал буюу үр дүнд нь эдийн засгийн ашиг сонирхолтой бол тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй. Энэ нь шүүгчээс таггалзах хангалттай үндэслэл болно. Хоёрдугаарт, энэ зарчим нь шүүх дэх маргаанд хэрэглэгдэх бөгөөд тухайн шүүгч нэхэмжлэлийн нэг тал биш, үр дүнд нь эдийн засгийн ашиг сонирхолгүй ч, хэргийн нэг талтай нөхөрлөдөг зэргээр төвийг сахихгүй байна гэх хардлага төрүүлэхээр биеэ авч явахад байдал хамаарна. Шүүгч төвийг сахихгүй байгаа нь түүнд буюу өөр хүнд ашиг

авчирдаггүй тул, хоёр дахь тохиолдолд “өөрийнхөө асуудалд өөрөө шүүгч байж болохгүй гэх” зарчмыг хэрэглэдэггүй.⁴⁰

Талуудын зөвшөөрөл хамааралгүй

79. Талууд зөвшөөрсөн хэдий ч, шүүгч өөрөө татгалзах ёстой гэж мэдэрч байвал хэргийг үргэлжлүүлэн хянан хэлэлцэхгүй. Учир нь олон нийтийн зүгээс ч тэр, шүүх ямар нэг эргэлзээ төрүүлэхгүйгээр төвийг сахих ёстой гэж үздэг. Гэхдээ ихэнх улсад, төвийг сахихтай холбоотой аливаа асуудлаар талууд албан ёсоор татгалзах эрхтэй байдаг. Ийнхүү татгалзаж буйгаа зохих ёсоор мэдэгдсэн бол, татгалзах нөхцөлийг тодруулсны үндсэн дээр татгалзлыг хүлээн авч болно.

Шүүгч татгалзлын асуудлыг хэзээ ил болгох ёстой вэ?

80. Шүүгч нь талуудаас гаргасан бичиг баримт, хүсэлтийг хоёр нөхцөлд ил болгож болно. Нэгдүгээрт, хэрэв татгалзан гарах нөхцөлийн талаар шүүгчид ямар нэг эргэлзээ байгаа бол. Хоёрдугаарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр буюу түүнээс өмнө гэнэтийн асуудал үүсвэл. Шүүгч нь тухайн асуудлыг тодруулах хүсэлт гаргахад талуудын буюу тэдгээрийн өмгөөлөгчдийн зөвшөөрөл шаардлагагүй бөгөөд харин татгалзан гаргах нөхцөл бий эсэх асуудлаар тэднээс туслалцаа авч болно. Тухайлбал, шүүгч татгалзан гарах онолыг хэрэглэж буй нөхцөлд ийм туслалцаа авч болно. Хэрэв эргэлзэх бодит нөхцөл байгаа бол, үүнийг татгалзах нөхцөл гэж үзэн шийдвэрлэнэ.

Алагчлах үзлийн үндэслэл

81. Ерөнхийдөө, татгалзлын шалгуур нь алагчилж байна гэх үндэслэл юм. Алагчлах, гадуурхах үзэл бий эсэхийг

⁴⁰ *R v. Bow Street Stipendiary Magistrate, Ex parte Augusto Pinochet Ugarte (No.2)*, House of Lords, United Kingdom, [1999] 1 LRC 1.

тодорхойлоход өөр өөр үг хэрэглэдэг. Алагчлах үзэл нь алагчилж байна гэх “өндөр магадлалтай”-аас “бодит магадлал”, “бодит бололцоотой байх”, “үндэслэл бүхий сэжиг” хүртэл хэлбэлзэлтэй байдаг. Алагчлах үзэл бий эсэхийг ухаалаг, шударга, мэдээлэлтэй хүмүүс асуудал дэвшүүлж, шаардлагатай мэдээлэл олж авсны үндсэн дээр бодитоор гаргаж ирэх ёстой. Үүний шалгуур нь “тухайн хүн асуудалд бодитоор хандаж, дүгнэлт хийсэн үү?”, “тухайн хүн шүүгчийг санаатай буюу санамсаргүйгээр шударгаар шийдэхгүй гэж бодож байна уу?” гэх асуулт юм.⁴¹ Ийнхүү шүүгчийн зан үйлийн талаар ухаалаг ажиглагч хэрхэн үзэж буй нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийн дээшлүүлэх шаардлагад үндэслэсэн. Тодруулбал, энэ нь дээрх шалгуурыг бодит гэж үзэх нөхцөл бөгөөд бусад шүүгч болон хамт ажиллагсдынх нь үнэлгээнд тулгуурладаггүй.

82. Канадын Дээд шүүхийн шүүгчийн тэмдэглэснээр, үйл баримтаас үндэслэн шүүгч бусдыг гадуурхаж байна гэж үзэх нь ховор асуудал юм.⁴² Мэдээж хэрэг, ийм асуудал үүсвэл гарцаагүй шүүгчийг татгалзахад хүргэнэ. Гэхдээ талуудын гаргасан шүүгчийг татгалзах хүсэлтэд бодит үндэслэл тусгагдаагүй буюу хүсэлтэд дурдсан алагчлал бодитоор болоогүй байдаг. Хааяа, талууд алагчилж байна гэж шүүгчийг сэжиглэн татгалзах хүсэлт гаргадаг ч, үүнийгээ нотолдоггүй. Алагчлах үзлийн үндэслэлийг ойлгох нь түүний татгалзах нөхцөлийг шийдвэрлэхэд тустай бөгөөд бодитоор алагчилсан эсэх талаарх асуудал маргаан үүсгэдэггүй. Энд

⁴¹ See *Locabail (UK) Ltd v Bayfield Properties*, Court of Appeal of England and Wales [2000] QB 451, [2000] 3 LRC 482; *Re Medicaments and Related Classes of Goods (No.2)*, House of Lords, United Kingdom [2001] 1 WLR 700; *Porter v Magill*, House of Lords, United Kingdom [2002] 2 AC 357; *Webb v The Queen*, High Court of Australia (1994) 181 CLR 41; *Newfoundland Telephone Co v Newfoundland (Board of Commissioners of Public Utilities)*, Supreme Court of Canada [1992] 1 SCR 623; *R v Gough*, House of Lords, United Kingdom [1993] AC 646; *R v Bow Street Stipendiary Magistrate, Ex parte Augusto Pinochet Ugarte (No.2)*, House of Lords [2001] 1 AC 119.

⁴² *Wewaykum Indian Band v. Canada*, Supreme Court of Canada, [2004] 2 LRC 692, per Chief Justice McLachlin.

дурдаж буй “бодит алагчлал” гэдэгт гурван нөхцөл байдаг. Үүнд: бодит алагчлал болсон байх шаардлагагүй. Учир нь алагчилсан гэх үндэслэл бодитой байвал түүнийг бодитоор алагчилсантай адилтган орлуулдаг; шүүгч хэдийгээр хар буруу санаагүй буюу сайн санаж үйлдсэн ч, санамсаргүйгээр алагчлах нь бий; холбогдох магадалгаа, асуулга нь бодит алагчлалтай холбоогүй.

83. Нэгдүгээрт, татгалзалтай холбоотой өнөөгийн стандартаар, талуудын зүгээс шүүгч бодитоор алагчлаагүй гэж хэлэхэд, үүнийгээ нотлох шаардлагагүй гэж үздэг. Энэ утгаараа, бодит бус, хийсвэр зүйлд ямар нэг нотлох баримт шаардлагагүй гэх ойлголтоор, “алагчилсан гэх үндэслэл” нь бодит алагчлалыг орлоно. Мэдээж хэрэг, шүүгчийн оюун санааны нөхцөлийг нарийн тодорхойлох боломжгүй, ялангуяа хуулиар шүүгчийн оюун санаанд нөлөөлөх гадаад нөлөөллийн шинж байдлыг авч үздэггүй. Учир нь хуулийн агуулга нь ямар нэг алагчлал үнэхээр бодитоор байгааг харуулах шаардлагагүйгээр, шүүгдэгч нь алагчлал бодитой гэж ойлгогдох багахан хэсгийг харуулж чадвал шүүгдэгчийг хамгаална.

84. Хоёрдугаарт, талуудын зүгээс шүүгч бодитоор алагчлаагүй гэж хэлэхдээ, шүүгчийг сайн санаж үйлдсэн буюу санамсаргүйгээр алагчилсан гэдгийг хүлээн зөвшөөрч болох юм. Алагчлал нь санамсаргүй зүйл байж, шүүгчийн зүгээс бодитоор алагчлаагүй, тэр үйлдэл нь түүний оюун санаанд нөлөөлөхгүй гэдгээ шударгаар хэлсэн ч, алагчилсан гэх нөхцөл арилахгүй.

85. Эцэст нь жинхэнэ алагчлалыг хайхтай холбоотой магадалгаа, асуулга нь бодит алагчлал болохгүй гэдгийг талууд зөвшөөрч болох юм. Тэд “шүүх зөвхөн хийх бус, хийсэн зүйлээ ил тод, эргэлзээгүй харуулах ёстой” гэх афоризмд найддаг. Тухайн хэрэгт татгалзах ёстой эсэх талаар маргахад, холбогдох тодруулга, асуулга нь шүүгч алагчилж байна үзэх нөхцөл биш

хэдий ч, ухаалаг хүний зүгээс тэнд алагчлал байсан гэж зохих ёсоор мэдэгдэж болно. Энэ тохиолдолд, шударга шүүхэд итгэх олон нийтийн ашиг сонирхол нэн тэргүүнд байна.

86. Алагчлах үзлийн үндэслэлийн объектив стандартыг батлах дээрх гурван нөхцөлийн сүүлийнх нь шүүхийн тогтолцоонд хамгийн хатуу чанд нөхцөл юм. Учир нь шүүх юу хийсэн нь харагдахгүй байх магадлалтай бөгөөд хийсэн зүйл нь эргэлзээтэй байдалд орно. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдалд бүхэлдээ төвийг сахих ёстой шүүгч нь алагчилсан гэх үндэслэлтэй гэж ойлгогдож, шүүгчийг татгалзахыг шаардана. Гэхдээ татгалзлын шалгуур нь шүүгчийн оюун санаанд байх хэдий ч, ухаалаг хүний бодит ойлголтоор илэрхийлэгдэнэ. Нөхцөл байдлаас хамааран, ухаалаг хүнээс шүүгчийн оюун санааг хэрхэн төсөөлж буйг асууж болно. Энэ утгаараа, олонтоо дурдсан, “шүүхийн хийсэн зүйл ил тод харагдаж байх ёстой” гэх санааг алагчлалын үндэслэлийн талаарх стандартаас салгаж болохгүй.

Шүүгч нь татгалзлыг эмзгээр хүлээж авах ёсгүй

87. Шүүгч нь татгалзан гаргах хүсэлтийг хэт эмзгээр хүлээж авч болохгүй бөгөөд хувийн асуудал болгох ёсгүй. Хэрэв шүүгч нь татгалзан гаргах хүсэлтийг хувийн гомдол, дургүйцэл болговол, шийдвэрээ сэтгэл хөдлөлөөр гаргах хандлагатай болдог. Шүүгч нь гомдол, бухимдлаа талуудад нээлттэй илэрхийлбэл үр дүнд нь, хүсэлт гаргагчийн сэжиг магадгүй илүү бодитой болно. Алагчилж байна гэх сэжиг, таамгаа батлан хэлэх үед, шүүгч нь нэн тэргүүнд татгалзан гаргах хүсэлт гаргаж буй хүний үндэслэлд илүү анхаарал хандуулах ёстой. Энэ нь эрх зүйт нийгмийн суурь зарчим болох “шударга ёс бие болох нөхцөлийг шүүгч хангаж байдаг” гэсэн зарчимтай нэгэн адил чухал юм. Тиймээс шүүгч нь шүүх хурал, түүний үр дүнд санаа зовж буй бүх этгээд,

ялангуяа шүүхэд хүсэлт гаргагч этгээддээ шүүх хуралдааныг урьдчилсан дүгнэлтгүйгээр, төвийг сахиж, шударгаар явуулна гэдгээ ойлгуулж байх хэрэгтэй. Үүний дагуу, тухайн шүүгч нь татгалзах хүсэлтийг хэлэлцэхдээ төвийг сахина гэдгээ илт мэдэгдэхүйцээр биеэ авч явах ёстой.⁴³

Улс төрийн урьдын харилцаа нь татгалзах үндэслэл болохгүй

88. Шүүгчээр томилогдохоос өмнөх ажил мэргэжилтэй холбоотой аливаа үүрэг хариуцлага, ашиг сонирхол нь түүний төвийг сахих байдлаа хэрхэн хангаж байгаагаас шалтгаална. Өмгөөлөгчөөр ажиллаж байсан хуульчийг шүүгчээр томилж болдог улсад, тухайн хүний шүүгчээр томилогдохоос өмнөх улс төрийн нам, ашиг сонирхлын талаарх үзэл бодол, үйлдлийн талаар олон нийт мэдээлэлтэй байдаг. Энэ нь улс төрийн амьдралтай холбоотой өмгөөлөгчийн хувьд байх зүйл. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгчийн улс төрийн үйл ажиллагааны туршлага нь түүнийг татгалзан гаргах нэг үндэслэл болдог. Гэхдээ шүүгчийн тангараг өргөснөөр буюу шүүн таслах ажиллагааг хараат бусаар, төвийг сахин хэрэгжүүлэхээ баталгаажуулснаас эхлэн шүүгч нь урьд байсан улс төрийн харилцаа, улс төрийн ашиг сонирхлоо ардаа орхих ёстой гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ухаалаг, шударга, мэдээлэлтэй хүний зүгээс бодит алагчлал бий эсэхийг шийдэхэд харгалзан үзэх нэг нөхцөл болдог.⁴⁴

Татгалзалтай холбоогүй үндэслэлүүд

89. Шүүгчийн шашин шүтлэг, угсаа гарал, яс үндэс, хүйс, нас, нийгмийн гарал, бэлгийн чиг баримжаа нь ихэвчлэн

⁴³ See *Cole v Cullinan et al*, Court of Appeal of Lesotho, [2004] 1 LRC 550.

⁴⁴ See *Panton v Minister of Finance*, Privy Council on appeal from the Court of Appeal of Jamaica, [2001] 5 LRC 132; *Kartinyeri v Commonwealth of Australia*, High Court of Australia, (1998) 156 ALR 300

татгалзаг гаргах үндэслэл болохгүй. Харин шүүгчийн нийгмийн, боловсролын, албаны үүргийн буюу ажил эрхлэлтийн байдал; шүүгчийн нийгмийн, спортын, буяны байгууллагын гишүүнчлэл; шүүхийн өмнөх шийдвэрүүдэд тус тус суурилсан нөхцөл нь ерөнхийдөө татгалзаг гаргах үндэслэл болдог. Гэхдээ дээр дурдсан зүйлс нь тодорхой нэг хэрэг буюу шүүгчийн шийдвэрлэх хэргийн нөхцөл байдлаас хамаарна.

Нөхөрлөл, дайсагнал зэрэг татгалзах бусад үндэслэл

90. Нөхцөл байдлаас хамааран дараах тохиолдолд алагчлал гарч ирж болно. Үүнд:

- 1) Хэрэв шүүгч тухайн хэрэгтэй холбоотой хэн нэгэн оролцогчийн хооронд хувийн нөхөрлөл, дайсагнал байгаа бол;
- 2) Хэрэв шүүгч нь тухайн хэрэгтэй холбоотой хэн нэгэн оролцогчтой ойрын танил, ялангуяа тухайн хүний статус хэргийн үр дүнд чухал ач холбогдолтой бол;
- 3) Хэрэв тухайн хэрэгт шүүгч хувь хүний байдлыг тодорхойлох хэрэгцээ гарч, өмнө тэр хүний нотлох баримтыг хэтэрхий удаан ярьсан гэх үндэслэлээр хүсэлтийн хүлээн аваагүй, хувь хүний нотлох баримтыг урьдчилсан дүгнэлтгүйгээр үнэлэх шүүгчийн чадварт эргэлзээ төрүүлсэн бол;
- 4) Хэрэв шүүгч шүүх хуралдааны үеэрх ямар нэг асуудлаар ил тод, тэнцвэргүй үг хэллэгээр тухайлан үзэл бодлоо илэрхийлсэн нь, шүүгчийн хараат бус дотоод итгэлээрээ шийдвэр гаргах чадварт эргэлзэх үндэслэл бий болгосон бол;
- 5) Хэрэв хөндлөнгийн хүчин зүйлийг үл хэрэгсэх, гадуурхахгүй байх, асуудлыг хангалттай бодит үндэслэлтэйгээр шийдвэрлэх шүүгчийн чадварт эргэлзэх бодит үндэслэл, бусад шалтгаан байгаа бол.

Дээр дурдсантай адил алагчлал бодитоор байна гэгдэх зүйлс цаг хугацаа өнгөрч, удах тусам татгалзах үндэслэлээ алддаг.⁴⁵

Шүүгчээр ажиллахаа больсны дараа нь ажилд авах санал шүүгчийн татгалзалд хүргэнэ

91. Шүүгчийг албан үүргээ хэвээр гүйцэтгэж буй үед нь, шүүхэд ажиллахгүй болсны дараа холбоо тогтоох гэсэн оролдлого нь шүүгчийн татгалзалтай холбоотой асуудал болж, төстэй арга замыг шаардах нь бий. Ийм оролдлогыг хуулийн фирмүүд, ирээдүйн ажил олгогчид, хувийн сектор, төрийн байгууллагаас гаргадаг. Энэ нь ухаалаг, шударга, мэдээлэлтэй хүний нүдэнд шүүгч өөрийн ашиг сонирхолтой, үүргээ гүйцэтгэхдээ зөрчилтэй харагдуулах эрсдэлтэй. Ийм оролдлогод автах эсэхээ шүүгч эргэцүүлэх ёстой. Ялангуяа, шүүгчээр ажиллахаа больсны дараах шүүгч асны үйл хөдлөл нь шүүхийн талаарх олон нийтийн итгэлд байнга нөлөөлдөг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁴⁵ *Locabail (UK) Ltd v Bayfield Properties Ltd*, Court of Appeal of England and Wales [2000] 3 LRC 482.

Тухайлбал, дараах зарим тохиолдлыг дээрхэд хамааруулж болох бөгөөд татгалзан гарах үндэслэл үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

2.5.1. Шүүгч хэргийн аль нэг талд шударга бус хандсан, хэт нэг талыг баримталсан хандлага гаргасан, эсхүл хянан шийдвэрлэж байгаа хэргийн үйл баримтын талаар хувийн шугамаар мэдээ, мэдээлэлтэй болсон.

ТАЙЛБАР

Бодит алагчлал ба гадуурхал байвал

92. Бодит алагчлал нь хувийн шинжтэй, талуудын аль нэг рүү чиглэсэн байдаг. Шүүгчийн хувьд ийм төрлийн алагчлал байна гэж үзвэл татгалзах ёстой бөгөөд, энэ нь шүүгч төвийг сахин ажиллаж чадахгүй гэдгийн бодит нотолгоо болно. Ухаалаг ажиглагчийн хувьд бүх нөхцөл байдлыг мэдэж байгаа хэрнээ, шүүгчийн төвийг сахих байдалтай холбоотой эргэлзээгээ нууж уу? Гэдэг асуулт үүснэ.

Маргаантай үйл баримтын талаар хувийн шугамаар мэдээ, мэдээлэлтэй болсон

93. Энэ нөхцөл нь тухайн хэргийг шүүгчид шилжүүлэхээс өмнө олсон мэдээлэл, түүнчлэн хэрэг үргэлжилж байх үед шүүхээс гадуурх эх сурвалж, хувийн ажиглалтаар шүүгчийн олж авсан мэдээлэлд хэрэглэгддэг. Мөн ийм мэдээллийг нэхэмжлэлтэй холбоогүй зорилгоор, бие даан хийсэн судалгаагаар (тухайлбал, ном бичих) дамжуулан олж авч болно.⁴⁶ Дээр дурдсан мэдээлэлтэй холбоотой зарим тохиолдол болох, ижил хэлцэлтэй холбоотой талуудын хэргийг

⁴⁶ See *Prosecutor v Sesay*, Special Court for Sierra Leone (Appeals Chamber) [2004] 3 LRC 678.

шүүхээр шийдвэрлэх буюу өмнөх өөр хэрэгт тухайн шүүгчээр шийдүүлсэн талуудын хувьд татгалзах шаардлагагүй. Гэхдээ дээрх мэдээлэл нь илэрхий, ойлгомжтой, ерөнхийдөө яригдаж, хэлэлцэгдэж байдаг мэдээ буюу талуудын шүүхэд өгөх баримт бичигт дурдагдах нь зайлшгүй мэдээллийн хувьд, дээрх нөхцөл хамааралгүй юм. Энэ талаарх үндэслэл бүхий хязгаарлалт бий. Тухайлбал, шүүгч нь хэрэг хянан хэлэлцэх үеэр, тухайн хэрэгтэй хамааралтай нэгэнт илэрхий хуулийн зүйл бүр, шийдвэртэй холбоотой үйл баримт бүрийг тодруулах шаардлагагүй. Үүний хэмжүүр нь ухаалаг ажиглагчийн бодит, үндэслэл бүхий ойлголт байдаг.

2.5.2. Шүүгч нь тухайн хэрэгт өмнө нь өмгөөлөгчөөр эсхүл гол гэрчээр оролцсон.

ТАЙЛБАР

Өмгөөлөгч нь бусад танхимын гишүүний төлөө үүрэг хариуцлага хүлээхгүй

94. Шүүгч өмнө нь өмгөөлөгчөөр ажиллаж байсан бол, өөрөө бие даасан статустайгаар танхимын гишүүн бусад өмгөөлөгчийн өмнөөс үүрэг хариуцлага хүлээхгүй.

Хуульчид хамтрагчийнхаа мэргэжлийн үйлдэлд хариуцлага хүлээнэ

95. Хуулийн фирм, нөхөрлөлд хуульчаар ажиллаж буй этгээдийн хувьд, бусад хамтрагчийнхаа мэргэжлийн үйлдлийн төлөө эрх зүйн хариуцлага хүлээнэ. Тиймээс, тухайн компанийн үйлчлүүлэгчдэд биечлэн үйлчлээгүй, тэдний талаар мэдэхгүй байсан ч, хамтрагчийн хувиар фирм, нөхөрлөлийн үйлчлүүлэгчдийн өмнө үүрэг хариуцлага хүлээнэ. Үүний дагуу, өмнө нь тухайн фирм, нөхөрлөлийн гишүүн байсан шүүгчийн хувьд, өмнө нь шүүгчийн өөрийн буюу ажиллаж байсан хуулийн фирм, нөхөрлөлтэй шууд холбоотой, мэдлэгээ зарцуулсан гэж ойлгогдох хэрэгт шүүгчээр оролцож болохгүй.

Төрийн байгууллага, хууль зүйн туслалцааны төвд ажиллаж байсан байдал

96. Шүүгч өмнө нь төрийн байгууллага, хууль зүйн туслалцааны төвд ажиллаж байсан нь алагчлах байдал үүсгэх эсэхийг дүгнэхдээ, тэдгээр байгууллага, төвийн хууль зүйн практик шинжийг анхаарч үзэх шаардлагатай. Тодруулбал, шүүгч өмнө нь тэдгээр байгууллагад захиргааны, зөвлөх,

хяналт тавих буюу удирдах ажлын алийг эрхэлж байсныг харгалзан үзнэ.

Маргаантай асуудалд шүүгч гол гэрч байх асуудал

97. Шүүгч-гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлж болохгүй бөгөөд тэгж харагдах, ойлгогдох зүйлд оролцож болохгүй.

2.5.3. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүн нь хэргийн эцсийн шийдвэрийн хувьд эдийн засгийн аливаа сонирхолтой байх.

ТАЙЛБАР

Эдийн засгийн ашиг сонирхолтой бол шүүгч татгалзана

98. Шүүгч өөрөө буюу гэр бүлийн гишүүн нь тухайн нэг хэргийн шийдвэрээс санхүүгийн ашиг олох, алдагдал хүлээх байдалтай байгаа бол шүүгч өөрөө татгалзана. Тухайлбал, шүүгч нь талуудын аль нэгний компанид их хэмжээний хувьцаа эзэмшиж байгаа буюу, тухайн хэргийн үр дүн нь шүүгчийн ашиг сонирхолд бодитоор нөлөөлөх, тийнхүү нөлөөлнө гэдэг нь тодорхой харагдаж буй нөхцөлийг үүнд хамруулна. Хэрэв хэргийн оролцогч нь нээлттэй хувьцаат компани, шүүгч тус компанийн нийт хувьцааны багахан хэсгийг эзэмшдэг, хэргийн үр дүн шүүгчийн ашиг сонирхолд нөлөөлөхгүй бол, шүүгч татгалзан гарахгүй байж болно. Харин шүүхэд гаргасан нэхэмжлэл нь тухайн компанийн оршин тогтнох эсэхтэй холбоотой бөгөөд нөхцөл байдлаас хамааран үр дүн нь шүүгчийн ашиг сонирхолд бодитоор нөлөөлөх бол байдал өөр болно.

Ямар тохиолдолд “эдийн засгийн ашиг сонирхол” үүсэхгүй вэ?

99. Эдийн засгийн ашиг сонирхолтой байдлыг шүүгчийн аливаа эзэмшил, ашиг сонирхол бүрт хамааруулдаггүй. Тухайлбал, үйл ажиллагаа нь тухайн эзэмшлийн үнэ цэн, ашиг сонирхолд мэдэгдэхүйц нөлөөлөхөөргүй бол, хамтын хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн байгууллагад хадгалуулсан мөнгө, хамтын хадгаламж зээлийн хоршоо, шүүгчийн эзэмшиж

буй засгийн газрын үнэт цаас зэрэгт эдийн засгийн ашиг сонирхол яригдахгүй. Мөн шүүгч нь банк, даатгалын компани, зээлийн картны компанитай зөвхөн ердийн үйлчлүүлэгчийн хувиар харилцдаг бөгөөд үүнтэй холбоотой үүсэх ямар нэг маргаан, тусгай гүйлгээгүй тохиолдол эдийн засгийн ашиг сонирхол яригдахгүй. Шүүгчийн эхнэр/нөхөр, эцэг эх, хүүхэд нь захирал, ажилтан, зөвлөхөөр нь ажилладаг боловсролын, буяны, иргэний нийгмийн байгууллагын үнэт цаас эзэмшдэг бол нөхцөл байдлаас хамаар шүүгч тухайн байгууллагад эдийн засгийн ашиг сонирхолтой гэж үзэхэд хүргэнэ. Тухайн хэрэгтэй холбоотой санхүүгийн маш их үр дагавар гарах байсан ч, шийдвэр гарах үед тийм үр дагавар гарахгүй бол, татгалзах үр дүнд хүрэхгүй. Гэвч ийм нөхцөлд шүүгч болгоомжтой байхын тулд, тухайн нөхцөл байдлын талаар талуудад мэдэгдэж, шүүхийн баримт бичигт нээлттэй бичүүлснээр зөвхөн хуульчид гэлтгүй талуудад мэдээлэл, ойлголт өгөх хэрэгтэй. Заримдаа энгийн үйлчлүүлэгч илүү хардамтгай байдаг бөгөөд бусад шүүгчдэд ч бага итгэдэг.

Тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн өөр бүрэлдэхүүн байхгүй, хэргийг даруй шийдвэрлэх шаардлагатай болсон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх нь шүүн таслах ажилд ноцтой хохирол учруулахаар байвал шүүгч татгалзан гарах шаардлагагүй байж болно.

ТАЙЛБАР

Зайлшгүй байдлын номлол

100. Онцгой нөхцөл байдал үүсвэл дээр яригдсан зарчмыг хэрэглэхгүй байх шаардлага үүсдэг. Зайлшгүй байдлын номлол нь тухайн хэргийг хэлэлцэх, шийдвэрлэхээс татгалзсан нь шударга бус үр дүнд хүрэх нөхцөл байдал бий болгох асуудлыг шүүгч хэрхэн шийдэхийг зохицуулсан. Өөрөөр хэлбэл татгалзаагүй өөр шүүгч байхгүй, хэрэв цаг хугацаа алдах, шүүх хуралдаан хийхгүй байх нь маш хүнд бэрхшээлийг бий болгох, хэрэв тухайн шүүгч оролцуулахгүй бол шүүх хэргийг хянан хэлэлцэх, шийдвэрлэх боломжгүй болох үед дээрх нөхцөл байдал үүсдэг.⁴⁷ Мэдээж хэрэг, энэ нь ховор, онцгой тохиолдол юм. Гэхдээ цөөн шүүгчтэй эцсийн шатны шүүхийн хувьд, ийм тохиолдол үе үе гардаг бөгөөд Үндсэн хуулийн болон хяналтын шатны шүүхийн чухал чиг үүргийг өөр шүүхэд шилжүүлж болдоггүйтэй энэ нь холбоотой юм.

UJH.MN
СУДАЛГААНЫ САН

⁴⁷ See *The Judges v Attorney-General of Saskatchewan*, Privy Council on appeal from the Supreme Court of Canada, (1937) 53 TLR 464; *Ebner v Official Trustee in Bankruptcy*, High Court of Australia, [2001] 2 LRC 369; *Panton v Minister of Finance*, Privy Council on appeal from the Court of Appeal of Jamaica, [2002] 5 LRC 132.

ҮНЭТ ЗҮЙЛ 3: ШУДАРГА БАЙДАЛ

Зарчим:

Шударга байдал нь шүүхийн үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал ач холбогдолтой.

ТАЙЛБАР

“Шударга байдал”-ын үзэл баримтлал

101. Шударга байдал нь ёс суртахууны хувьд зөв зан үйл, бодол, ёс суртахуунтай байх чанар юм. Шударга байдал нь шүүгчийн үнэнч шударга ба ёс зүйтэй байдлаас бүрдэнэ. Шүүгчийн хувьд зөвхөн албан үүргээ гүйцэтгэх бус, шүүхийн байгууллагын эрх ашгийн үүднээс үнэнч шударгаар үйл ажиллагаа явуулах; залилан, хууран мэхлэлт, худал хуурмагаас ангид байх; зан байдлаа ариун, үйл хөдлөлөө зөв байлгах ёстой. Шударга байдлын төвшинг тодорхойлсон тодорхойлолт байдаггүй. Шударга байдал нь үнэмлэхүй зүйл. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын шударга байдал нь мэргэн санаандаа бус зайлшгүй шаардлагатай зүйл юм.

Олон нийтийн жишгээс хамаарах нь

102. Шударга байдлын үзэл санааг ерөнхийд нь ойлгоход хялбар боловч, илүү тодорхой нөхцөлд хэрэглэхэд хэцүү, магадгүй боломжгүй байж болох юм. Олон нийтийн ойлголтын үр нөлөө нь тухайн газар, цаг хугацааны байдлаас шалтгаалан харилцан адилгүй байж болдог. Энэ нь тодорхой зан үйлийг олон нийтийн эрүүл саруул ухаантай, мэдээлэлтэй хэсэг хэрхэн ойлгосон, тэрхүү ойлголт нь шүүгч, шүүхийг хүндэтгэх олон

нийтийн хүндэтгэлийг багасгах эсэхийг харгалзан үзэхийг шаарддаг. Иймд шүүх, шүүгчийг нэр хүндийг бууруулах магадлалтай аливаа зан үйл, үйлдлээс зайлсхийх ёстой.

Хэрэглэх нь:

3.1. Энгийн хүний байр сууринаас харахад, шүүгч нь элдэв шүүмжлэлд өртөхөөргүйгээр шүүгчийн ёс зүйг сахиж, хэвшүүлнэ.

ТАЙЛБАР

Хувийн амьдралдаа болон олон нийтийн дунд биеэ авч явахдаа өөртөө өндөр стандарт тавих шаардлагатай

103. Шүүгч нь хувийн амьдралдаа болон олон нийтийн дунд биеэ авч явахдаа өөртөө өндөр стандарт тавих шаардлагатай. Үүний шалтгаан нь, шүүгч шийдвэрээ гаргахад амьдралын арвин туршлага, зан үйл хэрэг болдог. Хэрэв шүүгч өөрийн хувийн амьдралдаа хэвшүүлээгүй зүйлийн бусдаас шаардвал шүүгч хоёр нүүртэн шиг харагдана. Ингэснээр, шүүгчид төдийгүй түүнээс илүүтэйгээр шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг гарцаагүй алдана.

Хувийн амьдралдаа нийгмийн тогтсон стандартыг баримтлах ёстой

104. Шүүгч нь бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн нийгмийн стандартыг зөрчих ёсгүй бөгөөд шүүх, эрх зүйн тогтолцооны нэр хүндийг унагах тодорхой үйл ажиллагаанд холбогдох ёсгүй. Ийнхүү шүүгч нь зөв тэнцвэрийг олохыг оролдохдоо, түүний үйлдэл, биеэ авч явах байдал нь нийгмийн ухаалаг, шударга, мэдээлэлтэй гишүүний нүдэнд шүүгчийн үнэнч шударга эсэхэд эргэлзэхэд хүргэх, шүүх, шүүгчийн нэр хүндийг бууруулах аливаа үйлдэл хийхээс зайлсхийх ёстой.

Нийгмийн нэгдсэн стандарт гэж байдаггүй

105. Соёлын олон янз байдал, байнгын хувьслын өнцгөөс харвал, шүүгчийн хувийн амьдралд хэрэглэх стандарт тийм ч нарийн, тодорхой байдаггүй.⁴⁸ Гэхдээ энэ зарчим нь шүүгч амьдралын тухгүй хэв маягтай болох буюу, шүүгчийн хувийн ашиг сонирхол, үйл ажиллагаа нь нийгмийн тодорхой хэсгийг гутаахуйц нөхцөлийг зөвшөөрсөн үйлдэл гэж ойлгогдохоор байж болохгүй. Иймд, тодорхой хэргийн шийдвэрүүд нь аль болох нийгэм, цаг үетэйгээ илүү ойрхон холбоотой байх ёстой. Харин бүх нийтээр хүлээн зөвшөөрөх шийдвэр цөөхөн гардаг.

Алтернатив хэмжүүр

106. Тодорхой нэг үйлдэл зарим шашны байгууллага, угсаатны итгэл үнэмшлийн хувьд ёс суртахуунтай эсэх, олон нийтийн стандартаар хүлээн зөвшөөрөгдсөн эсэх асуудал нь байцаан шалгах, нотлох баримт шинжлэн судлахад хамааралгүй. Харин тухайн үйлдлийг талаарх байцаан

⁴⁸ This is particularly evident in respect of sexual activity. For example, in the Philippines, a judge who flaunted an extra-marital relationship was found to have failed to embody judicial integrity, warranting dismissal from the judiciary (*Complaint against Judge Ferdinand Marcos*, Supreme Court of the Philippines, A.M. 97-2-53-RJC, 6 July 2001). In the United States, in Florida, a judge was reprimanded for engaging in sexual activities with a woman who was not his wife, in a parked motor car (*In re Inquiry Concerning a Judge*, 336 So. 2d 1175 (Fla. 1976), cited in Amerasinghe, *Judicial Conduct*, 53). In Connecticut, a judge was disciplined for having an affair with a married court stenographer (*In re Flanagan*, 240 Conn. 157, 690 A. 2d 865 (1997), cited in Amerasinghe, *Judicial Conduct*, 53). In Cincinnati, a married judge who was separated from his wife was disciplined for taking a girl friend (whom he since married) on three foreign visits, although they did not ever occupy the same room (*Cincinnati Bar Association v Heitzler*, 32 Ohio St. 2d 214, 291 N.E. 2d 477 (1972); 411 US 967 (1973), cited in Amerasinghe, *Judicial Conduct*, 53). But in Pennsylvania, also in the United States, the Supreme Court declined to discipline a judge who had engaged in an extra marital sexual relationship which included overnight trips and a one-week vacation abroad (*In re Dalessandro*, 483 Pa. 431, 397 A. 2d 743 (1979), cited in Amerasinghe, *Judicial Conduct*, 53). Some of the foregoing examples would not be viewed in some societies as impinging on the judge's public duties as a judge but relevant only to the private zone of consensual noncriminal adult behaviour.

шалгах, шинжлэн судлах ажиллагаа нь шүүгч өөрийн үндсэн ажлаа шударгаар, хараат бусаар, олон нийтийн хүндэтгэл төрүүлэхүйцээр хийж чадаж байгаа эсэхэд, шүүгчийн ажлын талаар олон нийтийн ойлголт ямар байгаад нөлөөлдөг. Ийм, шүүгч шийдвэр гаргахдаа дараах зургаан хүчин зүйлийг харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

- 1) Тухайн үйлдлийн мөн чанар болон хууль зөрчсөн бодит үйлдэл байгаа эсэх;
- 2) Тухайн үйлдлийн хэмжээ хязгаар, хувь хүний эрх болж хамгаалагдсан эсэх;
- 3) Шүүгч шийдвэр гаргах ямар сонголтууд байгаа эсэх;
- 4) Тухайн үйлдэл холбогдох хамгийн ойр этгээдэд зориудын хор хөнөөл учруулсан эсэх, бусдад бодитоор халдсан эсэх;
- 5) Тухайн үйлдэл олон нийт, хувь хүнийг ямар байдлаар хүндэлж, үл хүндэлж буй эсэх;
- 6) Тухайн үйлдэл алагчлал, гадуурхал, зохисгүй нөлөөг үзүүлж буй эсэх;

Дээрх хүчин зүйлс болон түүнтэй төстэй бусад хүчин зүйлсийг ашиглах нь олон нийтийн хүлээлт, шүүгчийн албан үүргийг тэнцвэржүүлэхэд туслах эсэх дээр маргаан өрнөдөг.⁴⁹

Шүүх дэх зан үйл

107. Шүүхэд тогтсон дэг журам өөр өөр байдаг боловч шүүгч нь амаар гаргасан шийдвэрийн агуулга өөрчлөх ёсгүй. Нөгөө талаар, шийдвэрийн агуулгыг амаар танилцуулахад гарсан үг үсэг, хэлц үг хэллэг, дүрэм, өгүүлбэр зүйн алдааг залруулах, орхигдсон эшлэлийг оруулах зэргийг зөвшөөрдөг. Үүнтэй адилаар, шүүгчийн хэлснийг буруу бичсэнээс бусад тохиолдолд, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн санал, шүүгчийн

⁴⁹ See Jeffrey M. Shaman, Steven Lubet and James J. Alfini, *Judicial Conduct and Ethics*, 3rd ed. (Charlottesville, Virginia, The Michie Company, 2000).

эцэслэн хэлсэн үгийн бичвэрийг ямар нэг байдлаар өөрчилж болохгүй. Шүүгч өөрийн шийдвэрийг давж заалдсантай холбоотойгоор, давж заалдах шатны шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй хувийн харилцаа тогтоож болохгүй. Шүүгч нь хамаатан саднаа шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллуулах нь зохистой эсэхийг нягталж үзэх хэрэгтэй. Албан ёсны ажил эрхлэлтэд хамаатан саднаа илүүд үзэхийн өмнө зохистой ажил эрхлэлтийн зарчмыг баримтлах ёстой.

Хуульд захирагдах үүрэг

108. Шүүгч хуульд захирагдахгүй байх, шүүхийг үл хүндэтгэх, хуулийг үл хүндэтгэх байдлыг өөгшүүлэх зэрэг нь шүүхийн шударга байдлын талаарх олон нийтийн итгэлийг сулруулдаг. Гэхдээ үүнийг бас туйлын утгаар ойлгож бусдыг хуульд захирагдахыг шаардаж болохгүй. Тухайлбал, нацист дэглэмийн үеийн германы шүүгч нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зохицуулалт бүхий Ньуренбергийн хуульд захирагдах шүүхийн зарчмыг өөрөө зөрчиж болохгүй. Үүнтэй адил, Өмнөд Африкийн апартейдын дэглэмийн үеийн шүүгч шүүхийн дээрх зарчмыг мөн зөрчиж болохгүй. Заримдаа шүүгчийн албаны мөн чанараас хамааран, шүүгч нь хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүний эрхэм чанарыг илтэд зөрчсөн хууль тогтоомжийг бусдаар сахин биелүүлэх үүрэг хүлээдэг. Тиймээс хуульд захирагдах үүрэг хүлээсэн шүүгч нь хуульд захирагдах үүрэг, тангаргаасаа няцахаас илүүтэйгээр, шүүхийн албанаас чөлөөлөгдөх ёстой. Шүүгч нь хуульд захирагдах зарчмыг үгүйсгэхгүй байх үүрэгтэй. Тиймээс шүүгч хуульд захирагдах зарчимтай зөрчилдөх байр суурийг илэрхийлэх ёсгүй. Бусад хүнд харьцангуй бага зөрчил гэж үзэхээр шүүгчийн үйлдэл олон нийтийн анхаарлыг татаж, шүүгчийг муу нэртэй болгож, шүүгч ба шүүхийн шударга байдлын талаар эргэлзээ төрүүлэх боломжтой.

3.2. Шүүгчийн зан байдал, үйл ажиллагаа нь шүүхийн шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг бататган бэхжүүлэхэд чиглэнэ. Шүүхийн үйл ажиллагаа шударга байгаад зогсохгүй, тийнхүү шударга байна гэдгээ батлан харуулах ёстой.

ТАЙЛБАР

Шүүгчийн хувийн зан үйл шүүхийн тогтолцоонд бүхэлд нь нөлөөлдөг

109. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл шүүгчийн ур чадвар, хичээл зүтгэл төдийгүй, тэдний үнэнч шударга, ёс суртахууны хувьд тогтвортой байдалд тулгуурладаг. Шүүгч нь “сайн шүүгч” байхаас гадна “сайн хүн” байх ёстой. Олон нийтийн ойлголтоор, шүүгч нь хууль дээдлэх ёс, ардчиллын үндэс суурийг тавьсан шударга ёс, үнэний үзэл баримтлалд үйлчлэхээр амласан төдийгүй, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх ёстой. Иймээс шүүгчийн хувийн шинж чанар, зан байдал, дүр төрх шүүхийн тогтолцоонд бүхэлд нь нөлөөлөх бөгөөд үүнээс олон нийтийн итгэл хамаардаг. Олон нийтийн хувьд жирийн иргэнээс шаарддагаас илүү зан үйл болон нийгэмд тавигддаг ерөнхий шаарддагаас илүү өндөр стандартыг шүүгчээс шаарддаг. Үнэндээ, олон нийтийн зүгээс шүүгчээс өө сэвгүй байхыг шаарддаг. Шүүхийн чиг үүрэг нь бусдыг шүүж, тэдэнд шаардлага тавих үүрэг байдаг тул, бусдын зүгээс өгч буй шүүхийн үүрэг хариуцлага, үйл ажиллагаанд зохих ёсоор нөлөөлөх үндэслэл бүхий үнэлгээг шүүгч тусган авах ёстой.

Шударга ёс харагдаж байх ёстой

110. Харагдах байдал нь шүүн таслах ажиллагааг бодитоор хэрэгжүүлэхтэй адил чухал тул шүүгч нь аливаа сэжиг, хардлага төрүүлэх үйлдлээс хол байх ёстой. Шүүгч нь шударга байгаад зогсохгүй түүнийгээ бусдад харуулах ёстой. Шүүгч нь шударгаар, төвийг сахин шийдвэр гаргах үүрэгтэй төдийгүй шударга, хараат бус байдал болон шүүгчийн үнэн шударгын талаарх аливаа сэжиг, хардлагаас ангид байдгаа харуулах үүрэгтэй. Тиймээс шүүгч хууль тайлбарлах, хэрэглэх ур чадвартай байх ёстойн нэгэн адил шүүхийн өмнө ирсэн талууд шүүгчийн хараат бус байдалд бүрэн итгэлтэй байхуйцаар биеэ авч явах, түүнийгээ өөрийн үйлдлээр харуулах нь чухал юм.

ҮНЭТ ЗҮЙЛ 4: ЗОХИСТОЙ БАЙДАЛ

Зарчим:

Зохистой байдлыг эрхэмлэх, тийнхүү харагдах нь шүүгчийн хийж гүйцэтгэх бүхий л үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.

ТАЙЛБАР

Олон нийтийн нүдэнд яаж харагдах ёстой вэ?

111. Мэргэжлийн болон хувийн зүгээс зохистой байдлыг эрхэмлэх, зохистой байдалтай харагдах нь шүүгчийн амьдралын онцгой чухал зүйл юм. Үүнээс илүү чухал зүйл бол, шүүгч юу хийдэг, хийдэггүйн тухай бус, бусад хүн шүүгчийг юу хийсэн, юу хийх ёстой гэж бодож буй явдал юм. Жишээ нь, хянан хэлэлцэж буй хэргийн оролцогчтой шүүгч хувиараа удаан ярилцсан бол энэ нь тухайн этгээдэд давуу байдал бий болгосон гэж харагдана. Үүнд тэрхүү харилцан яриа тухайн хэрэгтэй огт хамааралгүй эсэх нь нөлөөлөхгүй. Шүүгч өндөр ёс зүйтэй байх ёстой гэж бодож буй, шүүгчийн зүгээс аливаа арга хэмжээнд оролцох, жижиг ч хамаагүй бэлэг авах эсэхдээ эргэлзэж буй бол “Олон нийтийн нүдэнд энэ нь яаж харагдах бол?” гэж өөрөөсөө байнга асууж байх хэрэгтэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хэрэглэх нь:

4.1. Шүүгч өөрийн бүхий л үйл ажиллагаандаа зохисгүй байдал гаргахгүй байж, тийнхүү зохисгүй байдалтай гэж харагдахгүйгээр биеэ авч явбал зохино.

ТАЙЛБАР

Зохисгүй байдлын шалгуур

112. Зохисгүй байдлын шалгуур нь шүүгч шүүн таслах үүргээ шударга, төвийг сахисан, хараат бусаар, зохих эрх хэмжээтэйгээр гүйцэтгэх чадваргүйг илтгэх зан байдал гаргасан буюу, ухаалаг ажиглагчийн оюун санаанд шүүгч тийнхүү шүүн таслах үүргээ хэрэгжүүлж чадамжгүй, хүсэлгүй байна гэж ухамсарлагдах байдал юм. Тухайлбал, төрийн албан тушаалтанг жирийн иргэнээс өөрөөр, хүндэтгэлтэй харьцаж, тусад нь тухтай суудалд суулгах үйлдэл нь ердийн ажиглагчийн нүдээр төрийн албан тушаалтан шүүхийн өмнө болон шийдвэр гаргах үйл явцад тусгай эрхтэй юм байна гэж харагдуулна. Ихэнхдээ шүүхтэй танилцаж буй сургуулийн хүүхдүүдийг бусдаас тусгайлсан хэсэгт суулгадаг. Хүүхдүүдийн хувьд, эрх мэдэл бүхий хэсэг бус, тэгээд ч тэдэнд боловсролын зорилгоор шүүхийг танилцуулан тайлбарлаж буй тул энэ нь зохисгүй байдалтай гэж харагдахгүй.

Зохисгүй харилцаа

113. Шүүгч нь хүмүүс түүнийг хэн нэгэнтэй онцгой харилцаатай байна гэсэн дүгнэлтэд хүрэх харилцаанаас зайлсхийх мэдрэмжтэй байх хэрэгтэй. Тухайлбал, шүүгч цагдаагийн болон бусад хуулийн байгууллагын ажилтны унаагаар гэртээ хүргүүлэхээс зайлсхийх бөгөөд нийтийн тээврээр зорчих үедээ хэргийн оролцогч, гэрч зэрэгтэй зэрэгцэж суухгүй байх хэрэгтэй.

4.2. Шүүгч нь олон нийтийн байнгын хяналтад байдаг тул жирийн хүний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөртөө тогтоох ёстой бөгөөд түүнийгээ ямар нэг шахалт шаардлагагүйгээр, сайн дураараа хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино.

ТАЙЛБАР

Шүүгч өөрийн үйл ажиллагаан дахь хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй

114. Шүүгч нь ямагт олон нийтийн хараа хяналт дор байдаг тул, энгийн иргэний хувьд дарамттай байж болох хязгаарлалтыг өөртөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Шүүгч нь сөрөг харагдахааргүй бол нийгмийн бусад гишүүн, мэргэжил нэгтний зохион байгуулж буй үйл ажиллагаанд чөлөөтэй, идэвхтэй оролцож болно. Энэ нь шүүгчийн мэргэжлийн болон хувийн зан үйлд нэгэн адил хамаатай. Шүүгчийн үйлдэл хууль ёсны байх нь түүний зохистой байдлыг бүрэн хэмжихгүй.

Үлгэр жишээчээр амьдрах шаардлага

115. Шүүгч нь бүрэн эрхийн хугацаандаа бусдад үлгэр жишээ болохуйц амьдрах хэрэгтэй. Шүүхийн үйл ажиллагаа нь шүүгчийг олон нийтэд үйлчлэхдээ мэдрэмжтэй байх, өөрийгөө хянахыг шаарддаг. Учир нь овилгогүй зан байдалтай харагдах нь шүүн таслах ажиллагаанд сөргөөр нөлөөлж, шүүхийн өндөр нэр хүндэд үл нийцнэ.

Зугаа цэнгээний гэх мэт олон нийт цуглардаг газарт очих

116. Өнөөдрийн байдлаар ихэнх улсад шүүгчийг зугаа цэнгээний баар, шар айргийн мухлаг, тэдгээртэй төсөөтэй

газарт очихыг хориглоогүй ч, шүүгч болгоомжтой байх ёстой. Шүүгч нь дээрх газруудад очиход олон нийтийн ухаалаг ажиглагч түүний энэ үйлдлийг хэрхэн хүлээн авахыг анхаарч үзэх хэрэгтэй. Тухайлбал, очих газрын нэр хүнд, ямар хүмүүс байнга цуглардаг, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг эсэхийг шүүгч харгалзан үзэх хэрэгтэй.

Мөрийтэй тоглох

117. Шүүгч амралт, чөлөөт цагаа мөрийтэй тоглож өнгөрүүлэхийг хориглодоггүй ч, болгоомжтой байх хэрэгтэй бөгөөд олон нийтийн ухаалаг ажиглагчийн энэ талаарх ойлголтыг анхаарч үзэх хэрэгтэй. Хааяа нэг морин тойруулгын уралдаан үзэх, гадаадад амралтаараа явах үедээ казино орох, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хөзөр тоглож болох юм. Харин шүүгчийн хувьд уралдааны бооцооны кассаар хэтэрхий олон удаа үйлчлүүлэх, улайрсан мөрийтэй тоглоомчин, мэргэжлийн тоглогч болох нь өөр асуудал болно.

Клуб зэрэг үйлчилгээний байгууллагаар байнга үйлчлүүлэх

118. Шүүгч нь клуб зэрэг нийгмийн арга хэмжээ явуулдаг үйлчилгээний газраар байнга үйлчлүүлэхдээ анхааралтай байх хэрэгтэй. Тухайлбал, шүүгчийн хувьд шүүхтэй байнгын харилцаанд байдаг цагдаа, авлигатай тэмцэх газар, гааль, татвар зэрэг байгууллагын алба хаагч, төлөөлөгчдийн ажиллуулдаг газарт байнга үйлчлүүлэхээс болгоомжлох хэрэгтэй. Цагдаагийн зэрэг харьяаллын газарт хоол идэх урилга хүлээн авахыг тусгайлан хориглоогүй ч, шүүгчийн хувьд тийм клубийн гишүүн байх, тогтмол очих, байнгын үйлчлүүлэгч байх нь зохимжгүй. Ихэнх нийгэмд шүүгч хуулийн мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох, нийгмийн харилцааны хүрээнд өмгөөлөгчидтэй тааралдах нь хэвийн үзэгдэл байдаг.

4.3. Шүүгч нь тухайн шүүхэд тогтмол үйл ажиллагаа явуулдаг хуульчидтай хувийн шугамаар харьцахдаа, хэн нэгэнд ашигтай байдал бий болгосон, нэг талыг барьсан гэх бодит сэжиг, таамаг төрүүлэхээс зайлсхийнэ.

ТАЙЛБАР

Нийгмийн харилцааны хүрээн дэх мэргэжлийн харилцаа

119. Шүүхийн албан хаагчид болон хуулийн мэргэжилтнүүдийн хооронд нийгмийн урт хугацааны уламжлалт, зохистой харилцаа бий. Шүүгч нь бодит ертөнцөөс тусгаарлагдаагүй тул, шүүгч өөрийн албан үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн мэргэжил нэгтнүүдтэй тогтоосон бүх харилцаагаа таслах боломжгүй гэж үздэг. Шүүгчийг нийгмийн бусад хэсэг буюу сургуулийн найзууд, хуучин ажлын хамтрагчид, хууль зүйн салбар дахь хамтран ажиллагсдаас тусгаарлах нь шүүхийн процесст бүхэлдээ ашигтай байдаггүй. Үнэндээ, шүүгч нь бусад хуульчидтай нийгмийн харилцаанд орох нь зарим талаар ашигтай байдаг. Ийм харилцаа нь шүүгч болон өмгөөлөгчдийн хоорондох маргааныг багасгахад тустай байж болох албан бус харилцаа юм. Гэхдээ шүүгч нийтлэг ойлголтын хүрээнд, болгоомжтой харилцах хэрэгтэй.

Хувь хуульчтай нийгмийн харилцаатай байх

120. Шүүгч нь тухайн шүүхэд тогтмол үйл ажиллагаа явуулдаг бусад хуульчтай нийгмийн харилцаанд орохдоо болгоомжтой байж, тухайн харилцааг тэнцвэржилтэй байлгах шаардлагатай. Нөгөө талаас, шүүгчийг нийгмийн болон шүүхийн бус харилцаанаас бүрэн татгалзахын шаардаж болохгүй. Нөгөө талаар, шүүгчийн өмнө найз, хамтран зүтгэгч

нь гарч ирснээр алагчлах, үзэмжээр хандах хадлага гарч ирэх нь тодорхой. Шүүгч нь тухайн хуульчтай ойр буюу хувийн харилцаатай, бусдад тийнхүү харагдах эсэхээс үл хамааран эцсийн эцэст шүүгч хэвээрээ байх ёстой. Шүүгч хүрээгээ хэрхэн тогтоохоо өөрөө шийднэ. Харин үүний гол шалгуур нь шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх нийгмийн харилцаа нөлөөлж буй эсэх, нийгмийн харилцааны мөн чанарын талаар бүрэн мэдээлэлтэй хувийн сонирхолгүй ажиглагчийн зүгээс шударга ёс тогтоно гэдэгт итгэж буй эсэх асуудал юм. Мөн шүүгчийн зүгээс түүний хянан хэлэлцэх буюу оролцох хэргийн талаар шүүхээс гадуурх мэдээлэлтэй болох санамсаргүй аюулаас болгоомжлох хэрэгтэй. Иймд шүүгч, хуульчдын хооронд ойр дотно харилцаа байна гэж ойлгогдохоор байвал, тухайн хэргийг хянан хэлэлцэхийн өмнө бусад хуульчтай харилцахаас зайлсхийх хэрэгтэй.

Нийгмийн харилцааны хүрээнд хуульчтай хөршийн харилцаанд орох

121. Шүүгч нь тухайн шүүхэд тогтмол үйл ажиллагаа явуулдаг хуульчтай хөрш бол, түүний хянан хэлэлцэж буй хэрэгт тухайн хуульч оролцож буйгаас бусад тохиолдолд нийгмийн харилцаанд орохоос татгалзах шаардлагагүй. Нөхцөл байдлаас хамааран шүүгч байнга татгалзах шаардлага гарахгүй, хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй нөхцөл байдал үүсэхгүй бол нийгмийн харилцааны зарим төвшинг хүлээн зөвшөөрөх боломжтой.

Нэг удаагийн арга хэмжээний үеэр бусад хуульчтай харилцах

122. Ахлах хуульчаар томилогдсон, мэргэжлийн амжилтаа тэмдэглэх гэх мэт баяр ёслолын арга хэмжээнд шүүгч оролцохыг хориглодоггүй. Хэдийгээр өмгөөлөгчид чиг үүргийн дагуу

шүүгчтэй байнга харьцаж байдаг ч, хянан хэлэлцэхээр болсон тухайн нэг хэргийн хуульчтай шууд нийгмийн харилцаа үүсгэхээс зайлсхийх ёстой. Хэрэв баяр ёслолын арга хэмжээний үеэр тааралдсан бол тодорхой хэргийн талаар ярилцахгүй байх ёстой. Нөхцөл байдлаас хамааран тэрхүү ярилцлагын талаар шүүх хуралдааны бусад оролцогч хамгийн түрүүнд мэдээлэлтэй болдог. Хамгийн гол асуудал бол нийгмийн иймэрхүү арга хэмжээ нь тухайн хуульчийг шүүгчтэй онцгой харилцаатай байдаг гэх ойлголт бий болгох, тийм ойлголт төрүүлэх хөшүүрэг болох эсэх, тухайн харилцаа нь шүүгчийн зүгээс хуульчийн үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжихэд эрмэлзэлтэй байдал бий болгох эсэх асуудал юм.

Энгийн зочломтгой байдал

123. Шүүгч нь өмгөөлөгч, бусад хуульчаас нийгмийн уулзалт, цугларалтад оролцох урилга хүлээн авахыг зөвшөөрдөг. Нийгмийн арга хэмжээний үеэр болж буй албан бус хэлэлцүүлгүүд ашиг тустай тул ийнхүү өмгөөлөгчидтэй нийгмийн харилцаанд орохыг сайшаадаг. Гэхдээ шүүгч нь бусад хуульчаас бэлэг, дурсгалын зүйл авч болохгүй бөгөөд хуулийн фирм, нөхөрлөлөөс зохион байгуулж буй энгийн зочломтгой байдлаас хэтэрсэн арга хэмжээнд оролцож болохгүй. Үүний шалгуур бол тэрхүү үйл ажиллагааг ухаалаг ажиглагч хэрхэн харж буй байдал юм.

Хуулийн фирмээр зочлох

124. Шүүгч нь хуулийн фирмээс зохион байгуулж буй үдэшлэгт оролцох эсэх нь тухайн үдэшлэгт хэн оролцох, хэн ивээн тэтгэж байгаа болон үдэшлэгийн мөн чанараас ихээхэн хамаарна. Оролцох эсэхээ шийдэхийн тулд, шүүгч нь дотоод итгэл болон өмнөх үйл баримтын талаарх мэдлэгтээ найдах хэрэгтэй. Нөхцөл байдлаас хамаарч шүүгч хэн оролцохоор

уригдсан талаар болон төлөвлөгдсөн үйл ажиллагааны цар хүрээг зохион байгуулагчаас асуух хэрэгтэй. Тухайлсан нэг хуулийн фирм өөрийнхөө маркетинг буюу үйлчлүүлэгч, боломжит үйлчлүүлэгчдэдээ зориулсан арга хэмжээ эсэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Мэргэжлийн холбоодоос зохион байгуулж байгаа үйл ажиллагаа (ихэвчлэн шүүгчийг ерөнхий сэдвээр ярихыг урих нь олонтоо тохиолддог) болон тухайлсан хуулийн фирмийн зохион байгуулах үйл ажиллагааны хооронд тодорхой ялгаа байдаг. Шүүгч нь хуулийн фирмийн үдэшлэгт оролцохдоо шүүгчийн төвийг сахих байдалд нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангах ёстой.

Өмнө нь ажиллаж байсан хуульчдын танхим, фирм, албан газарт зочлох

125. Шүүгч урьд нь ажиллаж байсан хуульчдын танхим, фирмд зочлох нь хэр зохимжтойг үнэлж байх хэрэгтэй. Тухайлбал, шүүгч нь шинэ жилийн, ойн үдэшлэг, танхимын гишүүн нь ахлах хуульч, шүүгчээр томилогдсоныг тэмдэглэх үдэшлэг зэрэг тусгайлсан үйл ажиллагаанд оролцохоор, өмнө нь ажиллаж байсан танхим, хуулийн фирмд зочлох нь ерөнхийдөө зохистой байдаг. Харин нөхцөл байдлаас хамааран, шүүгч нь хуучин хамтран ажиллагсадтайгаа уулзахаар хэт их буюу байнга очих нь зохистой биш юм. Өмнө нь прокуророор ажиллаж байсан шүүгчийн хувьд, хуучин хамт ажиллаж байсан прокурор, цагдаагийн ажилтантай хэт ойр байхаас зайлсхийх хэрэгтэй. Албаны чиг үүрэг, үйл ажиллагаа ялгаатай хүмүүстэй хамт байж харагдах нь ухаалаг бус юм.

Хэргийн оролцогчидтой харилцах харилцаа

126. Шүүгч нь сайд, түүний албан тушаалтнууд, орон нутгийн албан тушаалтнууд, цагдаагийн удирдлага, дүүргийн прокурор, улсын өмгөөлөгч зэрэг хэргийн оролцогчидтой хэт

ойр дотно харилцахаас зайлсхийхийг эрмэлзэх ёстой. Ийм харилцаа нь алагчилсан байдалтай харагдах төдийгүй хожим шүүгчээс татгалзах нөхцөл болно. Иймд шүүгч бусад хуульч, албан тушаалтантай харилцахдаа хэр давтамжтай уулзаад, шүүгч тухайн хувь хүний хоорондын нийгмийн харилцааны төвшин, хуулийн этгээдийн соёл, одоогийн буюу цаашид гарах хэргийн шинж чанарыг харгалзан үзвэл зохистой.

Хаалттай нийгэмлэг дэх гишүүнчлэл

127. Шүүгч нь тухайн шүүхэд тогтмол үйл ажиллагаа явуулдаг хуульчтай хаалттай нийгэмлэгийн гишүүнчлэлтэй байх, тийм нийгэмлэгтэй холбогдохгүй байх хэрэгтэй. Учир нь хаалттай нийгэмлэгийн гишүүд, ялангуяа хуульч гишүүд ах дүүгийн барилдлагатай байдаг тул шүүгчид нөлөөлөх эрсдэлтэй.

4.4. Шүүгчийн гэр бүлийн гишүүдээс хэн нэгэн нь хэргийн нэг талыг төлөөлөн оролцож байгаа, эсхүл тухайн хэрэгт ямар нэг байдлаар холбоотой тохиолдолд шүүгч хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй.

ТАЙЛБАР

Заавал татгалзах нөхцөл

128. Хэрэв шүүгчийн гэр бүлийн гишүүн (сүйт бүсгүй/ залуу нэгэн адил хамаарна) хуулийн зөвлөх, хуульчийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон буюу тийн оролцсон гэж харагдсан бол шүүгч өөрөө татгалзах үүрэгтэй.

Хэрэв гэр бүлийн гишүүн хуулийн фирмтэй харилцан хамааралтай бол

129. Хуулийн фирмийн гишүүд ашиг, зардлаа хуваадаг бөгөөд үйлчлүүлэгч олж авах, тэдний хэргийг амжилттай шийдвэрлүүлэх эрмэлзэлтэй байдаг. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хуульч шүүгчийн гэр бүлийн гишүүн ажилладаг хуулийн фирмтэй харилцан хамааралтай бол шүүгч татгалзах шаардлагатай. Тухайн нөхцөл байдал шүүгчийн төвийг сахих байдалд бодит эргэлзээ төрүүлдэг ба шүүгчийн гэр бүлийн гишүүн хуулийн фирмтэй ашиг сонирхол нэгтэй байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд ноцтой нөлөөлөх тул шүүгчийн татгалзал шаардлагатай. Түүнчлэн, шүүгч хэрэгт дүгнэлт хийх замаар дараах зүйлийг харгалзах хэрэгтэй бөгөөд харгалзах зүйл үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- 1) Олон нийтэд татгалзах ёстой алдаа дутагдал гэж харагдах байдал;

- 2) Бусад хуульч, шүүгч, олон нийтийн төлөөлөлд татгалзах ёстой гэж харагдах байдал;
- 3) Татгалзалтай холбоотой шүүх дэх захиргааны ачаалал;
- 4) Тухайн хэрэгт хамаатан садны, санхүүгийн, мэргэжлийн болон бусад ашиг сонирхлын цар хүрээ.

Хэрэв гэр бүлийн гишүүн төрийн байгууллагад хуульчаар ажилладаг бол

130. Хэдийгээр төрийн албаны хуульчид тогтмол цалин авдаг, эдийн засгийн болон ашиг олох сэдэлгүй ч, ихэвчлэн эрүүгийн болон иргэний хэргийн үр дүнгээс хамааралтай, мэргэжлээрээ амжилтад хүрэх эрмэлзэлтэй байдаг. Гиймээс, гэр бүлийн гишүүн нь улсын прокурорын газар, улсын өмгөөлөгчийн газарт ажилладаг, хяналт тавих буюу захиргааны албан тушаал хашдаггүй байсан ч, шүүгч болгоомжтой хандахын үүднээс тэдгээр байгууллагатай холбоотой бүх хэргээс дараах хоёр үндэслэлээр татгалзах шаардлагатай. Нэгдүгээрт, хэлэлцэж буй хэргийн талаар тухайн байгууллагын алба хаагчид мэдээлэл хуваалцдаг тул шүүгчийн гэр бүлийн гишүүн түүнд санамсаргүй байдлаар холбогдох, нөлөөлөх эрсдэлтэй. Үүнд шүүгчийн гэр бүлийн гишүүн хяналт тавих үүрэг хариуцлагатай эсэх нь хамааралгүй. Хоёрдугаарт, шүүгчийн төвийг сахих байдалд бодит асуудал үүснэ. Үүний шалгуур нь шүүгчийн гэр бүлийн гишүүн ажилладаг гэх шалтгаанаар тухайн байгууллагын амжилтын төлөө шүүгч санаатай буюу санамсаргүй байдлаар алагчлах магадлалтай гэж ухаалаг ажиглагчийн зүгээс ихээхэн эргэлзээ төрөх байдал юм.

Хуульчтай болзох

131. Шүүгч нь хуульчтай болзож байгаа үедээ тухайн хуульч албан ёсны оролцоотой, бусад байдлаар бүртгэлтэй гэж харагдахгүй байхаас бусад тохиолдолд, тухайн хуульчтай

холбоотой хэрэг маргаанд оролцохгүй. Гэхдээ шүүгч нь тухайн хуульчийн хамааралтай хуулийн фирм, ажлын газрын бусад гишүүний оролцсон хэрэгт оролцохоос өөрөө татгалзах шаардлагагүй.

Зөвхөн ганц шүүгч, ганц хуульчтай тойрог

132. Зөвхөн ганц шүүгч даргалж, прокурорын газрын буюу улсын өмгөөлөгчийн газрын нэг хуульч оролцдог шүүхийн тойрог байдаг. Хэрэв шүүгчийн хүү, охин, бусад ойрын хамаатан садан нь тэрхүү хуульч байвал, шүүгч нь өөрийн хариуцаж буй бүх эрүүгийн хэргээс заавал татгалзана. Ингээгүй нь тухайн бүс нутаг дахь бусад шүүгч (татгалзсан шүүгчийн оронд дуудагдсан шүүгч) төдийгүй шүүгдэгч нэгэнд адил хүнд байдалд ордог. Мөн тэрхүү эрүүгийн бүх хэрэгт оролцох шүүгчийг томилох хүртэл, түргэн шуурхай шүүлгэх шүүгдэгчийн эрхийг баталгаажуулахад хүндрэлтэй болдог. Иймд дээрх нөхцөл байдалд татгалзах нь туйлын шаардлага биш боловч, ийм нөхцөл байдлаас боломжийн хэрээр зайлсхийх хэрэгтэй.

4.5. Шүүгч нь хэн нэгэн хүн болон хуульчийг үйлчлүүлэгчтэйгээ болон бусадтай уулзахад өөрийн албан өрөө, орон байраа ашиглуулж болохгүй.

ТАЙЛБАР

Шүүгчийн албан өрөө, орон байр, утсан холбоог ашиглах

133. Шүүгч нь өөрийн албан өрөө, орон байрыг хэн нэгэн хуульчийг үйлчлүүлэгчтэйгээ болон бусад хуульчтай уулзахын тулд ашиглахыг зөвшөөрөх нь зохисгүй. Шүүгчийн эхнэр/нөхөр буюу гэр бүлийн бусад гишүүн нь хуульч бол, шүүгч өөрийн утсан холбоогоо хууль зүйн үйлчилгээтэй холбоотойгоор тухайн хуульчтай хуваалцах ёсгүй. Учир нь, ийм нөхцөл үүсвэл, шүүгч бусад хуульчийн нэгэн адил хууль зүйн үйлчилгээ үзүүлж байна гэх ойлголт бий болох бөгөөд санамсаргүй байдлаар ашиг сонирхлын зөрчил байна, тийм харилцаатай гэж харагдах, тийм харилцаанд сэрдэгдэх магадлалтай.

4.6. Шүүгч нь бусад иргэний нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг эдлэхдээ шүүхийн өндөр нэр хүнд, бие даасан, төвийг сахисан байдлыг хүндэтгэн дээдэлж биеэ авч явна.

ТАЙЛБАР

Шүүгч бусад иргэний нэгэн адил эрх эдэлнэ

134. Шүүгчээр томилогдсон нь түүнийг нийгмийн бусад гишүүний нэгэн адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхэд саад болохгүй. Гэхдээ шүүгч нь улс төрийн итгэл үнэмшил, улс төрийн ашиг сонирхлоо нээлттэй илэрхийлж болохгүй. Шүүгч нь шүүхийн бие даасан, төвийг сахих байдлын талаарх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд даруу төлөв байх шаардлагатай. Шүүхтэй холбоотой олон нийтийн маргаан, мэтгэлцээнд ямар хэмжээнд оролцохыг тодорхойлоход хоёр хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, шүүгч тухайн асуудалд оролцох нь түүний төвийг сахих байдлын талаарх итгэлийг алдах бодит эрсдэлтэй байгаа эсэх. Хоёрдугаарт, тэрхүү оролцоо нь шүүгчийг улс төрийн дайралтад өртүүлэх, шүүхийн албаны нэр хүндэд үл нийцэх эсэх асуудал юм. Хэрэв ийм нөхцөл байдалд бий болохоор бол шүүгч оролцохоос зайлсхийх хэрэгтэй.

Нийцэхгүй үйл ажиллагаа

135. Үндэсний парламент болон орон нутгийн зөвлөлийн гишүүн байх зэрэг улс төрийн тодорхой үйл ажиллагаа нь шүүгчийн үүрэгтэй нийцэхгүй.

Олон нийтийн маргаан, мэтгэлцээнд шүүгч оролцох ёсгүй

136. Шүүгч өөрөө олон нийтийн маргаанд оролцох нь зохисгүй. Шалтгаан нь тодорхой. Хэрэг, маргааныг бодитоор, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэрлэх чадвар нь шүүгчийн гол шинж чанар юм. Үүнээс гадна, шүүгч нь олон нийтэд алагчлах үзэлгүй, гадуурхах хандлагагүй, төвийг сахисан, оюун санаа нь цэлмэг, шийдвэрийг шударгаар гаргана гэж харагдах байдал нэгэн адил чухал юм. Хэрэв шүүгч маргаантай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн дунд маргаан үүсгэх, засгийн газрыг ил тод шүүмжлэх зэргээр улс төрийн тавцанд гарч, олон нийтийн мэтгэлцээнд оролцдог бол тухайн шүүгчийг шүүхэд ажиллаж шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж байна гэж олон нийт харахгүй. Шүүгч тийнхүү үзэл бодлоо илэрхийлсэн асуудалтай нь холбоотой маргааныг шийдвэрлэх нь төвийг сахиагүй гэж харагдана. Ялангуяа, шүүгчийн зүгээс өмнө нь ил тод шүүмжилж байсан олны танил хүн, төрийн байгууллага хэргийн оролцогч, нэхэмжлэгч, гэрчээр оролцож буй хэрэг, маргааныг шүүгч төвийг сахин шийдвэрлэж чадахгүй гэж харагдах эрсдэлтэй.

Шүүгчийг шүүмжлэх

137. Олон нийтийн, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын төлөөллийн зүгээс шүүгчийн алдаа дутагдал, шийдвэрийг хэрхэн үзэж буйгаа ил тодоор илэрхийлдэг. Улс төрийн шинжлэх ухааны тогтоосон заншлын дагуу, ийм сэтгэгдэлд шүүгч гол төлөв хариу өгдөггүй. Шүүгчийг шүүмжлэх эрхийг гүтгэлэгтэй холбодог, өмнө нь шүүх эрх мэдэл, шүүгчийг шүүмжилбэл шийтгэдэг байсан бол өнөөдөр энэ нь ховор үзэгдэл болсон байна. Илүү сайн, ухаалаг арга бол жигшил зэвүүцлийг өдөөж, байдлыг улам хүндрүүлэхийн оронд ямарваа нэг дайралтыг үл тоомсорлох явдал болж. Иймд “Шударга ёс бол амьдралаас тасархай ариун

журам биш. Шүүгчийн хувьд энгийн хүмүүсийн ямар ч санал, шүүмжлэлд анхаарал хандуулж, хүндэтгэх ёстой” гэдэг болж.⁵⁰

Шүүх эрх мэдэлд хамаатай асуудлаар шүүгч саналаа хэлж болно

138. Улс төрийн хувьд маргаантай ч, шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн бие даасан байдал (үүнд шүүгчийн цалин, хангамж хамаарна), шүүх эрх мэдлийн үндэс суурьт шууд нөлөөлөх асуудлаар шүүгч саналаа хэлэх нь зохистой гэж үздэг. Гэхдээ эдгээр асуудалд ч шүүгч маш хянамгай хандах ёстой. Эдгээр асуудлаар шүүгч нь олон нийтийн төлөөлөл болохын хувьд, засгийн газарт хандан байр сууриа илэрхийлэх нь зохистой. Харин шүүгчийн зүгээс засгийн газрыг “лоббидож” буй мэт, эсвэл тухайн нөхцөл байдлыг шүүх хэрхэн шийдвэрлэх талаар саналаа хэлж буй мэт харагдаж болохгүй. Түүнчлэн, шүүгч түүний нээлттэй сэтгэгдэл, тайлбар шүүхийн талаарх үзэл бодолд нөлөөлдгийг санах хэрэгтэй. Заримдаа, шүүгчийн үзэл бодлыг ерөнхий байдлаар гаргаагүй, шүүх эрх мэдэлтэй хамааралгүй, цэвэр хувийн үзэл бодол гэж хүлээж авах хүндрэл гардаг.

Шүүгч хуулийн хэлэлцүүлэгт оролцож болно

139. Шүүгч нь боловсролын зорилготой хуулийн хэлэлцүүлэг буюу хууль хэрэглээний хүндрэлийг илрүүлэх ярилцлагад оролцож болно. Зарим онцгой нөхцөлд, шүүгчийн зүгээс албан бус, үндсэн хуулийг тайлбарлахгүйгээр хуулийн төслийн талаар гаргасан санал нь ашигтай, зохистой байдаг. Ер нь, хууль тогтоомжийн төсөл, засгийн газрын бодлогын бусад асуудлаар гарсан шүүхийн тайлбар нь практик ач холбогдолтой, алдаа дутагдлыг залруулахад чиглэдэг, харин

⁵⁰ *Ambard v. Attorney General for Trinidad and Tobago*, Privy Council on appeal from the Court of Appeal of Trinidad and Tobago [1936]AC 322 at 335, per Lord Atkin.

ингэхдээ улс төрийн маргаантай асуудлаас зайлсхийх ёстой. Товчхондоо, шүүхийн гаргаж байгаа тайлбар нь хувь шүүгчийн бус, шүүхийн хамтын хүчин чармайлтын нэг хэсэг байх ёстой.

Шүүгч нь дэмжин ярих ёс суртахууны үүрэгтэй болох үе бий

140. Шүүгч нь ухамсар, ёс суртахуун, мэдрэмж, үнэт зүйлтэй хүний хувьд дэмжин ярих ёс суртахууны үүрэгтэй болох үе бий. Тухайлбал, шүүгч нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ, дайныг эсэргүүцэх, эрчим хүчний хэмнэлт, хараат бус байдлыг дэмжих, ядуурлын эсрэг агентлагийг санхүүжүүлэхээр гарын үсэг зурах, өргөдөлд гарын үсэг зурах, эсэргүүцлийн жагсаалд нэгдэх боломжтой. Эдгээр зүйлс нь орон нутгийн болон дэлхий даяарх нийгэмд санаа зовоосон зүйлсийн талаарх илэрхийлэл юм. Хэрэв шүүхэд эдгээр асуудлаар маргаан үүссэн, шүүгчийн дээрх үйл ажиллагаа нь шүүгчийн төвийг сахих, шүүхийн шударга байдалд эргэлзэх бодит нөхцөл болбол шүүгч өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзана.

4.7. Шүүгч нь өөрийн хувийн болон түүнд итгэмжлэгдсэн санхүүгийн ашиг сонирхлын тухайд өөрөө мэдүүлэх, түүнчлэн шүүгчийн гэр бүлийн гишүүдийн санхүүгийн ашиг сонирхлын талаарх мэдээллийг өөртөө авах боломжтой арга хэмжээ авна.

ТАЙЛБАР

Санхүүгийн ашиг сонирхлыг ухамсарлах үүрэг

141. Хэрэв шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүгчийн шийдвэрийн үр дүнд түүний буюу, шүүгчийн гэр бүлийн гишүүн, шүүгчтэй итгэмжлэлийн харилцаатай хэн нэгэнд санхүүгийн ашигтай байдал бий болохоор бол, шүүгч нь шийдвэр гаргахад оролцохгүй байхаас өөр сонголтгүй. Тиймээс шүүгч нь үргэлж өөрийн хувийн буюу итгэмжлэлийн харилцаатай этгээдийн болон гэр бүлийн санхүүгийн ашиг сонирхлыг ухамсарлаж байх шаардлагатай. “Итгэмжлэлийн харилцаа” гэдэгт гүйцэтгэгч, захирагч, итгэмжит өмчлөгч, асран хамгаалагчийн хувиар оролцох харилцаа багтана.

Санхүүгийн ашиг сонирхол

142. Санхүүгийн ашиг сонирхол гэдэгт хууль ёсны эд хөрөнгө, түүнтэй адилтгах хүү, буюу тэрхүү санхүүгийн асуудлаарх байгууллага, институт дахь захирал, зөвлөх, бусад идэвхтэй оролцогчтой харилцаатай байхыг ойлгоно. Дараах нөхцөл санхүүгийн ашиг сонирхолд тооцогдохгүй. Үүнд:

- 1) Хамтын хөрөнгө оруулалтын санд эзэмшиж буй үнэт цаасны хувьд, тэрхүү үнэт цаас “санхүүгийн ашиг сонирхол” үүсгэхгүй;

- 2) Боловсролын газар, шашин, хүмүүнлэгийн буюу иргэний байгууллагад эзэмшиж буй үнэт цаас “санхүүгийн ашиг сонирхол” үүсгэхгүй;
- 3) Хамтын даатгалын компанид хөрөнгө даатгуулагч, хамтын хадгаламжийн холбоонд хадгаламж эзэмшигч буюу төстэй эд хөрөнгийн эрх эзэмшигч бөгөөд, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн нь хүүгийн үнэ цэнд ноцтой нөлөөлөх бол тухайн байгууллагад “санхүүгийн ашиг сонирхолтой” гэж үзнэ;
- 4) Засгийн газрын үнэт цаасны эзэмшигч бөгөөд зөвхөн аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн нь тэрхүү хувьцааны үнэ цэнд ихээхэн нөлөөлөхөөр бол, тухайн үнэт цаас гаргагчтай “санхүүгийн ашиг сонирхолтой” гэж үзнэ.

4.8. Шүүгч нь түүний гэр бүл, нийгмийн болон бусад харилцаа нь шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаа, шүүгчийн шийдвэрт зүй бусаар нөлөөлөх байдлыг гаргуулахгүй байх ёстой.

ТАЙЛБАР

Зохисгүй нөлөөнд орохоос зайлсхийх үүрэг

143. Шүүгч нь түүний гэр бүл, найз нөхөд, нийгэм, иргэн, мэргэжлийн хамтрагчтайгаа харилцан ашиг сонирхол, санаа зовоосон зүйлийн талаар харилцах, байнга холбоотой байх нь түүнийг шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зохисгүй нөлөөнд оруулах буюу тийм нөлөөнд орсон гэж харагдуулна. Тэд өөрсдийн аргаар буюу үйл ажиллагаагаар хэргийн оролцогч, хуульчид нөлөөлөхийг хичээдэг байж болно. Шүүгч нь шүүхийн зан үйл, шийдвэрт нь ийм харилцаа зориуд нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангахын тулд онцгой анхаарах хэрэгтэй.

Өөрийн ашиг сонирхлыг дагахаас зайлсхийх үүрэг

144. Шүүгч нь шүүхийн албаны давуу байдлыг хувьдаа ашиг олох, хувийн хариу арга хэмжээ авахад ашиглах нь эрх мэдлээ урвуулан ашиглах нөхцөл юм. Эрх мэдлээ урвуулан ашиглах нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг маш их зөрчдөг тул, шүүгч нь түүнийг хувийн ашиг сонирхол, ялгаварлан гадуурхах байдалд хөтлөгдөн шийдвэр гаргасан гэж үзэх бүхий л үйл ажиллагаанаас зайлсхийх ёстой.

4.9. Шүүгч нь өөрийн болон гэр бүлийн гишүүний, түүнчлэн өөр бусад этгээдийн хувьд давуу байдал бий болгохын төлөө шүүхийн нэр хүндийг ашиглахгүй, тийнхүү ашиглахыг зөвшөөрөхгүй бөгөөд, хэн нэгэнд шүүгчийн нэрийн өмнөөс ийм байдлыг ашиглахыг зөвшөөрөхгүй төдийгүй, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд хэн нэгэн хүн зүй бусаар нөлөөлж чадахуйц тийм байдалтай байна гэж бусдад ойлгогдох, тийм сэтгэгдлийг төрүүлэхгүй байх ёстой.

ТАЙЛБАР

Шүүхийн албан тушаалыг зохистой, зохисгүй ашиглахыг ялгах үүрэг

145. Шүүгч нь олон нийтийн хувьд, шүүхэд төдийгүй шүүхээс гадуур үлгэр дуурайлалтай, онцгой хүн гэж үнэлэгддэг. Тиймээс шүүгч нь шүүхийн нэр хүндийг зохистой, зохисгүй ашиглаж байгаагаа ялгах ёстой. Шүүгчийн хувьд, өөрийн албан тушаалыг хувьдаа ашиг хонжоо олох, ямар нэг төрлийн хөнгөлөлт, давуу байдал бий болгохоор ашиглах нь зохисгүй. Тухайлбал, шүүгч нь хувьдаа ашиг хонжоо олохын тулд шүүхийн хэвлэмэл хуудсыг хувийн зорилгоор ашиглах ёсгүй. Шүүгч нь өөрийгөө хуулийн дарамт, хүнд суртлаас чөлөөлөхийн тулд, албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг урвуулан ашиглахыг оролдох, тийнхүү оролдож байна гэж илэрхий харагдах ёсгүй. Хэрэв замын хөдөлгөөний зөрчилтэй холбоотойгоор шүүгчийг зогсоосон бол, шүүгч нь өөрийн санаачилгаар шүүхийн ажил, албан тушаалаа хууль сахиулах албан хаагчид танилцуулах ёсгүй. Шүүгчийн туслах замын хөдөлгөөний зөрчил гаргасан торгуулийн хуудастай холбоотойгоор шүүгч прокурор руу утасдаж, “ямар нэг юм

болсон эсэх”-ийг асуух нь зохисгүй байдалтай харагдана. Дээрх тохиолдолд шүүхийн албан тушаалыг хэргийн үр дүнд нөлөөлөхөөр ашиглахыг оролдсон эсэх нь чухал биш юм.

Шүүгчийн албан тушаалаа нуух шаардлагагүй

146. Шүүгч нь шүүхэд хашиж буй албан тушаалаа нуух шаардлагагүй боловч, шүүгч гэдгийнхээ хувьд давуу байдал, хөнгөлөлт авна гэх ойлголт төрүүлэхээс зайлсхийхийг эрмэлзэнэ. Тухайлбал, хэрэв шүүгчийн хүү, охин баривчлагдвал, бусад эцэг эхийн адил санаа зовж, тэдгээрийг зовж шаналахыг мэдээж хүсэхгүй. Гэхдээ шүүгч шууд буюу хүнээр дамжуулан хууль сахиулах албан хаагчтай холбоо барьж, шүүгчийн албан тушаалаа хэлэх, баривчилсан офицерыг дэг журамтай байхыг шаардах нь эцэг, эх ба шүүгчийн хоорон дахь заагийг бүдгэрүүлнэ. Эцэг, эхийн хувиар, шүүгч хүү, охиндоо туслах, хүүхдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрхтэй ч, шүүгч бус бусад эцэг, эхийн хувьд боломжгүй үйлдлийг хийх эрхгүй. Шүүгчийн албан тушаалаа ашиглаж, хуулийн дагуу үүргээ хэрэгжүүлж буй бусад төрийн албан хаагчид нөлөөлөхийг оролдох нь эцэг, эхийн эрх, үүргээсээ хальж, шүүхийн нэр хүндийг урвуулан ашиглаж буй хэрэг юм.

Шүүхийн хэвлэмэл хуудсыг ашиглах

147. Шүүхийн хэвлэмэл хуудсыг хэрэглэхдээ шүүхийн нэр хүндийг буруугаар ашиглах байдал гаргаж болохгүй. Ерөнхийдөө, шүүхийн хэвлэмэл хуудсыг шүүгчийн зүгээс албан ёсны бичиг үйлдэхэд ашигладаг. Шүүхийн хэвлэмэл хуудсыг хувийн зүйл бичихдээ хэрэглэх бол анхааралтай байх хэрэгтэй. Тухайлбал, нөхцөл байдлаас хамааран, нийгмийн үйл явдлын дараа талархлын зурвас илгээхдээ тэрхүү хэвлэмэл хуудсыг хэрэглэхийг хориглохгүй. Гэхдээ шүүхийн хэвлэмэл

хуудсыг захиа хүлээн авагчид нөлөөлөхийн тулд хэрэглэж, шүүгч албан тушаалдаа анхаарал хандуулахыг хүсэж байна гэх ойлголт төрүүлэх нь зохисгүй. Тухайлбал, даатгалын бичиг баримттай холбоотой хүсэлт гаргахдаа шүүхийн хэвлэмэл хуудсыг хэрэглэх нь зохисгүй.

Тодорхойлолт гаргах

148. Шүүгч бусдад тодорхойлолт гаргаж өгөхийг хориглодоггүй. Гэхдээ тийм тодорхойлолт бичүүлэх хүн нь шүүгчийн сайн таних хүний хувиар бус, зөвхөн шүүгчийн нэр хүндийг ашиглахыг хичээж буй эсэхийг тунгаах хэрэгтэй. Ерөнхийдөө тодорхойлолт гаргахдаа шүүхийн хэвлэмэл хуудсыг зөвхөн шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үедээ хувь хүнийх нь талаар хувийн мэдлэг олж авсан хүний хувьд хэрэглэнэ. Дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- 1) Шүүгч нь мэдэхгүй хүнийхээ талаар тодорхойлолт гаргаж болохгүй.
- 2) Ердийн ажил хэргийн шугамаар тогтсон журмын дагуу шүүгч тодорхойлолт гаргаж болно. Жишээ нь, ажил эрхлэлтийн байдалтай холбоотойгоор, шүүхийн ажилтанд тодорхойлолт гаргаж өгч болно. Энэ нь тухайн тодорхойлж буй хүнийг шүүгч хэрхэн мэддэг болсон, хэр мэддэг талаар бичихээс гадна хэнд хандсан, хаягласан болохыг цуг бичнэ. Шүүгчийн туслах зэрэг шүүгчийн удирдлагад буй ажилтан нь өөр ажил эрхлэхээр тодорхойлолт бичүүлж буй үед тодорхойлолтын гарчгийг ерөнхийдөө “Тодорхойлолт” гэж бичиж болно.
- 3) Шүүгч нь төрөл садан, дотны найз зэрэг мэргэжлийн хувьд бус, хувь хүнийх нь хувьд мэддэг хүнийхээ хүсэлтээр түүний тухай хувийн тодорхойлолт гаргаж болно.

Мэдүүлгийн шинж байдлыг харгалзах үзэх

149. Гэрчийн хувиар өгсөн шүүгчийн мэдүүлэг нь, тэрхүү шүүгчийн мэдүүлэг өгсөн ажиллагаан дахь шүүхийн албаны нэр хүндэд нөлөөлдөг бөгөөд албан ёсны мэдүүлгийн талаар буруу ойлголт бий болгоно. Түүнчлэн, шүүгчийг гэрчийн мэдүүлэг өгөх үед, шүүгчийн өмнө байнга ирдэг хуульчийн хувьд, мэдүүлгийг няцаах асуулт асуух болоход эвгүй байдалд ордог. Тиймээс шүүгч нь сайн дураараа нотлох баримтын шинжтэй зүйл өгч болохгүй. Хэрэв тийм зүйлийг шүүгчээс хүссэн бол, шүүгч нь зөвхөн нотлох баримт хайж буй этгээдэд шударга бус байх нь илэрхий нөхцөлд мэдүүлэг өгч болно. Тухайлбал, шүүгчээс өөр шүүхийн ажилтан тийнхүү мэдүүлэг өгөх эрхтэй үед, шүүгч мэдүүлэг өгөх шаардлагагүй. Гэхдээ энэ нь заавал өгөх ёстой мэдүүлгээс шүүгчийг чөлөөлөхгүй.

150. Хуульчийн холбогдсон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Хуульчдын холбооны ажилтан руу сайн дураараа бичсэн зүйл, утсаар ярьсан яриа нь хүчин төгөлдөр гэрчийн мэдүүлэгт тооцогдох бөгөөд ингэснээр тухайн хуульчийн хувийн ашиг сонирхлыг дэмжихэд шүүхийн албаны нэр хүндийг зээлдүүлсэн болно. Үүнтэй адилаар албан ёсны хүсэлтгүйгээр, шүүгчид нэр дэвшигчийн өмнөөс сайн дураараа холбоо барих нь гэрчийн хувиар мэдүүлэг өгсөнтэй адил бөгөөд өөр нэг хувийн ашиг сонирхлыг дэмжихэд шүүхийн албаны нэр хүндийг зээлдүүлж буй нөхцөл юм.

Ном, хэвлэлийн бүтээлд хувь нэмрээ оруулах

151. Хууль эрх зүйтэй холбоотой эсэхээс үл хамааран шүүгч ном хэвлүүлэх, бүтээл туурвих, тийм бүтээлд хувь нэмрээ оруулахад онцгойлон анхаарах зүйл бий. Шүүгч нь тухайн хэвлэл бүтээлтэй холбоотой хэн нэгэнд шүүгчийн албаны нэр хүндийг ашиглахыг зөвшөөрөх ёсгүй. Шүүгчийн албаны нэр хүндийг ашиглуулахаас зайлсхийхийн тулд шүүгч

өөрийн зохиол бүтээлийг хэвлүүлэх гэрээгээр дамжуулан зар сурталчилгаанд хангалттай хяналт тавих эрхтэй байна.

Арилжааны радио, телевизийн нэвтрүүлэгт оролцох

152. Шүүгч арилжааны радио, телевизийн нэвтрүүлэгт оролцох нь тухайн байгууллага буюу ивээн тэтгэгчийн санхүүгийн ашиг сонирхлыг дэмжиж байна гэж харагдах магадлалтай. Иймд шүүгч нь тийнхүү оролцохдоо анхааралтай хандах хэрэгтэй. Нөгөө талаар, олон иргэд мэдээллийн хэрэгслээс үйл явдал, нийгмийн болон хуулийн талаарх мэдлэгээ баталгаажуулдаг. Тиймээс оролцох эсэх нь тухайн арга хэмжээнээс хамаарна, тухайлбал эрх зүйн хөтөлбөрт оролцох нь зохистой байж болно. Ийнхүү тэдгээр нэвтрүүлэгт оролцох эсэхээ тодорхойлохын тулд хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Тодруулбал, нэвтрүүлгийн гарах давтамж, үзэгчид, сэдэв, тухайн нэвтрүүлэг арилжааны шинжтэй эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй. Жишээ нь, нөхцөл байдлаас хамааран шүүх эрх мэдлийн чиг үүрэг, шүүх ба олон нийтийн боловсролын харилцааны талаарх хэлэлцүүлэгт оролцох нь зохистой байж болно.

Шүүгч асан

153. Дотоод тогтсон дэг жаягаас хамааран, шүүгчийн асаны хувьд, түүний холбогдох туршлагыг дурдсан мэдээлэл бүхий эвлэрүүлэн зуучлал, арбитрын үйлчилгээг санал болгосон зар сурталчилгаанд шүүгчийн дүрээр гарч болох юм. Гэхдээ нэгэнт шүүгчээр ажиллахаа больсон учраас түүний албан тушаалд “тэтгэвэртээ гарсан”, “асан” зэрэг үгийг хэрэглэж, тодотгох хэрэгтэй. Харин түүнд зохиулан өндөр дээд албан тушаалын илэрхийлэл болох “эрхэмсэг”, “хүндэт” гэх үгийг тухайн зар сурталчилгаанд хэрэглэж болохгүй.

4.10. Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нууц мэдээллийг шүүгчийн албан үүрэгтэй холбоогүй өөр бусад зорилгод ашиглахгүй, задруулахгүй байх ёстой.

ТАЙЛБАР

Нууц мэдээллийг хувьдаа ашиг олох зорилгоор болон бусдад ашиглуулж болохгүй

154. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа олон нийтэд нээлттэй болоогүй худалдааны мэдээлэл буюу бусад үнэ цэнтэй мэдээлэлтэй танилцдаг. Шүүгч нь тийм мэдээллийг хувьдаа ашиглаж болохгүй бөгөөд шүүн таслах ажиллагаатай холбоогүй ямар нэг зорилгоор задруулж болохгүй.

Хориглолтын мөн чанар

155. Энэхүү хориглолт нь задруулаагүй, ил болоогүй нотлох баримтыг зохисгүй ашиглахтай холбоотой. Тухайлбал, томоохон хэмжээний арилжааны маргааныг шийдвэрлэхэд хамаарах нууцалсан нотлох баримтыг задруулж болохгүй.

4.11. Шүүгч нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулж болно. Үүнд:

4.11.1. Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх болон холбогдох бусад асуудлаарх үйл ажиллагаанд оролцох, багшлах, лекц унших, бүтээл туурвих;

ТАЙЛБАР

Олон нийтийн боловсролд хувь нэмэр оруулах

156. Шүүгч нь өөрийн эрх хэмжээний хүрээнд болон түүнээс гадуур ч эрх зүй, эрх зүйн тогтолцоог сайжруулах, шударга ёсыг сахиулахад хувь нэмэр оруулах онцгой байр суурьтай. Ийм хувь нэмрийг ярих, бичих, багшлах буюу шүүхээс гадуурх бусад үйл ажиллагаанд оролцох байдлаар оруулж болно. Ийм үйл ажиллагаа нь шүүгчийн шүүн таслах ажлыг цалгардуулахгүй, ажлын цагт нөлөөлөхгүй бол түүнд оролцохыг эрмэлзэх хэрэгтэй.

Хууль зүйн боловсролд хувь нэмэр оруулах

157. Шүүгч нь лекц унших, хурал, семинарт оролцох, оюутны загвар шүүх хуралдааныг шүүх, дүгнэх зэргээр эрх зүйн болон мэргэжлийн боловсролд хувь нэмэр оруулж болно. Мөн зохиогч, редакторын хувиар эрх зүйн бүтээлд хувь нэмэр оруулж болно. Олон нийтийн ашиг сонирхлын төлөөх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг сайшаадаг. Гэхдээ хууль зүйн тодорхой асуудлаар дүгнэлт хэлэх, зөвлөгөө өгөх нь зохимжтой биш учраас, шүүгч нь сургалтын форум, хэлэлцүүлэг дээр түүний хийсэн тайлбар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой байр суурь илэрхийлэхгүй

гэдгийг ил тод мэдэгдэх шаардлагатай. Шүүгч нь гаргасан нотлох баримттай танилцаж, үндэслэлийг сонсож, бүрэн шинжилж дуусах хүртэл нотлох баримтыг үнэлэхгүй бөгөөд төвийг сахин шүүхийн дүгнэлтээ гаргана. Шүүгч нь хичээл заасны хөлс, мөнгөн урамшуулал авахдаа, шүүгчтэй адил хичээл заасан шүүгчээр ажилладаггүй өөр багшийн авах хөлс, урамшууллаас илүү хэмжээний хөлс авахгүй байхыг болон нэмэлт хөлс авахтай холбоотой Үндсэн хуулийн буюу хууль зүйн үүрэгт нь нийцэх эсэхийг хянан үзнэ.

4.11.2. Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх болон холбогдох бусад асуудлаарх төрийн байгууллагын нээлттэй хуралдаан, хэлэлцүүлэгт оролцох;

ТАЙЛБАР

Албан байгууллагад шүүгчийн хувиар очих

158. Шүүгч нь ерөнхийдөө шүүн таслах ажиллагааны туршлага нь тухайн нэг хянан үзэх асуудлаарх тусгай мэргэшил болно гэж ойлгогдож буй хэмжээнд албан байгууллагад очиж, нотлох баримт гаргаж болно.

Албан байгууллагад хувь иргэний хувиар очих

159. Шүүгч нь түүний хувийн амьдралд нөлөөлөх асуудлаар албан байгууллагад хувь иргэнийхээ хувиар нотлох баримт гаргах буюу хүсэлт гаргах боломжтой. Ийм хүсэлтэд, шүүгчийн үл хөдлөх хөрөнгөд нөлөөлөх бүсчлэлийн төлөвлөгөө, орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой санал багтана. Гэхдээ шүүгч нь иргэний хувиар гаргаж буй хүсэлт, саналдаа шүүхийн нэр хүндийг ашиглахгүй байх, тийнхүү ашиглуулахгүй байхад анхаарах хэрэгтэй.

4.11.3. Улс төрийн болон бусад асуудлаар төвийг сахисан байр суурьтай байх шүүгчийн ёс зүйд үл харшлах тохиолдолд төрийн байгууллага, засгийн газрын комисс, хорооны гишүүн байх, зөвлөх багт орж ажиллах;

ТАЙЛБАР

Судалгааны комиссын гишүүнчлэл

160. Шүүх олон нийтийн дунд нэр хүндтэй, шүүн таслах ажиллагааг дагнан эрхэлдэг тул, ихэвчлэн шүүгчийг шүүн таслах чиг үүргээс нь гадуур олон нийтэд чухал асуудлаар судалгаа хийх, тайлан гаргах ажилд урьдаг. Шүүгч энэхүү хүсэлтийг хянан үзэхдээ, тухайн даалгаврыг хүлээн авснаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд ямар үр дагавартай байж болохыг сайн бодох хэрэгтэй. Шүүгчийн оролцсон судалгааны комиссын тайлан хэвлэгдэж, нийтийн хүртээл болсны дараа, шүүгч нь олон нийтийн маргааны сэдэв болох, шүүмжлүүлэх, ичиж зовох тохиолдол олон гардаг. Мөн цаг хугацаа, эх үүсвэр зэрэг ажлын болон бусад нөхцөл нь шүүгчийн чиг үүрэгт нийцэх эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй. Үндэсний онц нөхцөл байдлын үеэр, үндэсний ач холбогдолтой асуудал үүсэхээс бусад тохиолдолд, шүүгч тэрхүү судалгааны комисст ажиллах үүрэггүй байдаг. Зарим улсад, Үндсэн хуульд заасан үндэслэлээр шүүгчийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын талаар судалгаа хийхийг хориглодог бөгөөд зөвшөөрсөн байсан ч, шүүгчийн томилгоотой холбоотой сэдэв, журмын асуудлаар судалгаа хийхэд оролцож болохгүй.⁵¹

⁵¹ *Wilson v Minister for Aboriginal Affairs*, High Court of Australia, (1997) 189 CLR 1.

161. Олон нийтийн буюу үндэсний эрх ашигт, олон нийтэд ноцтой нөлөөлөх асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд бүрэн, тодорхой үндэслэл гаргаж ирэх, судалгаа хийх шаардлага гардаг. Үүнийг нотлох баримт, гэрчийн мэдүүлгийг үнэлэх чадвар бүхий олон жилий туршлагатай шүүгч, практикийн хуульч хамгийн сайн хэрэгжүүлж чадна гэдэгтэй маргах зүйлгүй. Гэсэн хэдий ч, дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.

- 1) Шүүгчийн хууль ёсны чиг үүрэг нь шүүгч байх. Энэ чиг үүргийг маш цөөн хүн хэрэгжүүлдэг. Эдгээр хүмүүс нь мэргэжил, ур чадвартай олон хүний дундаас зөвхөн шүүн таслах ажлыг хэрэгжүүлэхээр томилогддог. Нөгөө талаар, шүүгчийг оролцуулахгүйгээр, комиссын гишүүнээр ажиллуулах мэдлэг чадвар, туршлага бүхий олон хүн бий;⁵²
- 2) Ерөнхийдөө судалгааны комиссын чиг үүрэг нь шүүхтэй бус, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай холбоотой хийгддэг. Комиссын чиг үүргийн нэг нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага зохих үйл ажиллагаа явуулсан эсэх талаарх мэдээллийг олж авах, хянан шалгах юм. Тухайн комиссын хяналт шалгалтад татагдсан хүмүүсийн хувьд, иргэний болон эрүүгийн хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татагдах нь бий. Өөрөөр хэлбэл, нисэх буудал, хурдны зам барих гэх мэт саналыг нягтлан шалгах, онгоц сүйрсэн хэргийг мөрдөн шалгах, тусгай бүлэгт шаардлагатай хууль, бодлогын шинэтгэл хийх эсэхийг судлах зэргээр комиссын хянан шалгах үйл ажиллагаа явагддаг. Гүйцэтгэх эрх мэдлийн бүх үйл ажиллагаатай адил, судалгааны комиссын хянан шалгах үйл ажиллагаа, дүгнэлт нь зохистой эсэхээс үл хамааран, олон нийтийн маргааны сэдэв болдог.

⁵² Sir Murray McInerney, "The Appointment of Judges to Commissions of Inquiry and Other Extra-Judicial Activities", (1978) *The Australian Law Journal*, vol. 52, pp. 540-553.

162. 1998 онд Канадын Шүүхийн зөвлөлөөс холбооны шүүгчдийг судалгааны комисст томилохтой холбоотой байр сууриа илэрхийлсэн байдаг.⁵³ Үүгээр дараах нөхцөлийг журамласан. Үүнд:

- 1) Шүүгчийг судалгааны комисст оруулах тухай хүсэлт бүрийг эхлээд ерөнхий шүүгчид гаргана;
- 2) Ерөнхий шүүгч нь хүсэлтэд дурдсан шүүгчтэй зөвлөлдөж, тухайн шүүгчийн шүүн таслах ажилд ноцтой нөлөөлөх асуудал гарах эсэхийг хянан үзнэ;
- 3) Ерөнхий шүүгч болон шүүгч нь тухайн судалгааны комисст томилохыг зөвшөөрснөөр, тухайн шүүх дэх шүүгчийн ирээдүйн ажилд нөлөөлөх эсэхийг хянан үзнэ. Энэ хүрээнд дараах нөхцөлийг хянан үзнэ.
 - i. Тухайн судалгааны сэдэв нь нийтийн бодлогын асуудлаар зөвлөхийг шаардах эсэх, ялангуяа улс төрийн мөн чанартай холбоотой асуудал байгаа эсэх;
 - ii. Засгийн газраас томилж буй агентлагуудын үйл ажиллагааг хянан шалгахад хамаатай асуудал уу?
 - iii. Судалгаа нь тухайн хувь хүмүүс гэмт хэрэг үйлдсэн, иргэний эрх зүйн зөрчил гаргасан эсэхийг мөрдөн шалгахтай хамаатай юу?
 - iv. Комиссын зөвлөх, гишүүдийг хэн сонгох?
 - v. Санал тавьсан шүүгчийн мэдлэг, туршлага тухайн судалгааг хийхэд зайлшгүй заавал шаардлагатай юу? Өөх бусад, тэтгэвэртээ гарсан, орон тооны бус шүүгч зэрэг байж болохгүй юу?
 - vi. Хэрэв тухайн судалгааны комисст хуулийн сургууль төгссөн гишүүн шаардлагатай бол, заавал шүүгч байх шаардлагатай юу? Тухайн чиг үүргийг мэргэшсэн хуульч адилхан хэрэгжүүлж болохгүй юу?

⁵³ *Position of the Canadian Judicial Council on the Appointment of Federally-Appointed Judges to Commissions of Inquiry*, approved at its March 1998 meeting, www.cjc-ccm.gc.ca

Онцгой нөхцөл байдал үгүй бол, ерөнхий шүүгч болон тухайн шүүгч дээрх бүх нөхцөлийг хянан үзэж, тухайн саналыг хүлээн авах нь шүүхийн ажилд төдийгүй цаашдын шүүн таслах ажлыг ноцтой сулруулахгүй гэж үзэх хүртэл, шүүгч нь түүнийг судалгааны комиссын гишүүнээр томилох саналыг хүлээн авч болохгүй гэж Канадын Шүүхийн зөвлөлөөс байр сууриа илэрхийлсэн байна.

163. Ерөнхийдөө, хуульд заасны дагуу шүүгчийг комиссын гишүүнээр ажиллуулах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд, засгийн газрын хороо, комисс болон хууль, эрх зүйн тогтолцоо, шүүх засаглалыг сайжруулахаас бусад асуудлаарх бодлого, үйл ажиллагааны албан тушаалд шүүгчийг томилох саналыг хүлээн авахдаа шүүгч болгоомжтой байх хэрэгтэй. Хэрэв засгийн газар дахь шүүгчийн оролцоо нь шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх буюу шүүхийн шударга, төвийг сахисан, бие даасан байдалд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулах хандлагатай бол, шүүгч нь ямар ч тохиолдолд тухайн саналыг хүлээн авах ёсгүй. Түүнчлэн, шүүгч үндсэн буюу өдөр тутмын үүргээсээ урт хугацаанд холдвол, эргээд хэвийн байдалдаа орох, шүүхийн ажилдаа дасан зохицоход хялбар байдаггүй.

Засгийн газрын үйл ажиллагаанд оролцох

164. Шүүгчээр ажиллаж байх хугацаандаа шүүгч нь гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд оролцож болохгүй. Гэхдээ, тухайн тогтолцоо зөвшөөрдөг бол, шүүгч нь шүүх дэх ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа Хууль зүйн яамны иргэний буюу эрүүгийн хэргийн хууль тогтоомжийн хэлтэс гэх мэт яамны захиргааны хэлтэст ажил эрхэлж болно. Харин шүүгч нь сайдын ажлын албаны ажилтан болох нь илүү ярвигтай асуудал. Нийтлэг эрх зүйн системтэй улсад шүүгч байсан хүнийг томилоход зохимжгүй

гэж үздэг албан тушаал нь иргэнлэг эрх зүйн системтэй улсаас өөр байдаг. Иргэнлэг эрх зүйн системтэй улсад шүүгч нь сайдын ажлын албанд орж ажиллахын өмнө, шүүгчийг томилох үүрэг хариуцлага бүхий байгууллагаас болон тухайн харьяалал бүхий шүүхийн хамтран ажиллагсаас дүгнэлт гаргуулах шаардлагатай байдаг. Энэ дүрэм нь хувь хүн тус бүрт хэрэглэгдэнэ. Шүүгч нь шүүхийн байгууллагад буцаж ажиллахдаа өмнө нь гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагад хашиж байсан бүх ажил албан тушаалаа хүлээлгэж өгсөн байх хэрэгтэй.

Төрийг төлөөлөх

165. Шүүгч нь өөрийн төрийг ёслолын үйл ажиллагаа болон үндэстний, бүс нутгийн, түүхийн, боловсролын, соёлын үйл ажиллагаатай холбоотой харилцаанд төлөөлж болно.

4.11.4. Шүүхийн нэр хүндэд харшлахгүй, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд саад тотгор болохгүй нөхцөлд өөр бусад үйл ажиллагаанд оролцож болно.

ТАЙЛБАР

Шүүхээс гадуурх үйл ажиллагаанд оролцох

166. Шүүгч нь шүүхээс гадуурх, нийгмээс тусгаарлахгүй зохих үйл ажиллагаанд оролцож болно. Тиймээс, шүүгч нь хуулийн бус сэдвээр бичих, лекц унших, багшлах, ярих, урлаг, спортын болон бусад нийгэм, амралтын үйл ажиллагаанд оролцож болно. Гэхдээ эдгээр үйл ажиллагаа нь шүүгчийн албаны нэр хүндийг унагах зэрэг шүүгчийн шүүн таслах ажилд нөлөөлөхгүй байх ёстой. Чухамдаа, өөр талбарт ажиллах нь шүүгч өөрийн мэдлэгийн хүрээгээ өргөжүүлэх, хууль зүйн мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд олж авсан мэдлэгээ тэлж, нийгэм дэх асуудлыг ойлгох бололцоо олгодог. Гэхдээ, шүүгч нийгэмтэй ойр байх болон албан үүргээ хараат бусаар, төвийг сахин хэрэгжүүлэх, тийнхүү харагдах үүргийн хооронд бодит тэнцвэрийг тогтоох хэрэгтэй. Эцсийн дүндээ, шүүгчийн нийгмийн идэвхтэй амьдрал нь нийгмийн тодорхой орчинд, ухаалаг ажиглагчийн нүдэнд шүүгчийн хараат бус, төвийг сахисан байдал, тийнхүү харагдах нөхцөлд бодит эрсдэл гаргах эсэх асуулт үргэлж тавигддаг.

Ашгийн бус байгууллага дахь гишүүнчлэл

167. Шүүгч нь олон төрлийн ашгийн бус байгууллага, түүний удирдах байгууллагад гишүүн болж болно. Ийм байгууллагад буяны байгууллагууд, их сургууль, ахлах сургуулийн зөвлөл, шашны байгууллагууд, эмнэлгийн зөвлөлүүд, нийгмийн клубууд, спортын байгууллагууд болон соёл, урлагийн ашиг

сонирхлыг дэмждэг байгууллагууд орно. Гэхдээ шүүгч эдгээр байгууллагад гишүүнээр элсэхээр бол дараах зүйлийг санаж байх хэрэгтэй. Үүнд:

- 1) Шүүгчийг олон нийтийн маргаанд татан оролцуулах буюу улс төрийн зорилготой, шүүхийн маргаанд байнга, тогтмол татагддаг байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь зохисгүй;
- 2) Шүүгчийн хувьд, тухайн байгууллагад ихэнх цагаа зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой;
- 3) Шүүгч нь хуулийн зөвлөхөөр ажиллах ёсгүй. Энэ нь хууль зүйн үр дагавартай асуудалд, шүүгч зөвхөн тухайн байгууллагын гишүүний хувиар санаа бодлоо илэрхийлэхийг хязгаарлахгүй. Гэхдээ тэрхүү санаа бодлыг нь хууль зүйн зөвлөгөө гэж үзэж болохгүй гэдгийг тодорхой хэлэх ёстой;
- 4) Шүүгч нь хөрөнгө босгох, сан арвижуулах үйл ажиллагаанд оролцох, нэрээ ашиглуулахдаа болгоомжтой байх хэрэгтэй;
- 5) Шүүгч нь дарамт шахалт үзүүлдэг буюу голчлон хөрөнгө босгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэж ойлгогдох байгууллагад гишүүнээр элсэж болохгүй.

168. Шүүгч нь арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, бусад байдлаар ялгаварлан гадуурхаж, хүний суурь эрхийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг аливаа байгууллагад гишүүнчлэлтэй байж болохгүй. Байгууллагыг ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тогтоох нь нарийн түвэгтэй асуудал юм. Ерөнхийдөө, арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, үндэс угсаа, угсаатны байдал, бэлгийн чиг баримжаагаар нь хувь хүнийг дур зоргоороо гишүүнчлэлээс хасдаг, авдаг бол ялгаварлан гадуурхдаг байгууллага гэж ойлгоно. Гэхдээ, шүүгч нь шашин, угсаатан, хууль ёсны соёлын үнэт зүйлийг хадгалах

зориулалттай, гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхлыг хангах байгууллагад гишүүн болж болно. Үүнтэй адилаар, ялгаварлан гадуурхах үйл ажиллагаатай гэдгийг нь мэдэж буй клубын уулзалтад шүүгч оролцох ёсгүй төдийгүй тийм үйл ажиллагааг тогтмол, байнга зохион байгуулахад оролцох ёсгүй.

Санхүүгийн үйл ажиллагааны хязгаарлалт

169. Шүүгчийн албан үүргийг зохих ёсоор хэрэгжүүлэхтэй холбоотой хязгаарлалт үйлчлэхээс бусад тохиолдолд, шүүгч нь өөрийн хувийн санхүүгийн асуудалд энгийн иргэний адил эрхтэй. Шүүгч нь үл хөдлөх хөрөнгө зэрэгт хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтыг удирдах, бусад санхүүгийн үр ашигтай үйл ажиллагаанд оролцох боломжтой. Гэхдээ шүүгчийн гэр бүлийн гишүүний эрхэлдэг, хянадаг бизнесээс бусад бизнесийн хувьд, мэргэжилтэн, захирал, идэвхтэй түнш, менежер, зөвлөх, ажилтан байж болохгүй. Шүүгчийг гэр бүлийнх нь эрхэлдэг бизнест оролцохыг ерөнхийдөө зөвшөөрдөг ч, тэрхүү бизнест хэт их цаг зарцуулах, бизнес нь шүүхийн нэр хүндийг буруугаар ашиглахтай холбоотой, шүүхийн өмнө дуудагдах магадлалтай байвал, шүүгч тийнхүү оролцохоос зайсхийх ёстой. Шүүгч нь арилжааны аж ахуйн нэгжийн захирлуудын зөвлөлд үйлчлэх, өөрөөр хэлбэл, ашиг олох зорилготой компанид үйлчлэх нь зохисгүй. Энэ нь нийтийн болон хувийн компанийн хувьд нэгэн адил хамаатай бөгөөд шүүгч гүйцэтгэх, гүйцэтгэх бус чиг үүрэгтэй эсэх, цалин хөлс авдаг эсэхээс үл хамаарна.

Оршин суугчдын холбооны гишүүнчлэл

170. Хэрэв шүүгч өмчлөгчдийн буюу оршин суугчдын холбоо бүхий барилгад байр өмчилдөг, эзэмшдэг бол, тэрхүү холбооны удирдлагын хороонд үйлчилж болох ч, хуулийн зөвлөгөө өгч болохгүй. Гэхдээ хууль зүйн үр дагавартай

асуудлаар, зөвхөн гишүүнийхээ хувиар санаа бодлоо илэрхийлж болно. Ингэхдээ, түүний санаа бодлыг хууль зүйн зөвлөгөө гэж үзэж болохгүй гэдгийг тодорхой хэлэх хэрэгтэй. Тухайн байгууллагад ямар нэгэн хууль зүйн зөвлөгөө шаардлагатай бол мэргэжлийн хүнээс зөвлөгөө авахыг зөвлөх хэрэгтэй. Хэрэв санаа зовох асуудал гарч ирсэн буюу маргаантай асуудал үүсэхээр бол, шүүгч нь тэрхүү маргаантай асуудлаар санаа бодлоо илэрхийлэхгүй байх нь зүйтэй. Ийм санаа бодол нь шүүгч болон шүүхийг эвгүй байдалд оруулдаг.

Батлан даагчийн үүрэг гүйцэтгэх

171. Нөхцөл байдлаас хамаарч шүүгч цалин урамшуулал авахгүйгээр шүүн таслах ажлаа зохих ёсоор гүйцэтгэхэд нь нөлөөлөхгүй бол үл хөдлөх хөрөнгийн гэрээслэл биелүүлэгч, хөрөнгө удирдсан этгээд, итгэмжлэгдсэн өмчлөгч, асран хамгаалагч, бусад батлан даагчийн үүрэг гүйцэтгэх буюу гэр бүлийн гишүүн, ойрын найзын итгэмжит хүн байж болно. Шүүгчид тавигдах санхүүгийн үйл ажиллагааны хязгаарлалт нь батлан даагчийн үүрэг гүйцэтгэж буй шүүгчид нэгэн адил хамаарна.

4.12. Шүүгч нь шүүгчээр ажиллаж байх хугацаандаа хуулийн практик үйл ажиллагаа буюу бусдын хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж болохгүй.

ТАЙЛБАР

“Хуулийн практик үйл ажиллагаа”-ны агуулга

172. Хуулийн практик үйл ажиллагаанд шүүхээс гадуур хийсэн буюу шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбоогүй үйл ажиллагаа багтана. Үүнд хууль зүйн бичиг баримт бэлтгэх, өргөн хүрээний асуудлаар хууль зүйн зөвлөгөө өгөх, бизнесийн буюу итгэлийн харилцаа бүхий өргөн цар хүрээтэй салбарын эрх зүйн дүрэм, журам, баримт бичиг бэлтгэх, хэрэгжүүлэх болон бусад ажил хэрэг хамаарна. Шүүгчийн хувьд амралтынхаа турш, бүтэн цагаар засгийн газрын салбар байгууллагад шүүх, шүүх эрх мэдэлтэй холбоотой асуудлаар тусгай зөвлөхийн ажил хийх нь “хуулийн практик үйл ажиллагаа”-нд тооцогдож болно. Хориглолтын хүрээ хязгаарын талаарх үзэл бодлоос хамааран ялгаатай уламжлал байдаг. Иргэнлэг эрх зүйн системтэй зарим улсад, хяналтын шатны шүүхэд ажиллаж буй шүүгчийг арбитрч, эвлэрүүлэн зуучлагчийн ажил хийхийг зөвшөөрдөг. Нийтлэг эрх зүйн системтэй улсад, шүүгчийг тэтгэвэртээ гарсны дараа гадаадын болон засгийн газраас байгуулсан байгууллага дахь олон улсын арбитрч зэрэг цалин хөлстэй ажил хийхийг зөвшөөрдөг.

Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах

173. Ерөнхийдөө, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд, нийтлэг эрх зүйн тогтолцоотой улсад, шүүгч хувиараа арбитрч, эвлэрүүлэн зуучлагч буюу шүүн таслах үйл

ажиллагаатай холбоогүй бусад ажил хийж болохгүй. Шүүхийн үйл ажиллагаанаас гадуур орлого олох зорилгоор, маргаан шийдвэрлэх хувийн үйлчилгээ үзүүлэх байдлаар шүүхийн албыг санхүүгийн зорилгод ашиглах нь шүүхийн шударга байдалд үл итгэхэд хүргэдэг. Үнэ төлбөргүйгээр хийсэн байсан ч, ийм үйлчилгээ нь шүүн таслах ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг.

Гэр бүлийн гишүүдэд хууль зүйн зөвлөгөө өгөх

174. Шүүгч нь хууль зүйн зөвлөгөө өгөх ёсгүй. Гэхдээ гэр бүлийн гишүүн, ойрын найз нөхдөдөө нөхөрсөг, албан бус, үнэ төлбөргүй хувийн зөвлөгөө, санал гаргаж болох бөгөөд хууль зүйн зөвлөгөө өгөх ёсгүй гэдгээ тодорхой ойлгуулна. Хэрэв шаардлагатай бол, хууль зүйн зөвлөгөөг мэргэжлийн хүнээс авахын санал болгоно.

Шүүгч өөрийн ашиг сонирхлыг хамгаалах

175. Шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах зэргээр шүүгч нь өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах эрхтэй. Гэхдээ шүүгч нь өөрийн гаргасан нэхэмжлэл, гомдлыг шийдэх хуралдаанд оролцохгүй байх талаар анхаарах хэрэгтэй. Нэхэмжлэгч, гомдол гаргагчийн хувиар оролцох нь, шүүгч албаны давуу байдлаа ашиглаж байна гэх сэтгэгдэл төрүүлэх эрсдэлтэй байдаг. Мөн шүүгчийн итгэл үнэмшилд шүүхийн хамт ажиллагсдынх нь дүгнэлт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг.

4.13. Шүүгч нь шүүгчдийн холбоо байгуулах, түүнд гишүүнээр элсэх, шүүгчийн эрх ашгийг хамгаалах бусад байгууллагад нэгдэх эрхтэй.

ТАЙЛБАР

Үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл

176. Шүүгч нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхдээ шүүгчдийн хөдөлмөрийн болон цалин хөлсний нөхцөлийг дэмжих, хамгаалах зорилгоор байгуулагдсан үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоонд нэгдэх буюу тийм үйлдвэрчний эвлэл, холбоо байгуулж болно. Гэхдээ шүүгч олон нийтэд үйлчлэх болон Үндсэн хуульд заасны дагуу ажил хаялтад оролцох эрхээ хязгаарлуулж болно.

4.14. Шүүгч нь өөрөө болон түүний гэр бүлийн гишүүнээр дамжуулан шүүн таслах ажилтай холбоотойгоор аливаа нэг үйлдэл хийсний төлөө буюу хийхийн төлөө, эсхүл хийхгүй байхын төлөө бэлэг, шан харамж, зээл авах, давуу байдал олгохыг хүсэх, түүнчлэн хүлээн авахыг хориглоно.

4.15. Шүүгч нь түүний хамааралд байдаг, түүний чиг үүрэг, эрх мэдлийн хүрээнд хамаарах бусад хүмүүст болон шүүхийн ажилтнуудад шүүн таслах ажиллагаатай холбоотойгоор аливаа нэг үйлдэл хийсний төлөө, хийхээр зорьсон, эсхүл хийгээгүйн төлөө бэлэг, шан харамж, зээл авах, давуу байдал олгохыг хүсэх, түүнчлэн хүлээн авахыг мэдсээр байж зөвшөөрч болохгүй.

ТАЙЛБАР

Гэр бүлийн гишүүн, шүүхийн ажилтанд ёс зүйн хязгаарлалтын талаар мэдээлэх үүрэг

177. Шүүгчийн гэр бүлийн гишүүн, шүүгчийн гэрт хамт амьдардаг бусад хүнд бэлэг, өв хөрөнгө, зээл өгөх, хөнгөлөлт үзүүлэх буюу тийн харагдах нь шүүгчид нөлөөлөх зорилготой байдаг. Энэ утгаараа, үүнтэй холбоотой шүүгчид тавигддаг ёс зүйн хязгаарлалтын талаар шүүгч нь гэр бүлийн гишүүддээ мэдээлж, тэрхүү хязгаарлалтыг зөрчиж, урам хугалахгүй байхад анхаарна. Гэхдээ шүүгч нь түүнтэй хамт нэг гэрт байгаа гэр бүлийн бүх гишүүний санхүүгийн буюу бизнесийн бүх үйл ажиллагааг мэдэж, бүрэн хянаж чадахгүй.

178. Дээр дурдсан нөхцөл нь шүүхийн ажилтан буюу шүүгчийн нөлөөнд байдаг, түүний чиг үүрэг, эрх мэдлийн хүрээнд хамаарах хүмүүст нэгэн адил хамаарна.

Зөвшөөрөгдсөн зүйл

179. Дараах зүйлийг хориглодоггүй. Үүнд:

- 1) Ерөнхийдөө шүүгчийн эргэн тойрон дахь, ажил хэргийн зорилгогүй нийтлэг зочломтгой байдал болон хоол, зууш гэх мэт бага хэмжээгээр хэрэглэгдэх зүйлс;
- 2) Гоёл чимэглэл, ширээний зориулалттай гэрчилгээ, цом, мэндчилгээний хуудас зэрэг зөвхөн танилцуулгын зорилготой багахан үнэ цэн бүхий эд зүйлс;
- 3) Банк болон бусад санхүүгийн байгууллагаас шүүгчийн статустай нь холбоогүйгээр, ерөнхий журамд заасны дагуу ердийн нөхцөлөөр олгосон зээл;
- 4) Шүүгчийн статустай нь хамааралгүй, ерөнхий журамд заасны дагуу олгосон таатай хувь хэмжээ, арилжааны хямдрал зэрэг боломж, ашиг тус;
- 5) Шүүгчийн статустай нь хамааралгүй, ерөнхий журамд заасны дагуу зургийн уралдаан зэрэг олон нийтэд нээлттэй тэмцээн, бусад үйл явдалд бусдын адил оролцож, өрсөлсөнийнх хувиар нь өгч буй шагнал;
- 6) Шүүгч эсэхээс нь үл хамааран, хэн бүхэнд адил шалгуур тавьж, адил нөхцөлтэйгөөр олгосон тэтгэлэг;
- 7) Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүх эрх мэдлийг сайжруулахтай холбоотой чиг үүрэг буюу үйл ажиллагаанд шүүгч оролцохтой холбоотой аяллын зардал буюу шүүгч, түүний хамаатны тээвэр, орон байр, хоол ундны зардал зэрэг зардлын нөхөн олговор буюу буцаан олголт;
- 8) Шүүхээс гадуурх хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны бодит төлбөр.

Олон нийтийн зочломтгой байдал

180. Заримдаа, “ердийн зочломтгой байдал” болон шүүгчид таатай сэтгэгдэл төрүүлэх гэсэн зохисгүй оролдлогын хоорон зааг ялгааг гаргахад хүнд байдаг. Ихэвчлэн шүүгч тухайн үйл ажиллагаанд оролцох, оролцохгүй байх нь зохистой эсэхийг тодорхойлох нийтлэг нэг хүчин зүйл байхгүй бөгөөд тухайн нөхцөл байдал чухал байдаг. Зочломтгой байдлыг хүлээн авах эсэхийг шийдэхийн тулд шүүгч өөрөөсөө дараах асуултыг асуух хэрэгтэй. Энэ нь, шүүгчийн хараат бус, шударга байх, хууль дээдлэх, шүүн таслах үүргээ төвийг сахин, нэр төртэйгөөр, цаг хугацаанд нь шийдвэрлэхэд тэрхүү зочломтгой байдал сөргөөр нөлөөлөх буюу эдгээрийн аль нэгийг зөрчиж буй мэт харагдах уу? гэх асуулт юм. Мөн өөр олон асуултад хариулах хэрэгтэй болдог. Тодруулбал, харилцаа тогтоохоор санаачилж буй хүн нь хуучны найз уу, эсхүл саяхан танилцсан хүн үү? Тухайн хүн нийгэмд таагүй нэр хүндтэй юу? Нийтийг хамарсан цугларалт уу, хязгаарлагдмал хүрээний цугларалт уу? Энэ нь аяндаа болж байгаа юу, зохион байгуулалттай юу? Шүүгчийн шийдвэрлэх гэж байгаа хэрэгтэй холбоотой хэн нэгэн оролцох уу? Бусдад энэ нь шүүгч ашиг хүртэж байгаа мэтээр хардах, шүүмжлэх нөхцөл болох уу? зэрэг асуултыг өөрөө өөрөөсөө асууж, хариулт авах хэрэгтэй.

4.16. Шүүгч нь тодорхой арга хэмжээнд нийцүүлэн өгч байгаа жижиг бэлэг, шагнал, урамшуулал нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх зорилготой байсан гэх ойлголт төрүүлэхээргүй, түүнчлэн аль нэг талд үйлчилсэн гэх байдал бий болгоогүй тохиолдолд жижиг бэлэг, шагнал, урамшууллыг хуульд заасан тохиолдолд хүлээн авч, хуулиар тогтоосон журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

ТАЙЛБАР

Хэт үнэтэй бэлэг авч болохгүй

181. Шүүгчид буюу түүний гэрт байнга хамт амьдардаг гэр бүлийн гишүүнд хэт үнэтэй бэлэг өгөх нь шүүгчийн төвийг сахих байдал, шүүхийн албаны үнэнч шударга байдалд асуудал үүсгэж, шүүгчээс татгалзах нөхцөл болдог. Тиймээс ийм төрлийн бэлэг авч болохгүй. Шүүгч нь ийм бэлэг буюу бэлэг өгөх саналаас эелдгээр татгалзах ёстой. Заримдаа ийм бэлэг өгөх санал талархал илэрхийлэх дүрэм, дэг жаяггүйгээр өөрөө аяндаа ирдэг. Хуулиар оноосон үүргийн дагуу шүүгч гэрлэлт, иргэний харьяаллын ёслолын ажиллагаа гүйцэтгэсний дараа эрүүл мэндийн үнэгүй үйлчилгээ санал болговол, шүүгч нь албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбоотой хөлс, үйлчилгээ авч болохгүй нөхцөлийг тайлбарлаж татгалзах ёстой. Харин, нэг шил виски юм уу, шүүгчийн дуртай хөгжмийн бичлэгтэй ганц хоёр компакт диск дурсгавал энэ нь зөрчилд тооцогдохгүй байж болох юм.

Тохирсон хэмжээний төлбөр, урамшуулал авах

182. Шүүгчийн мэргэжлийн үйлчилгээ, илтгэл тавьсны төлбөр, урамшуулал нь түүний гүйцэтгэсэн ажилтай нь дүйцэхүйц буюу тохирсон хэмжээтэй бол тэрхүү төлбөр, урамшууллыг авахыг хориглохгүй. Шүүгчийн гүйцэтгэсэн үйл ажиллагаа шүүн таслах ажилтай зөрчилдөөн үүсгэхгүй байх нөхцөлийг хангах ёстой. Шүүгч нь хувийн байдлаа дээшлүүлэхээр шүүгчийн албан тушаалыг ашиглаж буй мэт харагдах ёсгүй бөгөөд шүүн таслах ажлынхаа дийлэнх цаг хугацааг төлбөр, урамшуулалтай илтгэл тавих, яриа өгөх, бичгийн ажил хийхэд зарцуулж болохгүй. Түүнчлэн, төлбөр, урамшууллын эх үүсвэр нь шүүгч төвийг сахин хэрэг маргааныг шийдвэрлэхэд зохисгүй нөлөөлөхүйц байх ёсгүй.

ҮНЭТ ЗҮЙЛ 5: ТЭГШ БАЙДАЛ

Зарчим:

Шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх нөхцөлийг хангах нь шүүхийн зохистой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.

ТАЙЛБАР

Олон улсын стандартууд

183. Шүүгч нь нийгэм дэх эмзэг бүлгийг ялгаварлан гадуурхахыг хориглосон олон улсын болон бүс нутгийн баримт бичгүүдтэй танилцсан байх ёстой. Үүнд, “Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай” олон улсын конвенц (1965), “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” олон улсын конвенц (1979), “Шашин шүтлэг, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхах, үл хүлцэх бүх хэлбэрийг устгах тухай” тунхаглал (1981), “Үндэстэн, угсаатан, шашин шүтлэг, хэлний цөөнхөд багтах хүмүүсийн эрхийн тухай” тунхаглал (1992) хамаарна. Шүүгч нь “хүн бүр шүүхийн өмнө тэгш эрхтэй” болохыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дугаар зүйлд баталгаажуулсныг хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүн бүр арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, бусад байдлаас үл хамааран шударгаар шүүлгэх эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн гэж ойлгоно. Энд дурдсан “бусад байдлаас үл хамааран” гэдгийг тайлбарлахдаа, бэлгийн чиг хандлага, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл, БЗХӨ-өөс үл

хамааран шүүхийн өмнө тэгш эрхтэй гэж үзнэ. Тиймээс шүүгч нь албан үүргээ гүйцэтгэхдээ, аливаа алдаа гаргах, ялгаварлан гадуурхахаас зайлсхийх, шүүх хуралдаан болгонд талуудын тэгш эрхийг хангах, тэнцвэржүүлэх замаар талуудын тэгш эрхийн зарчмыг хүндэтгэх үүрэгтэй.

Шүүгч нийгэмд хэвшсэн ойлголтоос зайлсхийх ёстой

184. Шударга, тэгш хандах нь урт хугацааны турш шүүхийн чухал шинж чанар гэж тооцогдсоор ирсэн. Хуулийн дагуу, тэгш байдал нь зөвхөн шүүхийн үндэс суурь байгаад зогсохгүй, шүүх төвийг сахих байдалтай нягт холбоотой шүүхийн үйл ажиллагааны онцгой шинж чанар юм. Тухайлбал, зөв үр дүнд хүрдэг ч, шүүгчийн төвийг сахих байдалд маш их хөрөнгө хугацаа шаарддаг гэсэн нийгэмд хэвшсэн ойлголт байдаг. Шүүгч нь хэвшсэн ойлголт, цуу яриа, хардлагаас үүдэлтэй байр суурь, хандлагын нөлөөнд автах ёсгүй. Иймд шүүгч тэрхүү байр суурь, хандлагыг хүлээн зөвшөөрүүлэхгүй байх, залруулах талаар бүхий л хүчин чармайлт гаргах ёстой.

Хүйсээр ялгаварлан гадуурхах

185. Шүүгч нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс шүүхийн өмнө тэгш байх нөхцөлийг хангахад голлох үүрэгтэй оролцдог. Энэ үүргээ шүүгч өөрөө хэргийн бусад оролцогчид, хуульчид, шүүхийн ажилтнуудтай харилцахад төдийгүй, шүүхийн ажилтнууд, хуульчдын зүгээс бусад хүнтэй харилцахад хэрэгжүүлэхийг шаардах ёстой. Хэдийгээр шүүгчдийн зүгээс хуульчдыг хүйсээр ялгаварлах тохиолдол өнөөгийн шүүхэд бараг гардаггүй ч, эмэгтэй хуульчид руу чиглэсэн үг хэллэг ашиглах (“хөөрхөн өө”, “хонгор минь”, “бяцхан охин”, “бяцхан бүсгүй” гэх мэт), тэдний гадаад байдал, хувцаслалтын талаар сэтгэгдлээ илэрхийлэх зэргээр хэл яриа, дохио зангаа, зан үйл нь бэлгийн дарамт гэж үзэх нөхцөл болж болно. Шүүгчийн

зүгээс хуульч эмэгтэйд энэрэнгүйгээр хандах (“энэ гомдлыг эмэгтэй хүн л бэлдсэн болов уу”) нь заримдаа тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг багасгах, өөртөө итгэх итгэл, ур чадварын төвшинг бууруулах байдлаар, эмэгтэй хуульчийнх нь үр нөлөөг сулруулдаг талтай. Мөн хэргийн оролцогч бусад эмэгтэйн мэдрэмжгүй харьцаа (“энэ тэнэг хүүхэн”) нь бусдын хууль ёсны эрхэд бодитоор болон харагдах байдлын хувьд шууд нөлөөлж болдог. Шүүхийн ажилтан, өмгөөлөгч, хэргийн оролцогч, хамт ажиллагсдын бэлгийн дарамт нь ихэвчлэн хууль бус бөгөөд ёс зүйгүй харагдуулдаг.

5.1. Шүүгч нь арьс өнгө, нас хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, бэлгийн хандлага, нийгэм, эдийн засгийн байдал болон өөр бусад байдлаас үүссэн нийгмийн олон талт байдал, ялгааг мэддэг, ойлгодог байвал зохино.

ТАЙЛБАР

Соёл иргэншлийн олон янз байдалд хариуцлагатай байх үүрэг

186. Шүүгч нь нийгэм дэх соёл, арьсны өнгө, шашны олон янз байдлыг хүлээн зөвшөөрөхөөс гадна, мэддэг байх үүрэгтэй бөгөөд, ямар нэг хамааралгүй үндэслэлээр алагчлах, гадуурхахаас ангид байна. Шүүгч нь нийгэм дэх өөрчлөгдөж буй хандлага, үнэт зүйлийн талаар зохих мэдээлэлтэй байхыг эрмэлзэх бөгөөд, шүүгч төвийг сахих, тийнхүү харагдахад нь туслахуйц тохирох боловсролтой байхыг эрмэлзэнэ. Үүнээс гадна шүүгч төвийг сахидаг гэх ойлголтыг алдагдуулахгүйн тулд тийм хүчин чармайлтаа нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

5.2. Шүүгч нь шүүн таслах ажиллагаанд оролцохдоо хэрэгт үл хамаарах үндэслэлээр хэн нэг хүн, хэсэг бүлэг хүмүүст үг хэл, үйл хөдлөлөөрөө шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдлыг гаргаж болохгүй.

ТАЙЛБАР

Доромжлох, гутаах хэлбэрийн тайлбар гаргахаас сэргийлэх үүрэг

187. Шүүгч нь түүний хараат бус байдалд итгэх ухаалаг ажиглагчийн итгэлийг алдахгүй байхаар биеэ авч явахыг эрмэлзэнэ. Шүүгч нь мэдрэмжгүй, үл хүндэтгэсэн байдалтай харагдах сэтгэгдэл, илэрхийлэл, дохио зангаа, ааш авир гаргахаас зайлсхийнэ. Тухайлбал, хамааралгүй буюу үл хүндэтгэсэн байдалтай сэтгэгдэл нь, шүүхийн өмнө ирсэн хэн нэгэнд тэгш бус хандах, үл хүндлэх агуулга бүхий арьс өнгө, соёл, бэлгийн болон бусад хэвшмэл ойлголтод суурилсан байдаг. Мөн угсаатны гарал үүслийн талаарх шүүгчийн дорд үзсэн тайлбар нь мунхаг, бүдүүлэг байдаг. Шүүгч нь түүний хэлсэн үг арьс өнгөөр ялгаварласан өнгө аясгүй байх, нийгэм дэх цөөнхийн бүлгийг санамсаргүйгээр ч гомдоохгүй байхын тулд онцгой анхаарал болгоомжтой байх ёстой.

Шүүгч үг, хэллэгийг болгоомжтой хэрэглэж, эелдэг байх ёстой

188. Шүүгч нь нэхэмжлэгч, өмгөөлөгч, хэргийн талууд, гэрчүүдийн тухай зохисгүй буюу доромжилсон үг хэлж болохгүй. Заримдаа ийм үгийг шүүгчийн зүгээс гэмт хэрэгт буруутгагдсан хүнд ял шийтгэл оногдуулахдаа, цагдан хорихдоо гаргадаг. Дотоодын дэг жаягаас үл хамааран, ноцтой гэмт хэрэгтэнд олон нийтийн хилэгнэлийг зохих ёсоор

илэрхийлэхдээ, шүүгч нь үг хэллэгээ үргэлж болгоомжтой хэрэглэж, аль болохоор эелдэг байх ёстой. Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах нь олон нийтийн өмнөөс хэрэгжүүлж буй хууль зүйн хүнд үүрэг хариуцлага юм. Үүнд шүүгч хувийн сэтгэл хөдлөлөөр хандаж болохгүй. Хэрэв тэгвэл, шүүн таслах ажиллагааны онцгой шинж чанарыг алдагдуулах эрсдэлтэй.

5.3. Шүүгч нь шүүн таслах ажиллагаанд оролцохдоо шүүгч, хэргийн оролцогч тал, гэрч, хуульч, шүүхийн ажилтнууд болон шүүхийн бусад этгээдтэй зохистой харьцаж, хэрэгт хамааралгүй, шүүн таслах ажиллагаанд ач холбогдолгүй үндэслэлээр ялгаварлах байдал гаргаж болохгүй.

ТАЙЛБАР

Шүүх дэх хүмүүстэй нэр төртэйгөөр харьцах ёстой

189. Шүүгч нь шүүхийн байранд шударгаар шүүх ая тухтай орчинг бүрдүүлнэ. Шүүхийн байранд хүмүүст тэгш бусаар, ялгаатай харьцах буюу тийнхүү ойлгогдох харьцааг хүлээн зөвшөөрч болохгүй. Хуульч, өмгөөлөгч, хэргийн оролцогч, гэрч зэрэг шүүх дэх бүх хүний хувьд нэр төр, үндсэн эрхийг нь хүндэтгэн харьцахыг шаардах эрхтэй. Шүүгч нь шүүх байранд байгаа бүх хүнийг арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, бусад хамааралгүй нөхцөлөөр ялгаварлан гадуурхахаас хамгаална.

5.4. Шүүгч нь түүний хамааралд байдаг, түүний чиг үүрэг, хяналтад хамаарах шүүхийн ажилтнууд болон өөр бусад хүний зүгээс, түүний хянан шийдвэрлэж буй хэргийн оролцогч талуудыг хэрэгт хамааралгүй үндэслэлээр ялгаварлах байдал гаргахыг мэдсээр байж зөвшөөрч болохгүй.

ТАЙЛБАР

Тогтсон стандартыг шүүхийн ажилтнаар дагаж мөрдүүлэх үүрэг

190. Олон нийтийн зүгээс шүүхийн тогтолцоотой ихэвчлэн шүүхийн ажилтнаар дамжин анхлан харилцдаг. Иймд шүүгчийн зүгээс дээр дурдсан зан байдлын стандартыг түүний удирдлага, хяналтад байдаг шүүхийн ажилтан бүрэн хэмжээнд мөрдөх нөхцөлийг хангаж ажиллах нь маш чухал юм. Тодруулбал, шүүхийн ажилтан нь зэмлэлд хүлээцтэй хандах, ялангуяа хүйсээр гадуурхсан мэдрэмжгүй хэл ярианаас зайлсхийх, доромжлол, халдлага, заналхийлэл, хэт ойр дотно байх болон бусад зохисгүй гэж үзэх зан байдал гаргах ёсгүй.

5.5. Шүүгч нь шүүхээр хянагдаж байгаа хэргийн хувьд хуульд заасны дагуу ач холбогдолтой, хуулийн дагуу өмгөөллийн зүйл, хэсэг болохоос бусад тохиолдолд шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа хуульчдаас хэрэгт хамааралгүй үндэслэлээр үг хэл, үйл хөдлөлөөрөө шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүй байхыг шаардана.

ТАЙЛБАР

Хуульчийн арьс өнгөөр ялгаварлах, хүйсээр гадуурхах зэрэг бусад зохисгүй байдлаар биеэ авч явахаас сэргийлэх үүрэг

191. Шүүгч нь шүүхийн танхимд болон өөрийн байгаа газарт хуульчдад хандаж, хүйсээр буюу арьс өнгөөр ялгаварлах, доромжлох, бусад зохисгүй хэлбэрээр сэтгэгдлээ илэрхийлэхгүй байхыг ойлгомжтойгоор сануулна. Мөн зохисгүй байдлаар, далд утгаар илэрхийлсэн хэл яриа, дохио зангаа, эс үйлдэхүй бүхий сэтгэгдлийг хориглоно. Энэ нь нэхэмжлэл, гомдолд дурдсан хүйс, арьсны өнгө, бусад төстэй хүчин зүйлтэй холбоотойгоор шүүхийн өмнө зохих өмгөөлөл хийх, мэдүүлэг өгөхийг хязгаарлахгүй. Анхааралтай буюу тууштай сонсох нь шүүгчийн ерөнхий үүрэг хэдий ч, тэгш байдал, таатай уур амьсгалыг хадгалах шаардлага гарвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдааны танхимд дэг сахиулна. Энэ арга хэмжээ нь тухайн нөхцөл байдлаас хамаарна. Заримдаа эелдгээр залруулах нь хангалттай байдаг. Гэхдээ зорилготой буюу түрэмгий үйлдлийг зогсоохын тулд, нэмэлт арга хэмжээ авах шаардлага гардаг. Анхааруулсны дараа, хуульч ёс зүйгүй үйлдлээ дахин

давтах буюу хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг үл хүндэтгэвэл, шүүгч хуралдааныг тусгайлан чиглүүлэх, хувийн сануулга өгөх, тэмдэглэлд тусгаж сануулах зэргээр хуулиар зөвшөөрсөн арга хэмжээг авна.

ҮНЭТ ЗҮЙЛ 6: УР ЧАДВАР БА ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛТЭЙ БАЙДАЛ

Зарчим:

Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэх угтвар нөхцөл нь шүүгч ур чадвартай, хичээл зүтгэлтэй байх явдал мөн.

ТАЙЛБАР

Ур чадвар

192. Шүүхийн үүргийг хэрэгжүүлэх ур чадвартай байхын тулд эрх зүйн мэдлэг, туршлага, нарийн мэргэшсэн байдал, бэлтгэл шаардлагатай. Шүүгчийн мэргэжлийн ур чадвар нь, түүний албан үүргээ хэр гүйцэтгэж буй байдлаар тодорхойлогдоно. Шүүгч мансууруулах бодис, согтууруулах ундаа буюу сэтгэц, бие махбодын хэвийн байдлыг алдагдуулах бусад зүйлийг хэрэглэх үед түүний ур чадвар буурч, доройтно. Цөөн тохиолдолд, ур чадваргүй байдал нь хангалттай туршлагагүй, хувь хүний зан авирын асуудалтай байдал буюу шүүгчийн албан үүргийг гүйцэтгэхэд тохиромжгүй этгээдийг шүүгчээр томилсноос, шүүн таслах ажиллагааг гүйцэтгэхэд тохиромжгүй гэдэг нь илэрхий этгээдээс илэрдэг. Зарим тохиолдолд, эрх зүйн чадамжгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй болсноос ур чадваргүй байдал илэрдэг. Үүнд ганц л шийдэл бий. Энэ нь тухайн шүүгчийг Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн дагуу албан үүргээс нь чөлөөлөх арга хэмжээ юм.

Хичээл зүтгэл

193. Эрүүл ухаанаар хандаж, төвийг сахиж шийдвэрлэх, шуурхай байх нь шүүхийн хичээл зүтгэлийн бүх тал юм. Хичээл зүтгэлтэй байдалд төвийг сахихыг хичээх, хуулийг чанд сахиулах, шүүхийн процессыг урвуулан ашиглахаас сэргийлэх зэрэг хамаарна. Шүүгч мэргэжлийн үүргээ хичээл зүтгэлтэй гүйцэтгэх чадвар нь ажлын ачаалал, зохих нөөц (үүнд дэмжлэг үзүүлэх ажилтнууд, техникийн туслалцаа багтана), судлах, нягтлах, бичих цаг хугацаа болон шүүх хуралдаанаас бусад үеийн шүүхийн үүргээс хамаардаг.

Амралт, гэр бүлийн амьдралын хамаарал

194. Шүүгч нь бусдын адил гэр бүлдээ үүрэг хариуцлага хүлээх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Шүүгч нь биеийн болон сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах хангалттай хугацаа төдийгүй, шүүн таслах ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх бодит бололцоогоор хангагдах ёстой. Шүүгчийн ажил стресс ихтэй ажил гэдэг нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн зүйл юм. Шаардлагатай үед, шүүгч стрессээс ангижрахын тулд зөвлөгөө авах, засал хийлгэх хэрэгтэй. Өмнө нь шүүгч, хуульчид иймэрхүү төрлийн зөвлөгөө, эмчилгээнээс татгалзах, хайхрамжгүй хандах хандлагатай байсан. Сүүлийн үеийн эмпирик судалгаа болон шүүх дэх сэтгэл хямралын хэд хэдэн тохиолдлоос харахад энэ асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй байна.⁵⁴

⁵⁴ M.D. Kirby, "Judicial Stress: An Update", (1997) 71 *Australian Law Journal* 774, at 791.

6.1. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нь шүүгчийн нэн тэргүүний үүрэг юм.

ТАЙЛБАР

Шүүгчийн нэн тэргүүний үүрэг нь шүүхэд ажиллах

195. Шүүгчийн нэн тэргүүний үүрэг нь шүүх эрх мэдлийг зохих ёсоор хэрэгжүүлэх, үүнтэй холбоотойгоор хууль хэрэглээ, тайлбар шаардлагатай хэргүүдийг хэлэлцэх, шийдвэрлэх асуудал юм. Засгийн газрын зүгээс шүүгчийг шүүхийн үйл ажиллагаанаас гадуур үүрэг гүйцэтгэхийг илэрхийлсэн тохиолдолд, албан үүргээс гадуурх ажиллагаанд оролцох нь бусад шүүгчдэд дарамт учруулахгүй, шүүхийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй гэдэгт баталгаа гаргах үүднээс, ерөнхий шүүгч болон шүүхийн бусад хамтран ажиллагсадтай зөвлөлдөхгүйгээр ийм үйл ажиллагаанд оролцож болохгүй. Шүүгчийн албан үүргийг гүйцэтгэхэд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал шүүхээс гадуурх үйл ажиллагаанд хэт анхаарал хандуулахыг шаардсан аливаа санал санаачилгыг шүүгч эсэргүүцэх ёстой. Цалин, урамшуулалтай тохиолдолд, тийм үйл ажиллагаанд бусдын зүгээс онцгой анхаарал хандуулах эрсдэл өндөр байх нь ойлгомжтой. Энэ нь шүүгч албан ёсны орлогоо нэмэгдүүлэхийн тулд шүүхээс гадуурх үйл ажиллагаанд оролцсон гэж ухаалаг ажиглагчид хардахад хүргэдэг. Шүүх эрх мэдлийн байгууллага бол олон нийтэд үйлчилдэг байгууллага бөгөөд өрсөлдөөнт зах зээлийн эдийн засгийн аж ахуйн нэгж биш юм.

6.2. Шүүгч нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа, шүүхэд шүүн таслах ажиллагаа, түүнтэй холбоотой үүрэг гүйцэтгэх, шийдвэр гаргах болон тэдгээртээ холбоотой бусад асуудалд анхаарал хандуулах зэргээр шүүгчийн албан үүргээ гүйцэтгэхэд зориулна.

ТАЙЛБАР

Шүүхээр мэргэшсэн байх шаардлага

196. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэхээс гадна, зарим захиргааны гэж хэлдэг ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг. Шүүгч нь өөрийн шүүх, шүүхийн захиргааг үр нөлөөтэй байлгах хариуцлага хүлээдэг. Үүнд хэргийн удирдлага (хэргийг шуурхай хуваарилах зэрэг), хэргийн бүртгэл, хөрөнгийн удирдлага, шүүхийн ажилтнуудад тавих хяналт хамаарна. Шүүгч нь хэрэг хуваарилах, мониторинг хийх ажиллагаанд хайнга хандвал, үр ашиггүй зардал ихсэж, шүүхийн үйл ажиллагаа доголдоход хүргэдэг. Иймд, шүүгч нь шүүхээр мэргэшсэн, ур чадвартай байж, шүүхийн албан хаагчдын захиргааны үйл ажиллагааны гүйцэтгэлд тус дэм нэмэр болох учиртай.⁵⁵

Шүүхийн бичиг баримт, бүртгэл

197. Шүүгч нь шүүхийн бичиг баримт, хэргийн бүртгэл алдагдах, нуун дарагдахаас сэргийлэх бүх шаардлагатай, үндэслэл бүхий арга хэмжээг авах үүрэгтэй. Энэ хүрээнд, шүүхийн бичиг баримт, бүртгэлийг цахимжуулж болно. Мөн шүүгч нь алдагдсан болон алга болох магадлалтай шүүхийн хавтаст хэргийг шалган тогтоодог тогтолцоог бий болгох хэрэгтэй. Хэрэв гэмт хэрэг үйлдэгдсэн гэх үндэслэл бүхий

⁵⁵ See “Principles of Conduct for Court Personnel”, *Report of the Fourth Meeting of the Judicial Integrity Group, 27-28 October 2005, Vienna, Austria*, Annex A, at www.unodc.org/pdf/corruption/publication_jig4.pdf

сэжиг байвал алдагдсан хавтаст хэрэг дээр тусгай шалгалтын ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Учир нь, иймхүү зөрчил шүүгийн ноцтой алдаанд тооцогддог. Шүүхийн бичиг баримт алдагдсан тохиолдолд бичиг баримтыг дахин сэргээх, тийнхүү алагдахаас сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг нэн даруй авдаг тогтолцоог бий болгох нь зүйтэй.

Шүүхийн бусад зардал

198. Шүүхийн албан хаагчдаас хавтаст хэрэг хүргүүлэх, шүүхийн зарлан дуудах хуудас олгох, хүргэх, нотлох баримтын хуулбар гаргаж өгөх, батлан даалтад авах, шүүхийн шийдвэрийн баталгаажсан хувийг бэлдэх, хэргийн судалгаа шинжилгээ хийх, хойшлуулах, алдагдсан хавтаст хэргийг дахин сэргээх, хуралдааны тохиромжтой хугацааг товлох зэрэгт шаардагддаг шүүхийн бусад зардлын асуудалд шүүгч нь дараах зүйлийг харгалзан үзнэ:

- 1) Дээрх ажиллагааны шүүхийн зардлын талаар гомдол гаргах журмыг танилцуулсан мэдээлэл гаргаж, шүүхийн байранд болон шүүхийн зардлыг эсэргүүцэж буй холбогдох этгээдүүд харах боломжтой бусад газарт байрлуулах;
- 2) Шүүхийн бусад зардалд хяналт шалгалт хийдэг тогтолцоог бий болгож, шүүхийн хяналтын албаны болон хэрэглэгчийн төлөөлөлтэй хамтарсан хороо байгуулж ажиллах;
- 3) Шүүх хуралдааны тов, шүүхийн баримт бичгүүдийг цахимжуулах;
- 4) Шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх хэрэгт бэлтгэхэд шаардлагатай хууль зүйн үе шат бүрийн хугацааны хязгаарыг танилцуулах;
- 5) Шүүхээс олон нийт, иргэдийн гомдолд шуурхай, үр дүнтэй хариу өгөх нөхцөлийг бүрдүүлэх.

6.3. Шүүгч нь өөрийн мэдлэг, ур чадвар, хувийн чанарыг дээшлүүлэх, сайжруулах зохих арга хэмжээг тухай бүр авах бөгөөд энэ зорилгоор шүүгчийн албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалт, бусад арга хэрэгслийг зохих ёсоор бүтээлчээр ашиглана.

ТАЙЛБАР

Шүүгч болгон мэргэшүүлэх боломжийг ашигладаг байх үүрэгтэй

199. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь шүүгчийн эрхийг эдлэхээс гадна, шүүхийн албан үүргээ мэргэжлийн түвшинд, хичээнгүй гүйцэтгэх ёс зүйн хариуцлагыг шаарддаг. Энэ нь шүүгч мэргэшсэн чадвартай байх ёстой бөгөөд тэрхүү чадвараа өөрийгөө мэргэшүүлэх замаар олж авах, эзэмших, байнга хөгжүүлэх ёстой гэсэн үг юм. Шүүгч нь албан үүргээ хангалттай хэмжээнд гүйцэтгэхийн тулд, юун түрүүнд өөрийн мэргэжлийн туршлагад тохирсон нарийвчилсан, гүнзгийрүүлсэн, төрөл бүрийн сургалтад хамрагдах зайлшгүй шаардлагатай. Зөвхөн материаллаг болон процессын хуулийн үзэл санааг бус, бодит амьдрал дээрх хууль, шүүхийн нөлөөллийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай юм.

200. Шүүгч нь хууль зүйн мэргэжлийн салбараасаа гадна, нийгмийн чухал асуудлын хүрээг сайн мэддэг, өргөн, гүнзгий мэдлэгтэй байх нь шүүх тогтолцоонд итгэх иргэдийн байр суурийг бэхжүүлдэг. Мөн шүүгч нь хувь хүнийхээ хувьд ур чадвартай, ойлголцолд хүргэж чаддаг (шүүх хурлын танхимд болон гадуур) байх нь зүй ёсоор, мэдрэмжтэйгээр хэрэг шийдвэрлэх, хэргийн оролцогч нартай харилцах боломжийг

олгодог. Товчоор хэлбэл, сургалтын арга хэмжээ нь шүүхийн үйл ажиллагаа бодитой, шударга, чадварлаг явагдах үндэс бөгөөд шүүгчийг зүй бус нөлөөллөөс хамгаалдаг. Иймээс өнөө үед шүүгчид хүйс, арьсны өнгө, уугуул соёл, олон янзын шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, ХДХВ/ДОХ-ын байдал, хөгжлийн бэрхшээл зэрэг эмзэг асуудлыг хөндсөн уулзалт, сургалтад хамрагдаж байна. Өмнө нь шүүгчид иймэрхүү мэдээллийг хуульчийн өдөр тутмын үйл ажиллагаанаас олж авдаг байв. Нөгөө талаас ийм төрлийн сургалт нь эмзэг бүлэг болон нийгмийн цөөнхийн төлөөлөлд шүүгчдэд асуудлаа шууд ярих боломж олгодогт үнэ цэн нь орших бөгөөд дараа асуудал гарахад тэдэнтэй ойлголцох бололцоо бүхий арга хэрэгсэл, мэдээллийг шүүгч олж авдагт оршино.

201. Шүүгч нь мэргэжлийн замналаа эхлүүлэхдээ, ихэвчлэн их дээд сургууль төгсөн бөгөөд хамгийн туршлагатай, шилдэг хуульч нарын дундаас сонгогдсон байх нь зүй ёсны шаардлага. “Сайн хуульч тааруу шүүгч болж болдогтой адил тааруу хуульч сайн шүүгч байх боломжтой. Шүүхийн шийдвэрийн чанар, шүүгчийн биеэ авч явах байдал нь хууль судалснаас хавь илүү чухал зүйл юм”.⁵⁶

Шүүгчийн сургалтын хөтөлбөрийн агуулга

202. Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаа нь залуу шинэ боловсон хүчин болон туршлагатай хуульчдын аль алиных нь хувьд шинэ мэргэшил бөгөөд үүнд нэн ялангуяа шүүгчийн мэргэжлийн ёс зүй, шүүхийн үйл ажиллагааг хүндэтгэх, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүн бүртэй харилцах харилцаа зэрэг олон талын тухайлсан хандлага хамаардаг. Шинэ албан хаагчийн мэргэжлийн туршлагын түвшнээс хамаарч, зөвхөн шүүгчийн хэрэг шийдвэрлэх арга

⁵⁶ Sir Robert Megarry VC, ‘The Anatomy of Judicial Appointment: Change But Not Decay’, The Leon Ladner Lecture for 1984, 19:1 *University of British Columbia Law Review*, 113 at 114.

техникийг заах бус нийгмийн ухамсрын хэрэгцээ шаардлага, нийгмийн амьдралын нарийн түвэгтэй байдлын талаарх олон янзын өргөн ойлголтуудыг үүнд хамааруулан үзэх ёстой. Нөгөө талаас, сургалтын хөтөлбөрийг зүй ёсоор хэрэгжүүлэхийн тулд түүнд тохирсон нэмэлт тусгай онцлог бүхий аргуудыг авч үзэх нь чухал. Туршлагатай хуульч шинээр мэргэшихэд шаардлагатай зүйлд л суралцах нь зүйтэй. Шүүхийн процедур, нотлох баримтын эрх зүй, шүүгчид шаардлагатай ердийн дэг журам зэргийн талаар бүрэн мэдлэгтэй байж болно. Гэвч, тэрээр хэзээ ч ХДХВ/ДОХ-ын халдвартай хүнтэй уулзаж байгаагүй, тийм хүнд шаардлагатай эрх зүйн болон бусад хэрэгцээг бодож үзээгүй байх боломжтой. Энэ утгаараа, шүүх эрх мэдлийн байнгын боловсрол нь нээлттэй зүйл юм. Хэдийгээр жишгийн эрх зүйн шүүхийн тогтолцоонд харьцангуй шинэ зүйл боловч, туршлагаас үзвэл шүүх өөрөө дээр дурдсан зүйлстэй холбоотой туршлагаа хуваалцвал шинэхэн шүүгчдэд маш ач тустай төдийгүй шүүгчийн хувьд амжилттай байх сайн үндэс суурь болох боломжтой.

Бүх шатны шүүгчийг мэргэшүүлэх сургалт

203. Шүүгч нь шүүгчийн албан үүргийг гүйцэтгэж эхлэхэд шаардагддаг суурь мэдлэгээс гадна, томилогдсоны дараа байнга суралцаж, судалгаа хийдэг байх ёстой. Ийм сургалт нь хууль тогтоомж, техник, ирээдүйн байнгын өөрчлөлтийн улмаас явагдах шаардлагатай бөгөөд, ихэнх улсад шүүгчид нь шинэ албан тушаалд томилогдоход шинэ үүрэг хариуцлага хүлээдэг. Иймд, мэргэшүүлэх хөтөлбөрийг ажил мэргэжил солигдох үед, тухайлбал эрүүгийн болон иргэний шүүх хооронд буюу, хэрэг хооронд шилжих, дагнасан шүүхэд орох (гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх шүүх гэх мэт), шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилогдох зэрэг үед явуулах ёстой. Үргэлжилсэн сургалтын боломж нь

бүх шатны шүүгчид нээлттэй байх ёстой. Боломжтой бол, янз бүрийн түвшний төлөөлөгчид нэг хуралдаанд хамт оролцож, хэт хатуу шаталсан хандлагыг бууруулахад хувь нэмрээ оруулах талаар үзэл бодлоо солилцож, бүх шатны шүүгчид асуудлаа харилцан хуваалцаж, шүүх эрх мэдлийн үйлчилгээнд илүү дөхөм, тохиромжтой хандлагыг дэвшүүлэх боломжтой.

Шүүгчийн сургалтыг шүүх хариуцна

204. Тухайн улс өөрөө буюу шаардлагатай бол олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр зохих нөөцөөр хангах, зардал гаргах үүрэгтэй бол, шүүх өөрөө шүүгчийн сургалтыг зохион байгуулах, удирдах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд шүүхийн сургалтад голлох үүрэгтэй байна. Улс болгон энэхүү үүрэг Хууль зүйн яам юм уу хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад бус, шүүхэд өөрт нь юм уу, шүүхийн үйлчилгээний комисс зэрэг өөр бие даасан байгууллагад итгэн хүлээлгэдэг. Мөн шүүгчдийн холбоо нь шүүгчийг тогтмол сургалтад хамруулахад чухал үүрэгтэй. Орчин үеийн нийгэмд, шүүгч нь өдөр бүр үүсэж буй бүх төрлийн асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байх ёстой. Шүүгч нь түүний давтан сургалтад хамрагдах хэрэгцээнд мэдээллийн тогтолцоон дахь технологийн өөрчлөлт чухал үүрэгтэй гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Сургалт явуулах эрх бүхий байгууллага нь сахилгын болон томилдог эрх бүхий байгууллагаас тусдаа байна

205. Чиг үүргийг зохимжтой байлгахын тулд шүүгчийг сургах үүрэгтэй байгууллага нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэдэг, томилдог, дэвшүүлдэг байгууллагаас тусдаа байх ёстой. Шүүхийн эрх бүхий байгууллага буюу бусад бие даасан байгууллага нь сургалтын үйл ажиллагааг өөрийн төсөвтэйгөөр, шүүгчидтэй зөвлөлдөн сургалтын хөтөлбөр боловсруулж,

хэрэгжүүлнэ. Сургалтыг тухайн салбарт мэргэшсэн шүүгчид, мэргэжилтнүүд удирдан явуулах нь чухал. Сургалт хариуцсан байгууллага нь сургагч багшийг мэдлэг, боловсрол, мэргэшсэн байдал болон тухайн сэдвийг эзэмшсэн байдал, заах ур чадварыг нь үндэслэн шилж сонгоно.

6.4. Шүүгч нь хүний эрхийн талаарх хэм хэмжээ тогтоосон олон улсын гэрээ, конвенц, баримт бичиг зэрэг олон улсын эрх зүйн хөгжлийн талаар зохих мэдээлэлтэй байхыг эрмэлзэнэ.

ТАЙЛБАР

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн хамаарал

206. Хувь хүн болон улс хоорондын харилцаанд болон нийгэм өөрөө илүү олон улсын шинж чанартай болж, олон улсын эрх зүйн хамаарал өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан шүүгчид олгогдсон эрх мэдлийг гагцхүү үндэсний хууль тогтоомжийн хүрээнд бус орчин үеийн ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчмуудад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна. Тухайн улсын эрх зүйн аливаа шаардлага, шүүгчийн чиг үүргийн шинж чанараас хамаарч олон улсын хууль тогтоомж, тэр дундаа олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, олон улсын зан заншлын хэм хэмжээ, олон улсын гэрээ буюу бүс нутгийн хүний эрхийн конвенцүүдийг мөрдөхгүй байж болохгүй. Шүүгчийн үүрэг хариуцлагын энэхүү нэн чухал талыг нэмэгдүүлэхийн тулд, шинэ шүүгчдэд зориулсан анхан шатны болон мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт хүний эрхийн эрх зүйн судалгааг багтааж, шүүгчийн зүгээс дотоодын эрх зүйгээр зөвшөөрсөн хүрээнд, олон улсын эрх зүйг өдөр тутмын ажилдаа бүрэн хэмжээгээр хэрэглэх практик арга замыг таниулах нь зүйтэй юм.

6.5. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг үр бүтээлтэй, шударгаар, аль болох хурдан шуурхай шийдвэр гаргахад чиглүүлнэ.

ТАЙЛБАР

Маргааныг цаг тухайд нь шийдвэрлэх үүрэг

207. Шүүгч нь гарсан хэрэг, маргааныг талуудын эрхийг харгалзан үзсэний үндсэн дээр шаардлагагүй илүү зардал гаргалгүйгээр буюу хойшлуулалгүйгээр, үр ашигтай, шударга, түргэн шуурхай шийдвэрлэх үүрэгтэй. Шүүгч нь шаардлагагүй илүү зардал гаргахгүй байх, ажиллагааг удаашруулах, хойшлуулахыг бууруулах, арилгах үүднээс хэргийг хяналтандаа байлгах үүрэгтэй. Шүүгч нь хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэхийг эрмэлзэж, тус аргыг дэмжих хэрэгтэй боловч, оролцогч талуудад шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх эрхээсээ албадан татгалзсан мэт мэдрэмж төрүүлэх ёсгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч бүрийг тэвчээртэй, шударгаар сонсох үүрэг нь шүүх хэргийг цаг тухайд нь, шуурхай шийдвэрлэх үүрэгтэй зөрчилдөхгүй. Шүүгч нь тайван, тэвчээртэй байснаар үр ашигтай, ажил хэрэгч байж чадна.

Тасралтгүй байх үүрэг

208. Шүүх хэргийг шуурхай шийдвэрлэх явдал нь шүүгчийг шүүхийн албан хаагч, хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч нарыг шүүгчтэй хамтран ажиллахыг шаардах, хэрэг шийдвэрлэгдэж дуустал хэргийг хойшлуулахгүй, тасралтгүйгээр хэлэлцэж шийдвэрлэхийг шүүгчээс шаарддаг. Тохиромжгүй буюу бодит бусаар товлосон цаг нь хугацаанаасаа хоцроход хүргэж, шүүхийн талаар сөрөг сэтгэгдлийг бий

болгоно. Иймд шүүгч нь шүүхийн үйл ажиллагааг шуурхай явуулахаас гадна, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар тогтоосон болон хүлээгдэж буй хуралдааны цагийг хатуу мөрдөх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэрийг хойшлуулалгүйгээр хүргүүлэх үүрэг

209. Шүүгч нь ажлын бусад үүрэг даалгавар, хэргийн хугацаа, нарийн түвэгтэй байдал зэрэг яаралтай болон бусад онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэж, гаргасан шийдвэрээ аль болох хурдан хүргүүлэх үүрэгтэй. Ялангуяа шалтгаангүй хоцроохгүйгээр шүүгч нь шийдвэрийн үндэслэлээ хэвлэмэл байдлаар хүргүүлэх үүрэгтэй.

Ил тод байдлын ач холбогдол

210. Шүүгч нь өмгөөлөгч болон хэргийн оролцогчид, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл авах ил тод байдлын тогтолцоог бий болгох үүрэгтэй. Шүүхээс өмгөөлөгч буюу өөрийгөө өмгөөлж буй хэргийн оролцогчдод хоцроож болзошгүй шийдвэрийн талаар тэмдэглэлээр /албан ёсоор/ ил тод мэдэгдэх үүрэгтэй. Тийм тэмдэглэл үйлдэх нь шүүхийн шийдвэрийг хоцроож гаргасан үндэслэлийг ил тод болгодог бөгөөд талууд ноцтой хохирол учруулж байна гэж үзвэл холбогдох байгууллагад гомдол гаргах боломжоор хангах учиртай юм.

6.6. Шүүгч нь шүүх дэх бүхий л шүүх хуралдааныг зохистой, хэв журамд нийцүүлэн явуулах бөгөөд хэргийн оролцогч талууд, шүүхийн иргэдийн төлөөлөгч, гэрч, хуульч болон шүүгчийн албан үүргийн дагуу харьцаж буй бусад хүнтэй хүлээцтэй, хүндэтгэлтэй, эелдэг, анхааралтай харьцана. Мөн шүүгч нь түүний хамаарал, чиг үүрэг, хяналтад байдаг бусад хүнийг ийм байдлаар бусадтай харьцаж байхыг шаардана.

ТАЙЛБАР

Шүүгчийн чиг үүрэг

211. Шүүгчийн чиг үүргийг нэгэн ахлах шүүгчийн зүгээс дараах байдлаар дүгнэсэн байна:⁵⁷

Шүүгчийн хувьд, нотлох баримтыг шинжилж, тодорхойгүй буюу анзаараагүй үлдсэн зүйл байгаа тохиолдолд, тодруулах шаардлагатай гэвэл гэрчүүдээс гагцхүү өөрөө асуулт асуух, бусад оролцогчийн зүй зохистой зан байдал гаргаж, хуулиа дагаж мөрдөж байгаа эсэхийг харах, хэрэгт хамааралгүй зүйлийг арилгах, давтагдан гарахаас сэргийлэх; өмгөөлөгчийн гаргасан санал, тайлбарыг үнэлэх, эцэст нь оюун ухаандаа үнэнийг тогтоох явдал юм. Үүнээс хэтэрвэл, шүүгч нь шүүгчийн нөмрөгөө тайлж өмгөөлөгчийн хурмийг өмсөх хэрэгтэй бөгөөд өөрчлөлт сайнаар нөлөөлөхгүй. Бидний жишиг ийм билээ.

Шүүхэд дэг, хэв журам сахиулах үүрэг

212. “Дэг” гэж шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь түүнийг зохицуулсан дүрмийн дагуу тасралтгүй, эерэг

⁵⁷ *Jones v. National Coal Board*, Court of Appeal of England and Wales [1957] 2 QB p.55 at p.64, per Lord Denning.

уур амьсгалтай явагдах баталгааны төвшинг илэрхийлнэ. “Хэв журам” гэж шүүхээс хэргийг хуулийн дагуу хүлээн авч шударгаар хянан хэлэлцэн шийдвэрлэхэд хэргийн оролцогчид болон олон нийт шүүх тухайн хэрэг анхааралтай, чин сэтгэлээсээ хандаж байна гэсэн уур амьсгалыг бүрдүүлэхийг хэлнэ. Хувь шүүгчийн хувьд түүний өмнө зогсож байгаа хуульч, оролцогчдын зан байдал, хэл яриа, хувцаслалтын зохистой байдлын талаар ялгаатай үзэл, стандарттай байх нь бий. Нэг шүүгчийн хувьд зохисгүй байдал гэж ойлгогдож буй зүйл, өөр нэг шүүгчийн хувьд зохистой харагдаж болно. Мөн, зарим шүүн таслах ажиллагаа илүү албан ёсны байдлыг шаарддаг. Иймд, шүүхийн танхим дахь тухайн цаг хугацааны “дэг”, “хэв журам”-ын талаар олон янзын илрэл байх нь гарцаагүй зүйл юм. “Дэг”, “хэв журам”-ын талаар нэгдмэл стандарт тогтоох нь боломжгүй зүйл юм. Харин нэн шаардлагатай зүйл бол шүүгч шүүхэд дэг, хэв журмыг сахиулах үүрэг хүлээх явдал юм. Ингэснээр, шүүхийн үйл ажиллагаа хэвийн, шударга явагдах нөхцөл бүрдэх бөгөөд хуульч, хэргийн оролцогчид, олон нийт шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй, шударга явагдана гэх итгэх итгэл үнэмшил төрүүлдэг.

Хэргийн оролцогчдод хандах хандлага

213. Шүүгчийн зан байдал нь түүний үнэн шударга байдлыг харуулахад нэн чухал юм. Зүй бус зан байдал нь ялгаварлал, хайхрамжгүй байдлыг илэрхийлж, шүүгчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Хэргийн оролцогчид хүндэтгэлгүй хандах нь түүний үг хэлэх эрхийг зөрчиж байгаа мэт харагдуулахаас гадна шүүх хуралдааны танхимын хэв журам болон эрхэм чанарыг гутаадаг. Боловсон харилцааны соёлын дутагдал нь мөн хэргээ шийдвэрлүүлэх хэргийн оролцогчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг бөгөөд энэ нь ерөнхийдөө шүүхийн талаар сөрөг үнэлэмжийг бий болгодог.

Хуульчдад хандах хандлага

214. Шүүгч нь уур хилэнгээ өөртөө барих ёстой. Ямар ч өдөөн хатгалгыг үл харгалзан шүүгчийн хариу үйлдэл ухаалаг байх учиртай. Хуульч бүдүүлэг харьцаа гаргасан ч, түүнийг нь хайхралгүйгээр шүүх хуралдааныг зохих арга хэлбэрээр зохион байгуулах үүрэгтэй. Анхааруулга хийсээр байтал бүдүүлэг харьцаа хэвээр үргэлжлэх тохиолдолд, шүүх хуралдаанаас тусдаа шийдвэр гаргах байдлаар холбогдох арга хэмжээг авах нь зүйтэй. Харин үндэслэлгүйгээр хуульчийг дахин дахин босгох, түүний тайлбар, үйлдлийг тохуурхсан, дээрэнгүй байдлаар хүлээн авах зэрэг эсрэг үйлдлийг шүүгчийн зүгээс хэзээ ч гаргаж болохгүй. Нөгөө талаас ямар ч шүүгч бусад шүүгч, өмгөөлөгч, оролцогч талууд болон гэрчүүдэд хандсан доромжлол, маргаанд хамааралгүй илэрхий тайлбар зэргийг зүгээр сонсоод сууж болохгүй.

Эелдэг, хүлээцтэй байдал, эрхэм чанар зайлшгүй шаардлагатай

215. Шүүхэд болон шүүх хуралдааны танхимд шүүгч нь ямагт хэн бүхний эрхэм чанарыг хүндэтгэж, эелдэг байх учиртай. Шүүгч нь мөн шүүхэд ирсэн хэн бүхнээс болон түүний удирдлагад ажилладаг бусад этгээд болон шүүхийн албан хаагчдаас тийм байдлыг шаарддаг байх ёстой. Шүүгч нь хувийн өс хонзонгоос гадуур байж, шүүхэд хүрэлцэн ирсэн өмгөөлөгч, хуульчдад хувийн сонирхлоор хандаж болохгүй. Хуульчийн шударга бус шүүмжлэл, хэргийн оролцогч буюу гэрчүүдийн талаар доромж үг хэлэх, бүдүүлэг хошигнол, ёжлол, шүүгчийн гаргаж буй зүй бус үйлдэл зэрэг нь шүүхийн дэг, хэв журмын аль алинд сөргөөр нөлөөлдөг. Шүүгч нь хөндлөнгөөс оролцохдоо, тэрхүү үйлдэл нь үл ялгаварлах, шударга байдал хийгээд шударга байдлын ойлголтод сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт баталгаа байх ёстой.

6.7. Шүүгч нь шүүх эрх мэдлийг зохистойгоор хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд оролцож болохгүй.

ТАЙЛБАР

Шүүх хэргийг шударга, эрх тэгш хуваарилах

216. Хэрэг хуваарилах үүрэгтэй шүүгч нь хэргийн үр дагаварт хамааралтай аливаа этгээд, хэргийн аль нэг талын хүсэлтэд автах ёсгүй. Хуваарилалтыг тойргоор болон цагаан толгойн үсгийн дарааллаар, бусад төстэй аргаар хийж болдог. Эсвэл шүүхийн ажиллагааг удирддаг ерөнхий шүүгч бусад шүүгчтэй зөвлөлдсөний үндсэн дээр тус чиг үүргийг шударга үнэнчээр гүйцэтгэх ёстой. Шаардлагатай тохиолдолд тодорхой хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзсан хуваарилалт хийж болох боловч, хэргийн хуваарилалт нь аль болох шүүхийн бүх гишүүдэд тоон болон чанарын хувьд эн тэнцүү бөгөөд бүх шүүгч нарт ил тод байх ёстой.

Шүүгч хэргээс татгалзан гарах

217. Ашиг сонирхлын зөрчил, ноцтой өвчин зэрэг үндэслэл бүхий шалтгаангүйгээр, хэргээс тухайн шүүгчийг татгалзан гаргаж болохгүй. Шүүгчийг татгалзан гаргах аливаа тийм үндэслэл журмыг хууль буюу шүүхийн журмаар зохицуулах ёстой. Шүүхийн чиг үүргийн гүйцэтгэлийг хангах үүднээс олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, хуульд нийцсэн үйлдэл хийхээс бусдаар гадаадын бусад эрх мэдэл, гүйцэтгэх засаглалаас аливаа байдлаар шүүгчид нөлөөлөх ёсгүй.

Бусад шүүгч буюу хуульчийн мэргэжлийн бус үйлдэлд хандах хандлага

218. Бусад шүүгч буюу хуульч мэргэжлийн бус үйлдэл гаргасан байж болзошгүй талаар баталгаатай нотлох баримтыг шүүгч мэдсэн бол холбогдох арга хэмжээг авах ёстой. Холбогдох арга хэмжээ гэдэгт зөрчил үйлдэж байгаа болон үйлдэх нь батлагдсан шүүгч буюу өмгөөлөгчийн үйлдлийг боломжтой бол таслан зогсоох, зохих албан ёсны байгууллагад зөрчлийг мэдэгдэх зэрэг шууд үйлдэл хамаарна.

Шүүхийн ажилтныг буруугаар ашиглах

219. Шүүхийн ажилтан болон тоног төхөөрөмжийг зохисгүй байдлаар ашиглах нь шүүхийн ажилтныг маш хүнд нөхцөл байдалд оруулсан, шүүх эрх мэдлийг урвуулан ашигласан явдалд тооцогддог. Шүүхийн ажилтан нь шүүхэд тогтсон дэг жаягт нийцэхгүй, зохисгүй, хэт хувийн үйлчилгээ үзүүлэх ёсгүй.

ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Эдгээр зарчмыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл тухайн орны шүүхийн тогтолцоонд байхгүй бол, үндэсний шүүхүүд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн зарчмын дагуу дээрх зарчмуудыг хэрэгжүүлэх үр өгөөжтэй арга хэрэгслийг бий болгох арга хэмжээг батламжилна.

ТАЙЛБАР

Бангалорын зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх журам

220. Шүүхийн шударга байдлын бүлэг Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх журмын талаар мэдээлэл бэлтгэхээр ажиллаж байна. Эдгээр зарчмуудын нэгэн адил, тэдгээрийг хэрэгжүүлэх журам нь аливаа үндэсний шүүхийн хувьд, заавал дагаж мөрдөх зүйл биш. Иймд тухайн журмыг удирдамж, жишиг болгон ашиглаж болно.

ЗАРЧМУУДЫН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Эдгээр зарчмын үг хэллэгийн агуулга нь өөрөөр ойлгож хэрэглэх боломж бий болгосон, эсхүл тийм шаардлагыг бий болгосноос бусад тохиолдолд, зарчмуудын дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Шүүхийн ажилтан” гэж шүүгчийн туслах болон шүүхийн захиргааны ажилтнуудыг ойлгоно.

“Шүүгч” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээр томилогдсон буюу сонгогдсон хүнийг ойлгоно.

“Шүүгчийн гэр бүлийн гишүүн” гэж шүүгчийн эхнэр/нөхөр, хүү, охин, хүргэн, бэр болон төрөл садан, түүнчлэн шүүгчийн гэрт амьдардаг хүн, шүүгчийн хамтрагч, ажилтан, найз нөхдийг ойлгоно.

“Шүүгчийн эхнэр/нөхөр” гэж шүүгчтэй гэр бүлийн харьцаатай хүн, түүнчлэн шүүгчтэй хувийн дотно харьцаатай ямар ч хүйсийн хүнийг ойлгоно.

ТАЙЛБАР

Шүүгчийн гэр бүлийн гишүүн

221. “Шүүгчийн гэр бүлийн гишүүн” гэх тодорхойлолт дахь “шүүгчийн гэрт амьдардаг” гэх тодотголд зөвхөн “шүүгчийн аливаа ойр дотны хамаатан болон шүүгчийн хамтрагч, ажилтан, найз нөхөд”-д хамааруулсан бөгөөд, шүүгчийн эхнэр/нөхөр, хүү, охин, бэр, хүргэнд хамаарахгүй.

НОМ ЗҮЙ

Ном, нэг сэдэвт зохиол

Amerasinghe, A.R.B., *Judicial Conduct Ethics and Responsibilities*, Colombo, Sri Lanka, 2002.

Shaman, Jeffrey, Lubet, Steven and Alfini, James, *Judicial Conduct and Ethics*, 3rd ed., Virginia, U.S.A., 2000.

Thomas, J.B., *Judicial Ethics in Australia*, Sydney, Australia, 1988.

Wood, David, *Judicial Ethics: A Discussion Paper*, Victoria, Australia, 1996.

Стандарт, тайлангууд

American Bar Association, *Model Code of Judicial Conduct*, preliminary draft, 2005.

Arab Centre for the Independence of the judiciary and the Legal Profession, *Beirut Declaration for Justice*, 1999.

Australian Bar Association, *Charter of Judicial Independence*, 2004.

Australian Institute of Judicial Administration Incorporated, *Guide to Judicial Conduct*, 2002.

Canadian Judicial Council, *Commentaries on Judicial Conduct*, Quebec, 1991.

Canadian Judicial Council, *Ethical Principles for Judges*, 1998.

Canadian Judicial Council, *Model Policy on Equality within the Court*, 1998.

Consultative Council of European Judges:

Opinion No.9 PROV (2006): The Role of National Judges in Ensuring an Effective Application of International and European Law;

Opinion No.7 (2005): Justice and Society;

Opinion No.6 (2004): Fair Trial within a Reasonable Time;

- Opinion No.4 (2003): Appropriate Initial and In-Service Training for Judges at National and European Levels;
- Opinion No.3 (2002): Principles and Rules governing Judges' Professional Conduct, in particular Ethics, Incompatible Behaviour and Impartiality;
- Opinion No.2 (2001): Funding and Management of Courts with reference to the Efficiency of the Judiciary and to Article 6 of the European Convention on Human Rights;
- Opinion No.1 (2001): Standards concerning the Independence of the Judiciary and the Irremovability of Judges.
- Hong Kong Special Administrative Region of China, *Guide to Judicial Conduct*, 2004.
- IFES, *Global Best Practices: Judicial Integrity Standards and Consensus Principles*, 2004.
- International Association of Judges, *The Universal Charter of the Judge*, 1999.
- International Centre for Ethics, Justice and Public Life, *Toward the Development of Ethics Guidelines for International Courts*, Report of a workshop held at the Brandeis Institute for International Judges, Salzburg, Austria, 2003.
- International Commission of Jurists, *International Principles on the Independence and Accountability of Judges, Lawyers and Prosecutors*, Geneva, 2004.
- Judicial Ethics in South Africa*, issued by the Chief Justice, President of the Constitutional Court, Judges Presidents of the High Courts and the Labour Appeal Court, and the President of the Land Claims Court, 2000.
- Madrid Principles on the Relationship between the Media and Judicial Independence, 1994.
- Suva Statement of Principles on Judicial Independence and Access to Justice, 2004.

Шүүхийн ёс зүйн зөвлөлдөх хорооны зөвлөмжүүд

Дараах хороо, байгууллагын зөвлөх саналууд:

The United States Judicial Conference;

Alabama Judicial Inquiry Commission;

Alaska Commission on Judicial Conduct;

Arizona Judicial Ethics Advisory Committee;

Arkansas Judicial Ethics Advisory Committee;

Colorado Judicial Ethics Board;

Delaware Judicial Ethics Advisory Committee;

Florida Judicial Ethics Advisory Committee;

Georgia Judicial Qualifications Commission;

Illinois Judicial Ethics Committee;

Indiana Commission on Judicial Qualifications;

Kansas Judicial Ethics Advisory Committee;

Ethics committee of the Kentucky Judiciary;

Maryland Judicial Ethics Committee;

Massachusetts Supreme Judicial Court Committee on Judicial Ethics;

Nebraska Ethics Advisory Committee;

Nevada Standing Committee on Judicial Ethics;

New Hampshire Advisory Committee on judicial Ethics;

New Mexico Advisory Committee on the Code of Judicial Conduct;

New York Advisory Committee on Judicial Ethics;

Oklahoma Judicial Ethics Advisory Panels;

Pennsylvania Conference of State Trial Judges Judicial Ethics
Committee;

South Carolina Advisory Committee on Standards of judicial Conduct;

Tennessee Judicial Ethics Committee;

Texas Committee on Judicial Ethics;

Utah Judicial Ethics Advisory Committee;

Vermont Judicial Ethics Committee;
Virginia Judicial Ethics Advisory Committee;
Washington Ethics Advisory Committee;
West Virginia Judicial Investigation Commission;
Wisconsin Supreme Court Judicial Conduct Advisory Committee.

ТЭМДЭГЛЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН